УДИРДЛАГЫН АКАДЕМИ

# ТӨЛӨӨЛЛИЙН АРДЧИЛЛЫН ЭРХ ЗҮЙН СУУРЬ ЗАРЧМУУД, ТЭДГЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ИРГЭДИЙН ҮНЭЛГЭЭ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

012

Улаанбаатар хот
2018 он

# ТӨЛӨӨЛЛИЙН АРДЧИЛЛЫН ЭРХ ЗҮЙН СУУРЬ ЗАРЧМУУД, ТЭДГЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ИРГЭДИЙН ҮНЭЛГЭЭ

Энэхүү бүтээлийн зохиогчийн эрхийг хуулийн дагуу хамгаалсан болно. Бүтээлийг бүтнээр буюу хэсэгчлэн хувилах, нийтлэх, электрон системд оруулах болон бусад ямар нэг хэлбэрээр олшруулахыг хориглоно.

**СУДАЛГААНЫ БАГ:**

**Удирдагч:**

| | |
|---|---|
| О.Цэрэнчимэд | Удирдлагын академийн Бодлого, улс төр судлалын тэнхимийн эрхлэгч, доктор |

**Зөвлөх:**

| | |
|---|---|
| Г.Чулуунбаатар | Удирдлагын академийн Бодлого, улс төр судлалын тэнхимийн багш, доктор, профессор, академич |

**Судлаачид:**

| | |
|---|---|
| С.Зулпхар | Удирдлагын академийн захирал, доктор, профессор |
| Ч.Энхбаатар | Удирдлагын академийн Эрх зүйн тэнхимийн эрхлэгч, доктор, профессор |
| П.Доржсүрэн | Удирдлагын академийн Бодлого, улс төр судлалын тэнхимийн багш, доктор, профессор |
| Ё.Батсүх | Удирдлагын академийн Бодлого, улс төр судлалын тэнхимийн багш, магистр |
| Д.Намхайдагва | Удирдлагын академийн Бодлого, улс төр судлалын тэнхимийн багш, магистр |

"Мөнхийн Үсэг" ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв.

# АГУУЛГА

**ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ .......... IV**
**ЗУРГИЙН ЖАГСААЛТ .......... VI**
**ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ .......... VIII**
**ӨМНӨХ ҮГ .......... IX**

**НЭГ. УДИРТГАЛ .......... 1**
1.1. Судалгааны асуудал .......... 1
1.2. Судалгааны асуулт .......... 3
1.3. Судалгааны зорилго .......... 3
1.4. Судалгааны зорилт .......... 3

**ХОЁР. СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ .......... 4**
2.1. Ардчиллын тухай ойлголт, ангилал .......... 4
2.2. Төлөөллийн ардчиллын үзэл баримтлал .......... 5
2.3. Монгол Улсад төлөөллийн ардчиллыг судалсан байдал .......... 7
2.4. Ардчиллын хэрэгжилт, чанарыг судлах онол, арга зүй .......... 10

**ГУРАВ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ .......... 19**
3.1. Контент шинжилгээ .......... 20
3.2. Асуулгын арга .......... 21

**ДӨРӨВ. СУДАЛГААНЫ ӨГӨГДӨЛ БОЛОВСРУУЛАЛТ .......... 24**
4.1. Контент шинжилгээний өгөгдөл боловсруулалт .......... 24
4.2. Асуулгын судалгааны өгөгдөл боловсруулалт .......... 35

**ТАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН .......... 60**

**ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ .......... 66**

**ХАВСРАЛТ .......... 69**

# ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Ардчилал, ардчилсан засаглалын төлөв байдлын талаарх судалгааны дүн (2005, 2008, 2010 онууд, 5 баллын шкалаар) ........ 8
Хүснэгт 2. Асуулгын найдвартай байдлын түвшин ........ 36
Хүснэгт 3. Судалгаанд оролцогчдын холбогдох хуулиудын талаарх мэдлэгийн түвшин (хувиар) ........ 42
Хүснэгт 4. Ардчиллын талаарх ойлголтын түвшинг үнэлэх шалгуур үзүүлэлт ........ 45
Хүснэгт 5. Судалгаанд оролцогчдын төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмуудын талаарх өөрийн ойлголтын төсөөлөл, түүний эрэмбэ (дундаж утгаар) ........ 46
Хүснэгт 6. Судалгаанд оролцогчдын төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмуудын хэрэгжилтийн өнөөгийн байдлын талаарх ойлголтын төсөөлөл, түүний эрэмбэ (дундаж утгаар) ........ 47
Хүснэгт 7. Судалгаанд оролцогчдын ардчиллын эрх зүйн суурь зарчмуудын талаарх өөрийн ойлголт, суурь зарчмуудын хэрэгжилтийн өнөөгийн байдлын талаарх төсөөллийн үнэлгээний эрэмбэ, харьцуулалт /дундаж утгаар, 3 ба 9 дэд шалгуур үзүүлэлтээр/ ........ 48
Хүснэгт 8. Судалгаанд оролцогчдын төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмуудын талаарх өөрийн ойлголт, суурь зарчмуудын хэрэгжилтийн өнөөгийн байдлын талаарх төсөөллийн үнэлгээний эрэмбэ, харьцуулалт /дундаж утгаар, 19 дэд үзүүлэлтээр/ ........ 49
Хүснэгт 9. Судалгаанд оролцогчдын төрийн байгууллагуудын үйл ажиллагааны хэрэгжилтийн өнөөгийн байдлын талаарх төсөөлөл, эрэмбэ ........ 51
Хүснэгт 10. Сургалтад хамрагдагсдын төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмуудын талаарх өөрийн ойлголтын төсөөллийн харьцуулалт /сургалтын өмнөх болон дараах байдлаар, дундаж утгаар/ ........ 55

Хүснэгт 11. Сургалтад хамрагдагсдын төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмуудын хэрэгжилтийн өнөөгийн байдлын талаарх ойлголтын төсөөллийн харьцуулалт /сургалтын өмнөх болон дараах байдлаар, дундаж утгаар/ ....... 56

Хүснэгт 12. Сургалтад хамрагдагсдын төрийн байгууллагуудын үйл ажиллагааны хэрэгжилтийн өнөөгийн байдлын талаарх ойлголтын төсөөллийн харьцуулалт /сургалтын өмнөх болон дараах байдлаар, дундаж утгаар/...................................... 57

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ


Зураг 1. Ардчиллын барометрийн үзэл баримтлалын агуулга ... 12
Зураг 2. Ардчиллын барометрийн шалгуур үзүүлэлтийн үзэл баримтлалын эх үндэс ... 12
Зураг 3. Морлиногийн ардчиллын чанарын тухай үзэл баримтлал ... 16
Зураг 4. Судалгааны арга зүйн тойм зураглал ... 20
Зураг 5. Төлөөллийн ардчиллын талаарх иргэдийн төсөөллийг хэмжих үзүүлэлт ... 22
Зураг 6. Монгол Улсын төрийн байгуулал ... 25
Зураг 7. Монгол Улсын парламентын засаглалын онцлог ... 26
Зураг 8. УИХ ба төлөөллийн зарчим ... 29
Зураг 9. Төрийн байгуулал дахь эрх мэдлийн хуваарилалт ... 31
Зураг 10. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тогтолцоо ... 33
Зураг 11. Судалгаанд оролцогчдын нас (хувиар) ... 37
Зураг 12. Судалгаанд оролцогчдын хүйс (хувиар) ... 37
Зураг 13. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин (хувиар) ... 38
Зураг 14. Судалгаанд оролцогчдын оршин суугаа газар (хувиар) ... 39
Зураг 15. Судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлтийн байдал (хувиар) ... 39
Зураг 16. Судалгаанд оролцогчдын ам бүлийн тоо (хувиар) ... 40
Зураг 17. Судалгаанд оролцогчдын өрхийн сарын дундаж орлого (хувиар) ... 40
Зураг 18. Судалгаанд оролцогчдын шашин шүтлэгийн байдал (хувиар) ... 41
Зураг 19. Судалгаанд оролцогчдын ардчиллын нөлөөллийн талаарх төсөөлөл (хувиар) ... 43
Зураг 20. Судалгаанд оролцогчдын ардчиллын хөгжлийн талаарх төсөөлөл (хувиар) ... 44
Зураг 21. Төлөөллийн ардчиллын суурь зарчмуудын тухай ойлголт, хэрэгжилтийн түвшний үнэлгээ (9-н дэд үзүүлэлтээр) ... 52

Зураг 22. Финлянд, АНУ /1995, 2005 он/ болон Монгол улсын иргэдийн ардчиллын талаарх ойлголтын түвшний харьцуулалт /2018 он/ ........ 53

Зураг 23. Сургалтанд хамрагдагсдын ардчиллын талаарх ойлголтын түвшин, хэрэгжилтийн талаарх төсөөллийн үнэлгээний харьцуулалт (сургалтын өмнөх болон дараах байдлаар, дундаж утгаар) ........ 58

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| АНУ | Америкийн Нэгдсэн Улс |
| НӨУБ | Нутгийн өөрөө удирдах байгууллага |
| НҮБ | Нэгдсэн үндэстний байгууллага |
| НҮБХХ | Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр |
| УИХ | Улсын Их Хурал |
| УИХТГ | Улсын Их Хурлын Тамгын газар |
| ҮСГ | Үндэсний статистикийн газар |
| ҮХ | Үндсэн хууль |
| ҮХЦ | Үндсэн хуулийн цэц |
| ХБНГУ | Холбооны Бүгд Найрамдах Герман улс |
| ШУА | Шинжлэх ухааны академи |
| ФСЭХ | Философи, социологи, эрхийн хүрээлэн |
| IDEA | Institute for democracy and electoral assistance |
| UNDP | United Nations Development Programme |

## ӨМНӨХ ҮГ

Удирдлагын Академийн Бодлого, Улс төр судлалын тэнхимийн судалгааны баг "Төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмууд, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх иргэдийн үнэлгээ" сэдэвт судалгааны тайлангаа уншигч Танд толилуулж байна.

Монгол Улс 1990 онд дэлхий дахинаа өрнөсөн "Ардчиллын гурав дахь давалгаа"-ны үр дүнд нэг намын тогтолцоо бүхий улс төрийн авторитар дэглэмээс олон намын тогтолцоо бүхий ардчилсан улс төрийн дэглэмд тайван замаар шилжсэн түүхтэй. Энэхүү шилжилт нийгэм, эдийн засаг, улс төрийн орчныг бүхэлд нь хамарсан байдаг. Ардчиллын эхэн үед улс орнууд ижил төстэй байдлаар улс төр, эдийн засгийн гараагаа эхэлж байсан бол харин ардчиллын гурав дахь давалгааны үед нөхцөл байдал ихээхэн өөрчлөгдсөн байсан.

Зөвхөн Монгол улсын хэмжээнд төдийгүй дэлхий дахинд төлөөллийн ардчилал нь томоохон сорилтуудтай тулгарч, энэхүү бий болсон хүндрэлтэй нөхцөл байдлаас гарах арга замыг онол, практикийн түвшинд судлан тодорхойлохоор улс орнууд идэвхийлэн ажиллаж байна. Энэхүү эрэл хайгуулын хүрээнд Freedom House, НҮБХХ, Amnesty International, Дэлхийн банк, IDEA зэрэг байгууллага болон Роберт Даль, Леонардо Морлино, Марк Бульманн зэрэг судлаачид тодорхой үзэл баримтлал, арга, аргачлалыг боловсруулсан байдаг. Эдгээр судлаачдын арга зүй нь ардчилсан дэглэмтэй байгааг тодорхойлохоос илүүтэй ардчиллын үндсэн агуулга болох "иргэний эрх чөлөө" баталгаажсан эсэх, нийгмийн харилцаан дахь "иргэний тэгш эрх" хуулиар тодорхойлогдсон эсэх, улс төрийн шийдвэр "иргэдийн бодит оролцоотой" байгаа эсэх, улс төрийн хүрээнд гаргасан шийдвэр "иргэдийн хяналттай" байгаа эсэхийг голчлон анхаардаг. Өөрөөр хэлбэл, иргэдийн ардчиллын мөн чанарыг ойлгож, ухамсарласан байдал нь ардчиллын хөгжилд тэргүүлэх ач холбогдолтой гэсэн санаа юм.

Удирдлагын академийн судалгааны баг дээрх үзэл баримтлалд тулгуурлан Монгол улс дахь төлөөллийн ардчиллын үзэл баримтлалын суурь зарчим, тэдгээрийг эрх зүйн хүрээнд тодорхойлсон байдал, төлөөллийн ардчиллын зарчмуудын хэрэгжилтийн талаарх үнэлгээг иргэдийн ойлголт, төсөөллөөр тодорхойлох зорилгоор энэхүү судалгааг гүйцэтгэсэн болно.

Уг судалгааны ажлыг хийх боломжийг олгосон Удирдлагын Академийн Эрдэмийн Зөвлөл, Үндэсний статистикийн газар болон бусад хамтран ажилласан хүмүүст судалгааны багийн өмнөөс талархаж байгаагаа илэрхийлэхийг хүсэж байна. Уншигч та бүхэн судалгааны тайланг шимтэн

уншиж, санал зөвлөгөө харамгүй өгнө гэдэгт гүнээ итгэж байна. Та бүхэн санал, шүүмж, зөвлөгөөгөө Удирдлагын Академийн Бодлого, Улс төр судлалын тэнхимд tserenchimed@naog.gov.mn цахим хаягаар эсвэл 70135535 утсаар холбоо барьж ирүүлнэ үү!

Судалгааны багийн ахлагч
доктор О. Цэрэнчимэд

# 1. УДИРТГАЛ

## 1.1. Судалгааны асуудал

Монголын ард түмэн 1992 онд *"хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм"* цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгосон шинэ Үндсэн хуулиа баталж парламентын бүгд найрамдах улс гэдгээ тунхагласан билээ. Энэ үзэл санааныхаа дагуу "Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ"(Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 1 дүгээр заалт) хэмээн төлөөллийн ардчиллын зарчимд үндэслэсэн төрийн байгууллын тогтолцоог бүрдүүлэн хөгжүүлсэн юм. Энэ замаар хөгжсөн 30 шахам жилд Монгол Улс алдаа оноо, туршлага сургамжийг хослуулсан ээдрээтэй замын туулжээ.

Төлөөллийн ардчилал манай улсын хэмжээнд төдийгүй дэлхий дахинд томоохон сорилтуудтай тулгарч бий болсон хүндрэлтэй нөхцөл байдлаас гарах арга замыг онолын хувьд ч, практик түвшинд ч судлан тодорхойлох талаар идэвхтэй ажиллаж байна. Иймээс Удирдлагын академийн захиалгат судалгааны баг парламентад ёсны онцлогийг тодруулж, Монгол дахь төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмууд, тэдгээрийн хэрэгжилтийг "Төр-Иргэн" хоорондын харилцааны эргэх холбоогоор дамжуулан судалдаг олон улсын нийтлэг арга зүйг үндэслэн Үндсэн хуулийн үзэл баримтлалын хүрээнд судлав.

Төлөөллийн ардчилал бол парламентат ёсны суурь үзэл санаа, төлөвшиж хөгжих үндсэн зарчим юм гэсэн үзэл баримтлал ардчиллын тухай судалгааны бараг бүх онол, сургаалд нийтлэг бий. Тухайлбал, АНУ-ын Ерөнхийлөгч Абрахам Линкольн 1863 онд ардчиллыг "Ардчилал нь иргэдийн эрхийг хамгаалсан, иргэдийн оролцоонд суурилсан, ард түмний засаглал" буюу *"Democracy is the government of the people, by the people, and for the people"* гэж тодорхойлсон байдаг. Өөрөөр хэлбэл ардчилал ард түмний засаглал байх ёстой. Иймд засгийн бүх эрх ард түмний мэдэлд байх *(government of the people)*; засгийн эрх ард түмний мэдэлд байгаа баталгаа нь иргэдийн оролцоо, хяналттай байх *(government by the people) зарчмаар баталгаажиж,* улс төрийн шийдвэрүүд иргэдийн эрх ашиг, сонирхлыг төлөөлж байх *(government for the people) зарчим буюу* үзэл баримтлал болж цэгцэрсэн байдаг. Түүнчлэн төлөөллийн ардчиллын тогтолцооны мөн чанарыг манай улсын судлаачид "Ардчилал бол эрх зүйт төрийг тогтоох, хүний эрхийг хамгаалахаас илүү гүн агуулгатай..., эрх мэдлийг зөв ашиглах, зөрчилдөөнийг зохицуулах тухай асуудал"... хэмээн тодорхойлжээ (ШУА-ийн ФЭЗХ, 2017, х.5).

Ийм суурь үзэл баримтлалыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд Монгол Улс дахь төлөөллийн ардчиллыг Үндсэн хуулийн эрх зүй, төрийн байгуулал, хүний эрхийн хэрэгжилтийн талаар өмнө нь хийгдсэн судалгаанд тал бүрээс нь судалсан байдаг. Бидний хувьд төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмууд, тэдгээрийн хэрэгжилтийг иргэд хэрхэн ойлгож, хэрхэн дүгнэж байгааг доор дурдсан үндсэн асуулт бүрээр тодруулахыг **судалгааны асуудал** болгон тодорхойллоо. Тухайлбал:

1). Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн үзэл баримтлалд төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмуудыг хэрхэн тусгасан тухай,

2). Монгол Улсын төрийн байгуулалд төрийн эрх мэдлийн хуваарилалт, засаглалын тухай,

3). Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд хэрхэн тусгасан тухай.

Монгол улсад өмнө хийгдсэн судалгаанд бага хөндөгдсөн "Төр-Иргэн" хоорондын харилцааг тойрсон, ардчилал-засаглалын эрх зүйн орчны зохицуулалтын хүрээнээс бидний судалгааны **үндсэн асуултууд** урган гарсан болно.

Өнөөдрийн Монгол Улсын парламентын засаглал дахь сорилт бэрхшээлүүд 1992 оны Үндсэн хуулийн үзэл баримтлалын улбаатай, бодитой болохыг зарим судлаачид онцолдог (Амаржаргал, 2018, p. 13). Үндсэн хуулийг өөрчлөх зорилгоор үе үеийн УИХ-ын гишүүдийн санаачилга гаргаж байсныг судалгааны ажлын хэсгийн дүгнэлтүүд тодруулж байна (Улсын Их Хурлын Тамгын газар, 2016, p. 201) Тийм ч учраас төлөөллийн ардчилалд учирч буй сорилт бэрхшээлийг тухайн ард түмний түүх, соёл уламжлалтай холбон тайлбарлах, иргэдийн улс төрийн ойлголтын түвшинг тодорхойлох, улс төрийн оролцооны төрөл, хэлбэрийг төрийн тогтолцоогоор нь тайлбарлах, тэр дундаа "Төр-Иргэн" хоорондын харилцааны соёлын түвшинг ардчиллын хэрэгжилтээр судлах ёстой гэсэн үзэл санааг судалгаанд дэвшүүлсэн болно. Үүнтэй уялдуулан олон улсын судлаачдын дэвшүүлсэн судалгааны тодорхой арга зүйгээр Монгол Улсын "Төр-Иргэн" хоорондын харилцааг тодруулах, өнөөгийн төлөөллийн ардчилал дахь сорилт, бэрхшээлийг судалж, онол практикийн шийдлийг санал болгоход судалгааны ач холбогдол оршиж байна. Чингэхдээ арга зүйн хувьд ардчилсан хөгжлийн суурь бол ард түмэн засгийн эрхийг барих сонголтын эрх чөлөөтэй байх, засаглалын эрхийг хянах бололцоогоор хангагдсан байх, иргэний тэгш оролцоотой байх гэсэн зарчмуудын хэрэгжилтэд голлон анхаарч байгаагаараа өмнөх судалгаануудаас шинэлэг болно.

## 1.2. Судалгааны асуулт

Судалгааны хүрээнд судлах зүйлийг тодорхой болгож дэвшүүлсэн зорилго, зорилтыг хангах үүднээс судалгааг дараах асуултуудад чиглүүлсэн. Үүнд:

1. Монгол Улс төрийн байгууламд *"иргэний эрх чөлөө, хяналт, тэгш эрх"*-ийн зарчмыг хэрхэн хуульчилсан байна вэ?
2. Төрийн байгуулал дахь институцийн үйл ажиллагаанд *"иргэний эрх чөлөө, хяналт, тэгш эрх"*-ийн зарчмыг хэрхэн уялдуулсан байна вэ?
3. 1992 оноос хойш төлөөллийн ардчиллын *"иргэний эрх чөлөө, хяналт, тэгш эрх"*-ийн зарчмуудыг Монгол Улсын иргэд хэрхэн ойлгож ирсэн бэ?

## 1.3. Судалгааны зорилго

Энэхүү судалгааны зорилго нь Л.Морлиногийн ардчиллын чанарын үнэлгээ, Freedom House-ийн ардчиллын индекс, жишиг стандартыг харгалзан Марк Бульманны ардчиллын барометрийн арга зүй, аргачиллыг үндэслэн Монгол улс дахь төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмуудын хэрэгжилтийн талаарх үнэлгээг иргэдийн ойлголт, төсөөллөөр тодорхойлоход оршино.

## 1.4. Судалгааны зорилт

Энэхүү зорилгын хүрээнд дараах зорилтыг дэвшүүлсэн. Үүнд:

- Төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмууд, тэдгээрийн хэрэгжилтийг үнэлэх арга зүйг боловсруулах,
- Монгол Улсын төрийн байгуулал дахь институцийн эрх зүйн зохицуулалтад баримт бичгийн контент шинжилгээ хийх,
- Монгол Улс дахь төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчим, түүний хэрэгжилтийн талаарх иргэдийн ойлголт, төсөөллийг санал асуулгын аргаар судлах,
- Контент шинжилгээ болон санал асуулгын судалгааны дүнг үндэслэн Монгол Улс дахь төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмуудын хэрэгжилтэд үнэлгээ өгөх.

# 2. СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ

## 2.1. Ардчиллын тухай ойлголт, ангилал

Ардчиллыг түүхэн үүсэл талаас нь авч үзвэл “ард түмний засаглал” хэмээн тодорхойлж болно (ШУА-ийн Философийн хүрээлэн, 2017, p. 5). Төрийн эрх мэдлийн хуваарилалт, засаглалыг хэрэгжүүлэх явц дахь хяналтын тогтолцоо зэрэг нь улс төрийн дэглэмийн хэлбэрийг тодорхойлогч хэмжүүр болдог. Энэхүү хэмжүүрийг Үндсэн хуульд тусгасан байдал, эрх зүйн зохицуулалтаар хэмжих тул “Үндсэн хуульт ардчилсан төр” гэсэн ойлголт XX зуунд дэлгэрсэн байдаг. Энэ ойлголтод эрх мэдлийн субъект бол ард түмэн хэмээн Монгол Улсын Үндсэн хуулийн гуравдугаар зүйлийн нэгдүгээр заалтад тусгаснаар төрийн байгууллын суурь үзэл баримтлал манай орны практикт хэрэгжиж эхэлсэн билээ.

Ард түмний халдашгүй байдал нь аливаа асуудлыг шийдэхэд баримтлах тулгуур зарчим байх бөгөөд бүрэн эрх (sovereignty/Jean Bodin,1529-1596) хэмээх ойлголтоор тодорхойлогддог (ШУА-ийн Философийн хүрээлэн, 2017, p. 8) 1990 оны дараах ардчиллын гурав дахь давалгааны явцад дэлхийн тусгаар улсуудын ихэнх хэсэг нь ардчилсан дэглэмийг хөгжлийн замнал болгон сонгожээ.

Ардчилсан засаглал олон улсын хэмжээнд нийгэм, эдийн засаг, улс төрийн хөгжлийг тодорхойлогч хүчин зүйл болох тутам ардчиллын хэлбэр, загвар, хөгжлийн түвшний ялгаа зэрэг асуудлыг судлах шаардлага гардаг. Энэ чиглэлд Тухайлбал, либерал ардчилал (liberal), бүгд найрамдах ардчилал (republican), зөвлөлдөх ардчилал (deliberative), олон түмний ардчилал (mass), тоталитар ардчилал (totalitair), сонгодог ардчилал (classic), олон ургалч ардчилал (plural), шууд ардчилал (direct), төлөөллийн ардчилал (representative), олонхийн ардчилал (majoritarian), зөвшилцлийн ардчилал (consensus), өрсөлдөөний ардчилал (competetive) зэрэг ардчиллын хэлбэр төрлүүдийг авч үздэг (ФСЭХ, 2017, х.11). Тухайлбал, ардчилал дахь иргэдийн оролцооны хэв маягаар нь: а) Шууд ардчилал, б) Хамтын шийдлийн ардчилал (plebiscitedemocracy), в) Төлөөллийн ардчилал; мөн иргэдийн оролцооны цар хүрээ, хэмжээний байдлаар нь а) Хүчтэй ардчилал, б) Сул ардчилал гэж ангилсан байдаг. Өөрөөр хэлбэл тухайн улс дахь төлөөллийн ардчилал хүчтэй эсвэл сул байх нь тухайн төрийн байгуулал, төрийн эрх мэдлийг хуваарилсан байдал, засаглал дахь иргэдийн оролцооны төрөл, хэлбэр болон улс төрийн шийдвэрт тавих иргэдийн хяналтаас хамаардаг байна.

Төлөөллийн ардчилал нь парламентын болон ерөнхийлөгчийн засаглалын аль алинд нь байдаг гол хэлбэр юм. Төлөөллийн ардчилал олон сул талтай гэдгийг судлаачид тэмдэглэсээр байна. Тухайлбал, Роберт Михельс “Улс төрийн намууд” бүтээлдээ төлөөллийн тогтолцоон дахь улс төрийн нам, гишүүдийн оролцооны сул болон давуу талыг онцолсон байдаг (Robert, Michels, 1911).

Иргэдийн улс төрийн оролцооны төлөв байдал нь ардчиллын чанарыг тодорхойлно гэж Р.Даль үзэж, өөрийн бүтээлдээ “нээлттэй, өрсөлдөөнт, иргэдийн оролцоог хангасан нийгмийн тогтолцоог” полиарх ардчилал гэж нэрлэсэн. Габриэл Алмонд, Сиднэй Верба нар “Иргэний соёл” (Gabriel Almond and Sidney Verba, 1963) бүтээлдээ улс төрийн оролцооны төрөл, хэлбэрийг ангилан хөгжүүлэхийн зэрэгцээ улс төрийн соёл нь иргэдийн улс төрийн боловсрол, түүхэн уламжлал, нийгмийн хөгжлийн түвшин болон нийгмийн тогтолцоон дахь оролцооны төрөл зүйлээс хамааралтай гэсэн үзэл санаа дэвшүүлсэн байдаг (Жаргал, Ж. Сарангэрэл, Л, 2018, p. 187). Улс төрийн соёлын *(“politische kultur”)* тухай ойлголт нь германы судлаач Гердерийн тодорхойлолтоос эхтэй байдаг (Жаргал, Ж. Сарангэрэл, Л, 2018, p. 180). Энэ ч утгаараа төлөөллийн ардчилал дахь парламентат ёсны тухай ойлголт нь угтаа иргэний нийтлэг эрх ашгийг тэгш хийгээд шударга хамгаалах нь төрийн үүрэг байх бөгөөд төрийн үйл ажиллагаа иргэдийн оролцоотой, хяналттай байснаар ард түмний эрх чөлөөний баталгаа болох хууль хэрэгждэг байх тухай үзэл санаа юм.

## 2.2. Төлөөллийн ардчиллын үзэл баримтлал

Төрт улс ардчиллыг хэрхэн хэрэгжүүлэх нь тухайн улсын дотоод асуудал юм. Зарим судлаачид ардчиллын хэрэгжилт тухайн төрийн байгууллын тогтолцооны асуудал хэмээн үзэж, төлөөллийн болон шууд ардчиллын институцийг судалгааны асуудал болгон судалдаг. Зарим судлаачид нь төрийн байгууллын тогтолцооноос шууд хамааралгүй, ардчиллын хэрэгжилт гагцхүү иргэдийн тэгш оролцоотой байх болон улс төрийн шийдвэр иргэдийн хяналттай байхаас хамааралтай гэсэн үзэл санааг судалгааны асуудал болгон дэвшүүлдэг. Ийм чиглэлийн үзэл баримтлалын төлөөлөгч бол Марк Бульманн юм (Buehlmann, Marc (u.a.), 2012, pp. 115-159). Судлаач төлөөллийн байгууллага болох парламентын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын үндсэн зарчим нь “иргэний эрх чөлөө, тэгш эрх, иргэний хяналттай” байх нөхцөлийг бүрдүүлж чадаж байна уу гэсэн асуултыг судалгааны цөм асуудал болгон авч үзсэн.

Дэлхий дахинд 1990 оноос хойш хийгдсэн ардчиллын тухай судалгаанууд нь ардчилсан дэглэмтэй байна уу гэхээс илүүтэй ардчиллын үндсэн агуулга болох “иргэний эрх чөлөө” баталгаажсан эсэх, “иргэний тэгш эрх” нийгмийн

харилцаанд тодорхойлогдсон эсэх, мөн улс төрийн шийдвэр "иргэдийн бодит оролцоотой" байгаа эсэх, улс төрийн шийдвэр "иргэдийн хяналттай" байгаа эсэх гэсэн асуудлыг голчлон анхаардаг болжээ.

Орчин үед судлаачид дээр дурдсан үзэл баримтлалын хүрээнд ардчилсан тогтолцооны хэв шинжийг үндсэн гурван загварт хуваан судлах боломжтой гэж үзсэн байдаг (Buehlmann, Marc (u.a.), 2012, p. 117). Энэ ч утгаараа нэгдүгээрт, ардчилсан тогтолцоогоор **иргэний эрх чөлөөг хамгаалах** ойлголт байдаг. Ардчилсан тогтолцоо байгаа хэдий ч төрийн үйл ажиллагаа түүнийг хамгаалахад чиглэгдээгүй бол бодит ардчилал байх боломжгүй юм. Төлөөллийн ардчиллын тухай гол үзэл баримтлал нь бүх нийтийн чөлөөт, тэгш эрхийн зарчмын дагуу сонгуулиар төрийн байгууллалд төлөөлөгчийг сонгох явдал юм. Харин төлөөллийн байгууллагын зохион байгуулалтын тусламжтайгаар хүний эрх чөлөөг хамгаалах зорилготой үзэл санааны сонгодог төлөөлөлд Локк (1689), Монтескье (1748) нарыг нэрлэх боломжтой. Төлөөллийн ардчиллын үзэл баримтлалыг Токвиль (1835), Макс Вебер (1909) нар өөрсдийн бүтээлээр цааш нь хөгжүүлэх явцад ардчиллыг олон ургальч үзэл санаагаар Даль (1971) баяжуулсан байдаг (ШУА-ийн Философийн хүрээлэн, 2017, pp. 21-28). Учир нь аль ч ардчилсан төрийн байгууллалд эрх ашиг, сонирхлын зөрчил олонхийн саналын дагуу шийдэгдэх боломжтой хэдий ч шийдвэр цөөнхийн эрх ашгийг хамгаалж чадаж байгаа эсэх тухай асуудлыг давхар хөндсөн.

Хоёрдугаарт, ардчилал дахь хүний эрх чөлөөний үзэл баримтлалыг **олон ургальч үзэл санаагаар хамгаалахын зэрэгцээ иргэдийн бодит оролцоо**, оролцох төрөл, хэлбэр боломжийг загварчилан дэвшүүлсэн байдаг. Зарим судлаачид эрх чөлөө, тэгш эрхийн зарчим иргэдийн оролцоогоор бий болдог гэж үздэг. Улс төрийн бодит оролцоотой байж иргэд өөрсдийн асуудлыг шийдвэрлэх гэсэн үзэл баримтлалын цөм нь хувь хүний хөгжил, улс төрийн сонирхол, эрх ашиг болон нийгмийн бүлгийн сонирхлыг нэгтгэх хөдөлгүүр болдог. Уг үзэл баримтлал нь иргэний эрх чөлөөг өөрсдийнх нь тэгш эрхтэй оролцоогоор хамгаалах тухай санаа юм. Ингэснээр иргэд нийгмийн тулгамдсан асуудлын хүрээнд улс төрийн шийдвэр гаргахад оролцоотой байх тухай ойлголт юм.

Төлөөллийн ардчиллын улс төрийн шийдвэр гаргах үйл ажиллагааг иргэдийн шууд оролцоогоор хангах, иргэдийг зөвлөлдүүлэх замаар шийдвэрт оролцуулах үзэл баримтлалын анхны төлөөлөгч бол Жан Жак Руссо юм (ШУА-ийн Философийн хүрээлэн, 2017, p. 25). Руссогийн (1762) "Нийгмийн гэрээ"-ний үзэл баримтлал дахь орчин үеийн чиг хандлагын төлөөлөлд "Ардчилалд сайн дурын оролцоо"-г чухалчлах Барварын (1984) санаа, "Ардчилалд зөвлөлдөх санал асуулга" хэрэглэх Фишкиний (1991) үзэл баримтлал, "Улс төрийн диалоги" гэх Хабермасын онол зэргийг нэрлэх боломжтой. Иргэдийн сайн дурын оролцооны нэг хэлбэр нь улс төрийн намаар дамжин хэрэгждэг (ШУА-ийн Философийн хүрээлэн, 2017, pp. 73-75). Улс төрийн сонгууль нь

ил тод, нээлттэй, бүх нийтийн байхын зэрэгцээ улс төрийн оролцоог тэгш хангахад чиглэгдсэн байх ёстой. Эрх чөлөөг хамгаалах үүднээс иргэдийг тэгш оролцоотой байлгах гэсэн хандлагууд нь хүнлэг, иргэнлэг, хүмүүнлэг байх хандлагыг хэрэгжүүлэх суурь хөрс нь болох тул нийгмийн төвд хүнийг, төрийн бодлогын цөмд иргэний эрх ашиг, сонирхлыг тавьж буйн илрэл хэмээн 2017 оны ШУА-ийн ФСЭХ-ийн "Монгол Улс дахь төлөөллийн ардчилал ба иргэдийн улс төрийн оролцоо" бүтээлд онцолсон байдаг.

Гуравдугаарт, эрх чөлөөг хамгаалах чиглэлд **иргэний тэгш оролцоог** хангаад зогсохгүй тодорхой нийгмийн хөгжлийн төлөвшлийг ардчиллын үзэл баримтлалд оруулж ирсэн байдаг. Энэ утгаараа ардчилал тодорхой нийгмийн баталгаат байдлыг хангах үүрэг хүлээдэг. Тухайлбал, "нийгмийн шударга ёс", "эдийн засгийн тэгш хуваарилалт"-ын зарчим нь ардчиллын хөгжлийн тодорхой зорилт байх тухай ойлголт юм. Учир нь ардчилал зөвхөн хүний амьдрах таатай орчин байхаас илүүтэй "Төр-Иргэн" хоорондын эрх үүргийн тэнцвэртэй харилцааны тухай үзэл санаа юм (Buehlmann, Marc (u.a.), 2012, p. 118). Өөрөөр хэлбэл иргэн нь өөрийн эрх чөлөөгөө ухамсарлаж ойлгохын зэрэгцээ нийтийн эрхийн хүрээнд эрх зүйт төрийн зохицуулалт бүхий шийдвэрүүдэд хяналттай хандаж чаддаг байх тухай санаа юм. Энэ утгаар төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмын хэрэгжилтийн талаарх иргэдийн төсөөлөл өөрөө судалгааны гол хэрэглэгдэхүүн болж байна.

### 2.3. Монгол Улсад төлөөллийн ардчиллыг судалсан байдал

Монгол Улс 1990 онд ардчиллыг сонгоод эх орондоо "*хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг хөгжүүлэх*" эрхэм зорилго тавиад даруй 28 жил өнгөрч байна. Энэ хугацаанд нийгэм, эдийн засаг, улс төрийн хүрээнд өргөн цар хүрээтэй олон шинэчлэлийг эхлүүлж, ололт амжилт дэвшилд хүрэхийн зэрэгцээ ажилгүйдэл, ядуурал, авлига, төрийн хариуцлагагүй үйлдэл, нийгмийн шударга бус байдал нь даамжрах зэрэг олон сөрөг үр дагаварууд ардчиллын хөгжлийг дагалдан гарч ирсэн байдаг. Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын ардчиллын төлөв байдлыг тодруулах талаар олон улсын байгууллагын дэмжлэгтэй /IDEA, Дэлхийн банк, НҮБХХ/ олон тооны судалгаа хийгджээ.

2003 онд Монгол улсад Ардчиллыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын олон улсын V бага хурлыг амжилттай зохион байгуулж, хурлын шийдвэрийн дагуу "Ардчилсан засаглалын шалгуур үзүүлэлт" боловсруулах ажлыг эхлүүлсэн. Улмаар 2005-2006, 2007-2008, 2009-2010 онуудад ШУА-ийн ФСЭХ-ээс "Ардчилсан засаглалын төлөв байдалд гарсан өөрчлөлт" сэдэвт судалгааг гурван удаа дараалан үндэсний хэмжээнд зохион байгуулсан. Дээрх судалгаа нь Freedom House, НҮБХХ, Amnesty International, Дэлхийн банк, IDEA зэрэг байгууллагуудын аргачлалыг харьцуулан эдгээрээс IDEA (Ардчилал болон сонгуульд туслах олон улсын хүрээлэн)–ийн аргачлалын шалгуур үзүүлэлтийг үндэс болгожээ. IDEA–ийн судалгааны аргачлалын

онцлог нь төрийн шийдвэр гаргах үйл явц дахь иргэдийн хяналт болон улс төрийн тэгш эрхийг хангах нь ардчиллын мөн чанар гэж үзэж ардчиллын индексийг гаргасан байдаг (IDEA, 2017, p 4-6).

ФСЭХ-ийн дээрх цуврал гурван судалгааны хүрээнд олон нийтийн санал асуулга, экспертийн үнэлгээ, УИХ-ын гишүүдээс мэдээлэл цуглуулан харьцуулалт хийсэн байна. Тус судалгаа нь 1) Үндэстний харьяалал, хууль эрх, 2) Төлөөлөл бүхий хариуцлагатай засаг төр, 3) Иргэний нийгэм ба ард түмний оролцоо, 4) Улс орны хилийн чанад дахь ардчилал гэсэн хэсгүүдээс бүрдсэн бөгөөд цуврал гурван судалгаа тус бүр нь өмнөх судалгаанаас хойш гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлж ирснээрээ онцлогтой. Судалгааны үр дүн хэрхэн өөрчлөгдөж ирснийг доорхи хүснэгтээс ажиглаж болно.

**Хүснэгт 1. Ардчилал, ардчилсан засаглалын төлөв байдлын талаарх судалгааны дүн (2005, 2008, 2010 онууд, 5 баллын шкалаар)**

| Үнэлгээний асуулт | Үнэлгээний дундаж оноо | | | Гарсан өөрчлөлт | Гарсан өөрчлөлт |
|---|---|---|---|---|---|
| | 2005 | 2008 | 2010 | 2008-2010 | 2005-2010 |
| Үндэстний харьяалал, хууль эрх | 2.8 | 3.2 | 3.14 | 0.39 | 0.64 |
| Төлөөлөл бүхий хариуцлагатай засаг төр | 2.64 | 2.8 | 2.69 | -0.05 | 0.17 |
| Иргэний нийгэм ба ард түмний оролцоо | 2.84 | 2.93 | 2.67 | -0.10 | 0.01 |
| Улс орны хилийн чанад дахь ардчилал | 3.8 | 3.7 | 4.0 | 0.30 | 0.20 |
| Ардчилсан засаглалын ерөнхий үнэлгээ | 3.02 | 3.0 | 3.01 | 0.01 | -0.01 |

Эх сурвалж: О.Хатанболд, Ардчиллыг ойлгохуй ба судлахуй: Монголын жишээн дээр. УБ., 2017, х 136.

Энэхүү судалгааг хийхдээ эрх зүйн орчин болон олон нийтийн санаа бодолд гарсан өөрчлөлтүүдийг анхаарсан байна. Тухайлбал, төлөөлөл бүхий хариуцлагатай төр бүлэгт "сонгууль нь засгийн газар, түүний бодлогод хяналт тавих боломжийг ард түмэнд олгодог уу" гэсэн асуултад үнэлгээ өгөхдөө эрх зүйн орчинд гарсан өөрчлөлт, хуулийн хэрэгжилтэд гарсан өөрчлөлт, иргэдийн санаа бодлын судалгааг харьцуулсан юм (ФСЭХ, 2010, х. 53-61). Уг судалгааны хамгийн чухал нь нэгэн ижил асуулгыг давтан хэрэглэсэн нь хоёр жил тутам дахь ардчиллын төлөв байдлын өөрчлөлтийг дүгнэх боломжийг судлаачдад олгожээ.

ФСЭХ-гээс 2014-2016 онд "Монгол Улс дахь төлөөллийн ардчилал ба иргэдийн улс төрийн оролцоо" суурь судалгааг хийжээ. Энэхүү судалгаа нь төлөөллийн ба шууд ардчиллын хэлбэр болон иргэдийн улс төрийн оролцооны харилцан хамаарал, төлөөллийн ба шууд ардчиллыг илүү үр дүнтэй ашиглах боломж, иргэдийн улс төрийн оролцооны арга зам ба хэлбэр, загварын зохистой хувилбарыг тодруулах, хэтийн төлөв хандлагыг тодорхойлоход чиглэгдсэн (ФСЭХ, 2010, х.4). Уг судалгааны ажил нь мэргэжлийн судлаач

эрдэмтдийн хамтын бүтээл учраас онолын суурь мэдлэгт илүү түшиглэж түүнийгээ практик, олон нийтийн санаа бодлын судалгаагаар баяжуулах замаар экспертийн дүгнэлт хийсэн бүтээл юм.

Дээрх судалгааны хамрах хүрээний хувьд нэгдүгээрт, төлөөллийн ба шууд ардчиллын түүх, улс төрийн философийн үндэс, парламентат ёсыг төлөөллийн ардчиллын сонгодог хэлбэр болох тухай; хоёрдугаарт, оролцооны ардчиллын тухай орчин үеийн үзэл баримтлал, иргэний нийгэм дэх иргэдийн оролцоо, шийдвэр гаргах үйл явц дахь иргэдийн оролцоо, иргэдийн улс төрийн оролцоог боловсронгуй болгох арга зам; гуравдугаарт, нутгийн өөрөө удирдах ёс ба иргэдийн оролцоо, нутгийн удирдлагын тогтолцооны өнөөгийн төлөв байдал, чиг хандлага; дөрөвдүгээрт, төлөөллийн ба шууд ардчиллын үзэл санааны хэрэгжилтэд нөлөөлж буй хүчин зүйлс, харилцан хамаарал, шууд ардчиллын хэрэгжилтийн туршлага, сургамж, төлөөллийн ба шууд ардчиллыг төгөлдөржүүлэх боломж, гарцын тухай судалсан. Энэ утгаараа уг судалгааны ажил нь эрдэм шинжилгээний төдийгүй танин мэдэхүй, сургалт, мэдээллийн чухал хэрэглэгдэхүүн болсон байна.

Монгол Улсын хувьд ардчиллын судалгаануудад арга зүйн чиг баримжаа болсон бүтээл бол 2002 онд IDEA–аас гаргаж монгол хэлнээ орчуулсан "Ардчилалд үнэлгээ өгөх гарын авлага" юм. Тус бүтээлийн зорилго нь дэлхийн улс орнууд өөрийн ардчиллын хөгжил, төлөвшлийн түвшинг судлах боломжтой нийтлэг арга зүйг боловсруулахад чиглэсэн байдаг. Энэхүү гарын авлагад ардчиллын төлөв байдалд үнэлгээ хийхэд анхаарах дараах зөвлөмжийг өгсөн байна. Үүнд:

- Ардчиллыг үнэлэх гол зорилго нь олон нийтийн ойлголт ухамсрыг дээшлүүлэх, өөрчлөлт хийхэд нэн шаардлагатай зүйлийг тодорхойлох, эдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих
- Тухайн улсын иргэд өөрсдөө үнэлгээ хийх
- Үнэлгээний шалгуур нь товч, тодорхой ардчиллын зарчмуудаас урган гарсан байх
- Шалгуур нь ардчиллын өргөн хүрээтэй асуудлыг хамарсан, сонголт хийх боломжтой байх
- Үнэлгээ нь чанарын хувьд үнэлэгдэж тоон үзүүлэлтүүдээр баяжсан байх

Гарсан дүгнэлтийг нийтээр хүлээн зөвшөөрүүлэхийн тулд үнэлгээний үйл явцын хүрээнд үндэсний хэмжээний семинар зохион байгуулах, зөвлөлдөх зэрэг зөвлөмжийг өгсөн байна (IDEA, 2002, p. 13).

Энэхүү зөвлөмжийг "Ардчилсан засаглалын төлөв байдалд гарсан өөрчлөлт" цуврал судалгааны арга зүй болгосон байна. IDEA–ийн үнэлгээний удирдамжийн үндсэн зарчим нь ардчилсан засаглалд ард түмний хяналт байх, улс төрийн тэгш эрх байх тухай асуудал. Энэ хоёр зарчмаас ардчиллын гол шалгуурууд, үнэлгээний хүрээг гаргаж ирсэн байна. Гарын авлага бүхэлдээ

бэлтгэл ажил, эцсийн дүгнэлт, олон нийт, судлаачдын хүртээл болгох зэрэг судалгааны бүхий л үе шатыг хэрхэн зохион байгуулах тухай цогц зөвлөмж болсон байна.

2017 онд судлаач О.Хатанболд "Ардчиллыг ойлгохуй ба судлахуй: монголын жишээн дээр" бүтээл гаргажээ. Тус судалгааны бүтээлд ардчиллын талаарх монголчуудын сэтгэлгээний уламжлал ба орчин үеийн асуудлууд, ардчиллын тухай монголчуудын ойлголт төсөөлөл, Монголын ардчиллын хэрэгжилтийн өнөөгийн байдлын үнэлгээ болон тулгамдаж буй сорилт, боломжуудын тухай дэлгэрэнгүй авч үзжээ. Хатанболдын "Ардчиллыг ойлгохуй ба судлахуй: монголын жишээн дээр, 2017" бүтээлд ардчиллын сонгодог болон орчин үеийн онолын асуудал, ардчиллын хэлбэр шалгуур, олон улсын түвшинд хийгдсэн ардчиллын судалгааны арга зүй, харьцуулалтыг тодорхой авч үзсэн байна. Ардчиллын инструментал, конструктив, норматив, субстантив хэлбэр шалгуурууд, индексээр тооцох болон шкалаар хэмжих зарчмын тухай судалсан нь онол, арга зүйн чухал ач холбогдолтой болжээ.

### 2.4. Ардчиллын хэрэгжилт, чанарыг судлах онол, арга зүй

Удирдлагын академийн Бодлого, улс төр судлалын тэнхимийн гүйцэтгэсэн "Төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмууд, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх иргэдийн үнэлгээ" сэдэвт судалгаанд Роберт Далийн (1971) "Полиарх" ардчиллын үзэл баримтлал, Марк Бульманны ардчиллын барометр судалгааны арга зүй, Леонардо Морлиногийн (2004) ардчиллын чанарын үнэлгээны загварчлал, Freedom House-ийн ардчиллын индексийг зарчим, жишиг стандартад үндэслэн өөрийн орны онцлогтой тохируулан ашиглах зорилгыг дэвшүүлж хэрэгжүүлсэн болно.

Энэхүү судалгааны арга зүйн үндэс бол Далийн ардчиллын онолын үзэл баримтлал юм. Роберт Даль онолдоо нээлттэй, өрсөлдөөнт, иргэдийн оролцоог хангасан нийгмийг полиарх ардчилал гэж үзсэн байдаг. Түүний "Полиарх: оролцоо ба сөрөг хүчин" (1971), "Ардчилал ба түүнийг шүүмжлэгчид" (1989), "Ардчиллын тухай" (1998), "Улс төрийн тэгш эрхийн тухай" (2006) бүтээлүүд нь ардчиллын хэрэгжилтийг үнэлэх онолын эх сурвалж болдог.

Түүний үзлээр төгс ардчиллын үндсэн шинж нь үр дүнтэй оролцоо, шийдвэр гаргах үйл явц дахь эрх тэгш санал, мэдээлэлд тулгуурласан ойлголт, хэлэлцэхэд тавих хяналт, нийгмийн амьдрал дахь оролцоо (Robert Alan Dahl, 1998, p. 221) юм. Эдгээр шинжийг хангасан улс орон илүү төгс ардчиллын хөгжилд дөхөж очих боломжтой юм. Ардчилалд шилжсэн өндөр хөгжилтэй орнуудыг Полиарх ардчилалтай улс гэж нэрлэх ба дараах долоон институцид тулгуурлаж ардчилал үндсэн утгаараа хөгжих боломжтой юм. Үүнд: 1). Сонгогдсон түшмэд, 2). Чөлөөт шударга сонгууль, 3). Бүх нийтийн сонгох эрх, 4). Сонгуульд өрсөлдөх эрх, 5). Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө,

6). Хувилбарт мэдээллийн эх сурвалж, 7). Эвлэлдэн нэгдэх эрх чөлөө ордог байна (Robert Alan Dahl, 1998, p. 222). Далийн ардчиллын тухай дээрх үзэл баримтлал нь бидний судалгааны асуулгад тусгалаа олсноороо өмнө нь хийгдсэн ШУА-ийн ФСЭХ-ийн судалгаануудаас ялгарч байгаа бөгөөд 2002 оны IDEA-гийн ардчиллын үнэлгээний үзэл баримтлал болох үнэлгээний шалгуур нь ардчиллын зарчмуудаас урган гарсан байх шаардлагыг хангаж байгаа юм.

Судалгааны дараагийн шалгуур үзүүлэлт нь Бульманы ардчиллын барометр *(Demokratiebarometer)* юм. Ардчиллын барометр нь харьцангуй шинэ индекс бөгөөд өмнө нь хэрэглэгдэж байсан ардчиллын шалгуур үзүүлэлтүүдийн арга зүйн сул талыг нөхөхийг зорьсон байдаг. Freedom House, Polity, BTI, Ванханений ардчиллын индексүүд нь улс орнуудын ардчиллын чанарын ялгааг тодорхойлоход хэтэрхий ерөнхий, энгийн байсан учраас шинэ индексийг судлах хэрэгцээг бий болгосон юм. Ардчиллын индекс шалгуурууд нь ардчилсан болон дарангуй дэглэмтэй улс орнуудыг ялган ангилах тал дээр үзэл баримтлалын хувьд иргэдийн хяналттай байх тухай ойлголтыг ихэнхдээ орхигдуулж байсан. Анх 300 гаруй шалгуур үзүүлэлтүүдээс 105-ыг нь сонгох замаар ардчиллын барометрийг тодорхойлсон. Ардчиллын барометрийг ашиглан 1990-2014 оны хооронд дэлхийн 70 гаруй улс орныг судалсан байдаг.

Ардчиллын барометрийн үзэл баримтлалын эх үндэс нь Герман-Швейцар улсын хамтарсан судалгааны багийн ахлагч, судлаач Бульманны *(Demokratiebarometer,2012)* ардчиллын үзэл баримтлал болох улс төрийн сэтгэлгээний сонгодог үеийн төлөөлөгчид Локк, Монтескье, Милл, Токвилль нарын зэрэгцээ орчин үеийн төлөөлөгчид болох Даль (1956) "иргэдийн тэгш оролцоог хангах" тухай, Фишкинийн (1991) төлөөллийн ардчилалд "иргэдийн зөвлөлдөх санал асуулга"-ыг ашиглах замаар "иргэдийн оролцоотой, хяналттай, мэдээлэлтэй байх" зарчмыг бүрдүүлэх тухай төсөөллөөс эх үндэстэй. Энэ нь өмнөх үеийн ардчиллын судалгааны загварчлалын сул талуудыг нөхөх онцлогтой юм.

Бульманны барометрийг боловсруулах болсон дараагийн чухал үндэслэл нь ардчилал болон даяаршлын хоорондын уялдаа холбоо юм. Шүүмжлэгчид даяаршил нь өнөөгийн ардчиллын хямралын шалтгаан гэж үздэг. Харин дэмжигчид санхүүгийн нээлттэй байдал, олон улсын хамтын ажиллагаа нь ардчиллын хөгжилд эерэг нөлөөтэй гэж үздэг. Эндээс Бульманн даяаршил болон тогтвортой ардчиллын чанарын хоорондын холбоо хамаарал, нөлөөг судлахыг зорьсон байдаг.

### Зураг 1. Ардчиллын барометрийн үзэл баримтлалын агуулга




Эх сурвалж.Buehlmann, Marc; Merkel, Wolfgang;Mueller, Lisa; Giebler, Heiko; Wessels, Bernhard (2012): Demokrtaiebarometer: ein neues Instrument zur Messung von Demokratiequalitaet. In:Zeitschrift fuer Vergleichende Politikwissenschaft 6, s.123.

Өмнөх судалгаанаас ялгарах онцлог нь Ардчиллын барометрт ардчиллын суурь элементүүдийг гурван түвшинд онолын дедукци хийсэн байдаг. Үүнд: Нэгдүгээрт, ардчиллын барометрийн үндсэн гурван зарчим болох "эрх чөлөө, тэгш эрх, хяналт"-ын тухай ойлголтыг гаргаж ирсэн юм. Үндсэн санаа нь ардчилсан тогтолцоо нь эрх чөлөө болон тэгш эрхийн зөв тэнцлийг тогтоох, тэгэхдээ иргэдийн хяналтыг зайлшгүй шаарддаг гэсэн үзэл юм (Buehlmann, Marc (u.a.), 2012, p. 123). Хоёрдугаарт, уг гурван зарчим нь хувь хүний эрх чөлөө, эрх зүйт төр, нийтийн эрх, өрсөлдөөн, эрх мэдлийн хяналт-тэнцвэр, засаглах чадавх, ил тод байдал, оролцоо, төлөөлөл гэсэн өөр өөр үүргүүдээр хамгаалагдсан байх ёстой гэсэн төрийн байгууллын үзэл баримтлал юм. Эдгээр үүргүүд хэрхэн хангагдаж байгааг хэмжих арга зүйг бий болгосноор ардчиллын барометрийн мөн чанар оршдог. Гуравдугаарт, үүрэг болгон цааш хоёр хэсэгт хуваагдах ба тэр нь дэд хэсгүүдэд хуваагдан шалгуур үзүүлэлт болж чанарыг шалгах боломжтой (зураг 2).

### Зураг 2. Ардчиллын барометрийн шалгуур үзүүлэлтийн үзэл баримтлалын эх үндэс




Эх сурвалж: Buehlmann, Marc; Merkel, Wolfgang;Mueller, Lisa; Giebler, Heiko; Wessels, Bernhard (2012): Demokrtaiebarometer: ein neues Instrument zur Messung von Demokratiequalitaet. In: Zeitschrift fuer Vergleichende Politikwissenschaft 6, s.123.

Ардчиллын барометрийн эхний суурь зарчим бол эрх чөлөөний тухай ойлголт юм. Эрх чөлөө нь ямар нэгэн гадны, хөндлөнгийн этгээдийн хяналт, нөлөөллөөс ангид байхыг эрхэмлэдэг. Хувь хүний эрхийг эрх зүйт төр хуулиар хамгаалах баталгаа олгох нь ардчилсан дэглэмийн хувьд анхдагч нөхцөл болдог (David Beetham, 2004, pp. 61-75). Эрх чөлөөний тухай ойлголт нь иргэдийн хараат бус байдалтай хүчтэй хамааралтай байдаг тул иргэн бүр улс төрийн тэгш эрхээр хангагдсан тохиолдолд орших боломжтой юм. Эндээс хоёр дахь зарчим болох тэгш эрхийн тухай ойлголт гарч ирдэг. Тэгш эрхийн тухай ойлголт нь ихэвчлэн улс төрийн тэгш эрх гэсэн утгаар хэрэглэгдэх бөгөөд нэгдүгээрт, бүх иргэнийг улс төрийн үйл явцад тэгш эрхтэй оролцуулах тухай боломж (Robert Alan Dahl, 2006) хоёрдугаарт, иргэн бүр төрийн эрх барих үйл ажиллагаанд тэгш эрхтэй, шууд оролцох боломжоор хангагдсан байх (Saward Michael, 1998) бөгөөд энэхүү үйл явц хуульчлагдсан байх тухай юм. Эрх чөлөө, тэгш эрх хоёр нь харилцан бие биенээ хязгаарлах боловч хоорондоо эвлэршгүй зүйл биш. Харин эрх чөлөө болон тэгш эрхийн динамик тэнцлийг хангахын тулд ардчиллын гурав дахь зарчим болох иргэдийн хяналтын тухай ойлголт урган гарч ирдэг.

Хяналтын тухай ойлголт нь нөгөө хоёр зарчмаа тэнцвэржүүлэх туслах чанартай зарчим биш бөгөөд ардчиллын нэг чухал бүрдэл хэсэг. Хяналтын суурь зарчим нь иргэд өөрсдийн сонгосон төлөөллийн байгууллагад хариуцлага тооцох боломжтой байх тухай Томас Гоббсын (Leviathan 1651) ойлголт юм. Төлөөллийн ардчилал нь эрх мэдлийн босоо болон хэвтээ хяналтын тогтолцоо, эрх зүйн зохицуулалтаас хүчтэй хамааралтай байдаг. Хэвтээ тэнхлэг дэх эрх мэдлийн хяналтын (horizontal) үүргийг Монтескьегийн онолоор ойлгох ба төрийн байгуулал дахь институцууд үйл ажиллагааны чиглэлд бие даасан байх, харилцан бие биенээ хянах тэнцвэржүүлэх (Cheks and Balances) үүрэгтэй оршдог. Харин босоо хяналтын (vertical) үүргийг төрийн байгуулал дахь институцийн үйл ажиллагааны чиглэлд шаталсан эрх үүргийн хуваарилалтын зарчмаар (Subsidiarity) зохицуулан хэрэгжүүлдэг (Kelsen, 1960).

Ардчиллын барометрийн суурь гурван зарчмын шалгуур үзүүлэлт болох 9 үүргийн эхэнд хувь хүний эрх чөлөө ордог. Хувь хүний эрх чөлөөг хангах, эрх зүйгээр баталгаажуулах нь ардчилсан тогтолцооны хамгийн чухал үүрэг юм. Хүний эрх чөлөө нь хувийн орон зай, хүний халдашгүй байх эрхийг хангаж өгдөг. Эрх чөлөөний баталгаа бол эрх зүйт төр бөгөөд хоёр дахь үүрэг юм. Хувь хүний эрх, эрх чөлөө, улс төрийн эрхийг эрх зүйт төрийн хүрээнд хамгаалж хуульчилсан байх шаардлагатай ба хүн бүр хууль, шүүх засаглалын өмнө тэгш эрхтэй байж эрх чөлөө хангагдах нөхцөлтэй юм. Гурав дахь үүрэг нь нийтийн эрх бөгөөд хувь хүний эрх нь хамт олны зорилгын нэгэн чухал хэсэг болдог гэсэн Жан Жак Руссогийн санааны илрэл юм. Бусадтай хамтран үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэж итгэл үнэмшил төрүүлэх, дэмжлэг авахыг зорих

нь хувь хүний эрх чөлөөний салшгүй хэсэг юм. Өөрөөр хэлбэл эрх чөлөө гэх ойлголтыг ардчиллын либерализм утгаар "хувийн эрх чөлөө бусдын эрх чөлөөгөөр хязгаарлагдах бөгөөд эрх зүйт төрөөр зохицуулагдсан байх" ёстой гэсэн агуулгаар бидний судалгаанд хэрэглэгдэж байгаа болно.

Ардчиллын барометрийн "иргэний хяналттай байх" зарчмын шалгуур үзүүлэлт нь тэгш өрсөлдөөн, төрийн эрх мэдлийн хяналт-тэнцвэр, засаглалын чадавх гэсэн гурван дэд үзүүлэлтээр хэмжигдэх бөгөөд хяналтын үүрэг нь чөлөөт, тогтмол, өрсөлдөөнт сонгуулийн замаар оршин тогтох ёстой гэсэн Жон Локкын (1632-1704) үзэл баримтлалаас үүдэлтэй юм (ШУА-ийн Философийн хүрээлэн, 2017, p. 58). Иргэд сонгуульд санал өгснөөр тэдний оролцоо дуусгавар болохгүй бөгөөд тэд өөрсдийг нь төлөөлөх үүрэг бүхий төлөөллийн байгууллага, төлөөлөгчдийн үйл ажиллагаанд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх, нөлөөлөх зэрэг олон хэлбэрийг ашиглах боломжтой юм. Төрийн байгуулал дахь институцийн эрх мэдлийн хяналт-тэнцвэрийн үүрэг нь төлөөллийн байгууллагууд харилцан хяналттай байх гэсэн Шарль Де Монтескьегийн (1689-1705) ойлголтод суурилах юм (ШУА-ийн Философийн хүрээлэн, 2017, pp. 58-61). Төлөөллийн байгууллага дахь эрх мэдлийн хяналт-тэнцвэрийн асуудал нь нэн тэргүүнд хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын хоорондын харилцааны тухай үндсэн хуулийн зохицуулалт юм. Хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын үндсэн хуулийн зохицуулалт нь засаглалын чадавхыг тодорхойлох бөгөөд ардчиллын барометрийн зургаа дахь хэмжигдэхүүн болдог. Төлөөллийн ардчиллын гол шинж нь институц хоорондын хариу гинжин урвал явагдах үзэгдэл, чанарын тухай ойлголт юм. Учир нь иргэдийн хүсэл, ашиг сонирхол, төр засгийн талаарх эерэг сөрөг хандлага нь улс төрийн сонгуулиар дайчлагдан, артикуляц, агрегац хийгдэх замаар парламент дахь улс төрийн намуудын саналын тоо болж хувирдаг. Шуурхай "хариу үйлдэл үзүүлдэг байх" тухай үзүүлэлт нь төрийн хүний нөөцийн асуудал юм. Төр нь үйл ажиллагааныхаа чиглэлд төрийн албаны хүний нөөцийг үр дүнтэй ашиглах шаардлагатай тулгардаг. Олон нийтийн дэмжлэгтэй байх нь төрийн хамгийн чухал нөөцийн нэг хэсэг юм. Хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын тогтвортой үйл ажиллагаа нь нийгэмд илүү хариуцлагатай нөхцлийг бүрдүүлж өгдөг.

Ардчиллын барометрийн гурав дахь суурь зарчим нь "иргэний тэгш эрх"-ийн тухай асуудал юм. Иргэн бүр тэгш эрхтэй байх агуулга нь улс төрийн тэгш оролцооны нөхцөлөөр тодорхойлогдох бөгөөд жам ёсны эрхийг Гоббс эхлүүлж Руссо нийгмийн гэрээний онолоор тодруулж, ардчиллын тулгуур зарчмуудын нэг болгосон байдаг. Ардчиллын онолын орчин цагийн төлөөлөл болох Даль "иргэний тэгш эрх"-ийн тухай асуудлыг "хүн бүхэн улс төрийн шийдвэрт тэгш оролцоо"-той байх гэсэн санааг дэвшүүлж, "полархи" бүтээлдээ тодруулсан. Тэгш байх нөхцөлийг ардчиллын барометрийн үзэл баримтлалд Бульманн "ил тод байдал", "улс төрийн тэгш оролцоо" болон "төлөөллийн зарчим" гэсэн гурван үзүүлэлтээр тодорхойлсон.

"Ил тод байдал" гэх үүрэг нь улс төрийн тэгш оролцоог хангах нөхцөл байхаас илүүтэй "хүн бүхэн тэгш боломжоор хангагдсан байх" гэсэн нийгмийн гэрээний үндсэн агуулгаар илрэх ба ил тод бус байх нь ардчиллын чанарт сөрөг нөлөө үзүүлдэг болохыг илэрхийлжээ. Нууцлаг, хаалттай байдал нэмэгдэх тусам иргэдийн бодит оролцоо багасах, хувь бүлгийн ашиг сонирхол нэмэгдэх орчин ардчилалд бий болж ардчиллын мөн чанарт гажуудал үүсдэг болохыг чехийн судлаач өөрийн бүтээлээр тодруулсан байна (Michal, Klima, 2017) Ил тод бус байдал нь авлига хээл хахууль нэмэгдүүлэх, нийгмийн тэгш бус хуваарилалт, шударга бус байдлын үндэс болдог байна. Өөрөөр хэлбэл, иргэдийн идэвхтэй оролцоонд тулгуурласан сайн засаглал, иргэдийн эрхийг хамгаалахад чиглэсэн үр нөлөөтэй ардчилсан тогтолцоог бүрдүүлэх тухай асуудал юм. Нийгмийн харилцаа ил тод байх нь иргэдийн оролцооны үүргийг идэвхжүүлдэг. Ардчилал өндөр хөгжсөн орнуудад иргэдийн тэгш оролцох эрхийг хангаад зогсохгүй зэрэгцэн "иргэний нийгэм" гэсэн ойлголтоор "оролцоо" иргэдэд ухамсарлагдсан байдаг. Учир нь улс төрийн ямар нэгэн шийдвэр тухайн хүний амьдралд хамааралтай байгаа нөхцөлд тухайн хүн асуудлын шийдвэрт оролцоотой байх ёстой гэсэн үзэл юм. Ил тод байдал, улс төрийн тэгш оролцоо нь хувь хүний итгэл үнэмшил, үзэл бодлыг улс төрийн тогтолцоонд төлөөлүүлэх зарчмыг бүрэлдүүлж өгдөг. Төлөөлөх үүрэг нь Гоббсын "Төр-Иргэн" хооронд гэрээгээр эрх шилжүүлж, үүрэг хүлээх үйл явцын тухай ойлголт юм. Өөрөөр хэлбэл, төр иргэн хоорондын харилцаа нь хоёр урсгал бүхий зам байх ба төлөөллийн байгууллага, төлөөлөгч иргэдийн ашиг сонирхлыг төлөөлж чадахгүй байгаа нөхцөлд хариуцлага хүлээлгэх тухай гэрээний асуудал юм. Орчин үеийн ардчилсан улс төрийн дэглэм нь үүнийг төлөөллийн байгууллагын тусламжтайгаар зохицуулсан байдаг. Ардчиллын барометрийн эдгээр 9 шалгуур үзүүлэлт тус бүр нь дотроо дэд хэсгүүдэд хуваагдах ба өмнөх хийгдсэн ардчиллын хэрэгжилтийн талаарх судалгааны алдааг давтахгүйн тулд шалгуур үзүүлэлт тус бүрийг хэд хэдэн хэмжүүрээр шалгасан байдаг. Нэгдүгээрт, экспертийн үнэлгээн дээр тулгуурласан шалгууруудаас татгалзах; хоёрдугаарт, хэмжилтийн алдааг багасгахын тулд дэд хэсэг тус бүрт зориулж төрөл бүрийн шалгууруудыг оруулсан; гуравдугаарт, "институцийн төөрөгдлөөс" зайлсхийхийг оролджээ. Эдгээр шалгуур үзүүлэлтүүд нь 2002 оны Монгол Улсад IDEA-гийн гаргасан "Ардчилсан засаглалын шалгуур үзүүлэлт" арга зүйг сайжруулж ашиглах боломжийг нээж байна.

Ардчиллын барометр нь суурь гурван зарчмыг Үндсэн хуульд тодорхойлсон байдлаар нягтлаад зогсохгүй түүний бодит илрэл, хэрэгжилтийг үнэлэхэд чиглэгддэг. Өөрөөр хэлбэл нэг дэд хэсэг эрх зүйт төрийн зохицуулалтыг хэмжиж байхад нөгөө дэд хэсэг нь хуулийн бодит байдал дээр хэрэгжилтийг хэмжиж, иргэдийн төсөөллөөр үнэлгээ авахад чиглэгддэг гэсэн үг юм. Монгол Улс дахь ардчиллын хэрэгжилтийн төлөв байдлыг тодорхойлох судалгаанд

“Ардчиллын барометр”-ийн арга зүйг хэрэглэснээр нэг талаас өмнөх судалгаанд нарийвчлан судлагдаагүй иргэдийн ардчиллын тухай ойлголт, өнөөгийн чиг хандлагыг тодруулж, нөгөө талаас бодит байдал дээрх иргэдийн ойлголтын түвшингээр ардчиллын хэрэгжилтийг харьцуулан дүгнэхийг оролдож байгаагаараа онцлог ач холбогдолтой юм.

Бидний сонгож авсан гурав дахь шалгуур үзүүлэлт нь Италийн судлаач Леонардо Морлиногийн ардчиллын чанарыг үнэлэх арга зүй юм. Тэрээр “Сайн ардчилал”, “Ардчиллын чанар” (Morlino Leonardo, 2004, p. 5) хэмээх ойлголтыг онцгойлон авч үзсэн. Морлино Липхартын боловсруулсан ардчиллын минималист тодорхойлолтод тулгуурлан арга зүйгээ боловсруулсан байна. Минималист тодорхойлолтыг сонгосон шалтгаан нь нэгдүгээрт, сонгуулиар гарч ирсэн удирдагчид иргэдийнхээ хэрэгцээ, шаардлагад тогтмол хариу үзүүлснээр, иргэдийн хэрэгцээ сонирхол хангагдаж төр засгаа хүлээн зөвшөөрч, дэглэм тогтвортой, чанартай ажилладаг (Morlino Leonardo, 2011, pp. 9-45). Тэрээр “сайн” ардчилсан дэглэмүүдийг ардчиллын суурь зарчмууд дээр тулгуурлан “дутагдалтай” хувилбаруудаас нь ялгаж өгөхийг эхлээд зорьсон байдаг. Үүнд дараах хувилбарууд багтана. “Гибрид” нь чөлөөт, шударга сонгуулийн өрсөлдөөнийг хангаж чадаагүй, иргэний оролцоо хамгийн бага дэглэм юм. “Онцгой” ардчилал нь зөвхөн хязгаарлагдмал улс төрийн эрхийг олгодог. “Ноёрхсон” ардчиллын нөхцөлд хүчирхэг бүлэглэлүүд өөрсдийн нөлөөгөө сонгуулиар гарч ирсэн удирдагчдыг хянаж, хязгаарлахад ашигладаг. “Либерал бус” ардчилалд иргэний эрхийг зөвхөн хэсэгчилсэн байдлаар хангаж өгдөг байна (Morlino Leonardo, 2004, p. 5).

Морлиногийн үнэлгээний загварын тусламжтайгаар бид аливаа улс орны ардчиллын чанарыг судлан гаргаж ирэх боломжтой. Морлино ардчиллын үнэлгээний хамгийн гол нь аливаа улс оронд ардчилал тогтсон эсэхийг цөөн тооны асуулгаар үнэлээд зогсохгүй, ардчиллын чанарыг тодруулахад чиглэх ёстой гэсэн үзлийг дэвшүүлжээ.

**Зураг 3. Морлиногийн ардчиллын чанарын тухай үзэл баримтлал**



Морлиногийн "сайн", "чанартай" ардчилал нь "иргэдийн эрх чөлөө, тэгш эрхийг хууль ёсны зөв ажиллаж чаддаг институц болон механизмын тусламжтайгаар хэрэгжүүлдэг тогтвортой институционал бүтэц"-ийн тухай ойлголт юм (Morlino Leonardo, 2004, p. 5). Морлиногийн ардчиллын арга зүйн Бульманны ардчиллын барометрээс ялгарах гол онцлог нь эдийн засаг, маркетингийн салбарт хэрэглэдэг чанар гэсэн ойлголтыг эрх чөлөө, тэгш эрх, хяналт гэсэн ардчиллын гурван зарчмыг үйл явц, агуулга, үр дүн гэсэн гурван ойлголтоор орлуулан бодит амьдралд илүү ойр ардчиллын чанарыг үнэлэх арга зүйг боловсруулсанд оршиж байгаа юм. Морлино "сайн" болон "муу" ардчиллыг үнэлэхэд "чанар"-ын тодорхойлолт зайлшгүй хэрэгтэй гэж үзсэн бөгөөд аж үйлдвэр, маркетингийн салбарт хэрэглэдэг чанар хэмээх ойлголтыг ашиглаж ардчилсан дэглэмийг үнэлэх арга зүйг боловсруулсан байна.

"Сайн ардчилал" хэмээх ойлголтыг нэн тэргүүнд иргэдээ сэтгэл ханамжтай байлгаж чаддаг эрх зүйт улс төрийн дэглэм гэж үзэх ёстой. Чанар гэсэн ойлголт энд хэрэглэгчийн сэтгэл ханамж, өмнө нь авч байсан үйлчилгээ, бүтээгдэхүүнээ дахин дахин хүсэх хэрэгцээ, үйлдвэрээс гарсан бүтээгдэхүүн хэрэглэгчийн гар дээр чухам ямар хэлбэртэй очиж түүнийг нь хэрэглэгч хэрхэн хүлээж авч байгаа үр дүн гэсэн системийн онолын утгаар орж байгаа гэдгийг санах хэрэгтэй. Хоёрдугаарт, сайн ардчилал нь иргэд, холбоод, нийтлэгүүд эрх чөлөө болон тэгш эрхээ хангалттай эдлэхийг хэлдэг. Энд чанар гэсэн ойлголт нь тухайн бүтээгдэхүүний бүтцийн шинжүүд болох загвар, материал, бүтээгдэхүүний үүргийг багтаасан утгатай орж ирнэ. Гуравдугаарт, сайн ардчиллын нөхцөлд иргэд нь төр хуулийн дагуу ажиллаж, эрх чөлөө, тэгш эрхийг хангах зорилгоо хэрхэн гүйцэтгэж байгааг үнэлж, хянах эрх мэдэлтэй байх ёстой юм. Түүнээс гадна сайн ардчилал тогтсон үед иргэд хуулийн хэрэгжилтийн үр ашиг, засгийн газраас гарч байгаа шийдвэрийн үр дүн, сонгогдсон улс төрийн албан тушаалтнуудын улс төрийн үүрэг хариуцлагад хөндлөнгийн мониторинг хийдэг. Энд чанар гэсэн ойлголт нь тодорхой аргад тулгуурлан тодорхой хяналттай, нарийн цагийн горимд, байнга давтагдах үйл явц гэсэн утгыг илэрхийлнэ (Morlino Leonardo Carli Luiss G, 2014). Морлиногийн дээрх арга зүй энэхүү судалгаанд Монгол улсын ардчиллын чанарыг системийн онолын түвшинд үнэлэх бололцоог гаргаж өгч байгаад судалгааны чухал ач холбогдол оршино.

Энэхүү судалгаанд ашиглагдсан өөр нэгэн шалгуур үзүүлэлт бол Фрийдом хаусын (Freedom House) ардчиллын индекс юм. Олон улсын судалгааны Фрийдом хаус хүрээлэн нь 1941 онд байгуулагдсан бөгөөд 1972 оноос хойш дэлхийн улс орнуудын ардчиллын индексийг жил тутам гаргадаг болжээ. Фрийдом хаусын судалгааны эх сурвалж нь НҮБ-аас 1948 онд гаргасан Хүний эрхийн түгээмэл тунхаглал юм. Тунхаглалыг эх сурвалж болгосон шалтгаан нь хэл, соёл шашин шүтлэг, нийгэм, эдийн засгийн хөгжлийн түвшингээрээ өөр өөр улс орнуудыг судлахад хамгийн түгээмэл ерөнхий стандарт болж

өгдөгөөрөө онцлог юм. Улс орнуудыг эрх чөлөөтэй (1-2.5), хагас эрх чөлөөтэй (3-5), эрх чөлөөгүй (5.5-7) гэсэн гурван ангилалд хуваадаг бөгөөд 1-7 хүртэл оноогоор хамгийн ардчилсан улсаас хамгийн дарангуй дэглэм хүртэлх байр эрэмбэлдэг. Улс орнуудад оноо өгөхдөө улс төрийн эрхийн 10, иргэний эрхийн 15 үзүүлэлтэд тус бүрээр 0-4 оноогоор үнэлдэг. Улс төрийн эрх нь сонгуулийн үйл явц, улс төрийн олон ургальч байдал, оролцоо, төрийн үйл ажиллагаа гэсэн дэд хэсгүүдэд, иргэний эрх нь үзэл бодлоо илэрхийлэх эрх, эвлэлдэн нэгдэх эрх, хууль дээдлэх ёс, хувийн халдашгүй дархан байдал гэж хуваагддаг (Freedom house, 2018). Фрийдом хаусын ардчиллын индексийг бусад индекстэй харьцуулахад ашиглахад хялбар, ойлгомжтой, бүтцийн хувьд энгийн байдаг учраас судлаач эрдэмтдийн хүрээнд ихээхэн хүлээн зөвшөөрөгдсөн байдаг. Гэхдээ ардчиллыг үнэлэхдээ бодит байдлаас зарим нэг талаар хөндийрсөн дүгнэлт хийдэг гэсэн шүүмжлэлд өртдөг (Wouter P.Veendaal, 2015, pp. 92-112). Учир нь хүний эрхийн төлөв байдлын талаар НҮБ-ын гишүүн орнуудаас Хүний эрхийн хороонд жил бүр гаргадаг илтгэлд ардчилсан гэж харагдаж байгаа боловч амьдрал дээр ардчилсан бус дэглэмтэй байх нь бий. Иймээс бидний судалгаа зөвхөн нэг арга зүйг барьж түүнийг монголын төлөөллийн ардчиллыг судлахад ашиглахаар хязгаарлахгүйгээр ардчиллыг үнэлдэг хэд хэдэн шалгуур үзүүлэлтүүдийг харьцуулан өөрийн орны онцлогт тохирсон судалгааны шалгуур үзүүлэлтүүдийг гаргаж ирсэн болно. Чингэхдээ Бульманны арга зүйг ерөнхий суурь болгон авснаараа онцлог юм.

Монгол Улс дахь төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмын талаарх иргэдийн ойлголт, төсөөллөөр дамжуулан тэдгээрийн хэрэгжилтийн төлөв байдалд үнэлгээ хийсэн энэхүү судалгаа нь манай улсад урьд нь хийгдсэн судалгааны ажлын зарим үр дүнгийн үзүүлэлтүүдтэй өөрсдийн хийсэн судалгааны дүнг харьцуулах, мөн өмнөх судалгааны ажлуудад харьцангуй бага хөндөгдсөн иргэний хяналт, оролцоог илүү нарийвчлан шинжлэх боломж олгож байгаагаараа онцлог болно.

# 3. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Монгол Улсад ардчиллын талаарх өмнө хийгдсэн судалгааны ажилуудын дүгнэлт, судалгааны агуулгыг давтахгүйн тулд Бульманны барометрийн шалгуур үзүүлэлт болох "иргэний эрх чөлөө, иргэний тэгш эрх, иргэний хяналттай" байх тухай үзэл баримтлалыг судалгааны цөм асуудал болгон үзэл баримтлалын хүрээгээ хязгаарласан болно. Үүний зэрэгцээ зарим үзүүлэлтийг харьцуулах боломжтой байлгахын тулд арга зүйн хүрээнд цөөн шалгуур үзүүлэлтийг адил байхаар сонгов. Тухайлбал, Монгол Улсын төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмын хэрэгжилтийн талаарх иргэдийн ойлголт, төсөөллийг санал асуулгын аргаар тодруулахдаа төрийн байгууллын эрх зүйн орчинг тодорхойлсон байдал, төрийн эрх мэдлийн хуваарилагдсан байдал, "Төр-Иргэн" хоорондын харилцааны төлөв байдлыг тодорхойлсон байдал зэрэг гурван багц асуудлын хүрээнд өмнөх судалгаануудад орсон асуултын зэрэгцээ шинэ асуултууд, ялангуяа төрийн институцуудын иргэний эрх чөлөөг хангахад чиглэсэн үйл ажиллагаа, иргэний хяналтын хүрээний асуудлуудыг илүү түлхүү оруулж өгөв. Учир нь Бульманны ардчиллын барометрийн суурь гурван зарчмын дагуу төлөөллийн ардчиллын тухай ойлголтыг Үндсэн хуульд тодорхойлсон байдлаар нягтлахын зэрэгцээ Үндсэн хуулийг хэрэгжүүлэгч төрийн байгуулал дахь институцийн үйл ажиллагаа нь эрх зүйн үндсэн гурван зарчмын хэрэгжилтийг хангахад чиглэгдсэн эсэхийг чухалчилдаг. Өөрөөр хэлбэл, энэ судалгаанд Бульманны арга зүйг Морлиногийн арга зүйн зарим үзүүлэлтээр баяжуулалт хийсэн болно. Төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмын хэрэгжилтийн талаарх иргэдийн ойлголт, институцийн үйл ажиллагааны иргэдийн төсөөлөл гэсэн хоёр үзүүлэлт нь Морлиногийн "сайн ардчилал" гэх ойлголт дахь хэрэгжилтийн чанарыг илэрхийлэх тул төлөөллийн ардчиллын зарчмуудын хэрэгжилтэд үнэлгээ хийх зорилгын хүрээнд эл судалгаанд түүнийг зориуд хэрэглэсэн болно.

Судалгааны хүрээнд нэгдүгээрт, "иргэний эрх чөлөө, иргэний тэгш эрх, иргэний хяналттай байх" тухай багц асуудлуудыг Үндсэн хууль бусад эрх зүйн баримт бичгүүдэд тодохойлсон байдалд контент шинжилгээ хийлээ. Хоёрдугаарт, Үндсэн хуулийн үзэл баримтлал, судалгааны арга зүйн шаардлагын дагуу дээр дурдсан гурван багц, 9 бүлэг үзүүлэлтийг 56 асуулт болгон задалж, олон нийтийн санал асуулгын анкетийг боловсруулан мэдээлэл авч дүн шинжилгээ хийв. Гуравдугаарт, иргэдийн эрх чөлөө, тэгш эрх, оролцоо, хяналтыг хангахад чиглэсэн төрийн институцийн үйл ажиллагааны хэрэгжилтийг асуулгын анкетад тухайлан тусгаж, энэ тухайд

иргэдийн ойлголт, төсөөллийн цогц мэдээллийг авч боловсруулан сонгож авсан арга зүйн дагуу үнэлгээ хийж, дүгнэлт гаргасан болно.

### 3.1. Контент шинжилгээ

Ардчиллын гурав дахь давалгааны дараа үеэс эхлэн ардчилсан тогтолцоотой байхын зэрэгцээ иргэд ардчиллыг ойлгож, ардчиллын хэрэгжилтэнд хяналттай, оролцоотой байж чадаж байна уу гэсэн асуулт ардчиллын аливаа судалгааны гол асуудал болон дэвшигдсэн билээ. Ийм ч учраас Бульманны барометрийн шалгуур үзүүлэлт болох "иргэний эрх чөлөө, иргэний тэгш эрх, иргэний хяналттай" байх тухай ойлголтыг төлөөллийн ардчилал болон шууд ардчиллын аль алинд ашиглах боломжтой гэж судлаачид үзсээр байна.

Ардчилал бол "Ард түмний засаглал" гэсэн тодорхойлолтын дагуу "иргэний эрх чөлөө, иргэний тэгш эрх, иргэний хяналттай" байх нөхцөл эрх зүйн баримт бичгүүдэд хэрхэн тодорхойлогдсныг задлан шинжлэх, харьцуулж нэгтгэн дүгнэх замаар судлахын тулд баримт бичгийн контент шинжилгээний дизайныг боловсруулсан (зураг4). Ингэхдээ Бульманны гурван зарчмыг тус бүрт нь гурван үзүүлэлтээр нарийвчлан тодорхойлж, нийт есөн шалгуур үзүүлэлт тус бүрийг хоёр үзүүлэлтэд задлаж, 19-н үзүүлэлтээр иргэдийн ойлголтыг тодорхойлов (Хавсралт 1-ээс харна уу).

**Зураг 4. Судалгааны арга зүйн тойм зураглал**




Судалгаанд иргэний "эрх чөлөө" гэсэн ойлголт нь"хувь хүний эрх бусдын эрхээр хязгаарлагдана" гэх утгаар илэрхийлэгдэх бөгөөд энэ нь иргэдийн эрхийг дагалдсан үүрэг, хариуцлагын тухай асуудалд ч бас хамаарах юм. Эрх

чөлөөний талаарх иргэдийн ойлголттой байдал нь эрх үүргийн харилцаанд "нийтийн эрхийг" хангах нөхцөл хэр бүрэлдсэн болохыг илэрхийлэхийн зэрэгцээ "хувийн эрх чөлөө" болон "нийтийн эрхийн" тэнцвэрт харилцааг "эрх зүйт төр" зохицуулах үүрэг хүлээх ёстой гэсэн төсөөллийг бас харуулна. Иргэний "тэгш эрх"-ийн ойлголт нь иргэдийн оролцоогоор дамжиж хэрэгжих тул "ил тод" байдлаар илэрхийлэгдэж, нийгэмд "төлөөллийн зарчим" хангагдах эрх зүйн боломж хэр бүрдсэнийг тодорхойлно.

Ардчилсан нийгмийн тогтолцоон дахь олон ургальч үзлийн хүрээнд "эрх чөлөө" болон "тэгш эрхийн" харилцаанд динамик тэнцлийг хангагдсан байдлаар иргэний "хяналттай" байх агуулга тодорхойлогдоно. Харин иргэний хяналт нь тэгш оролцоон дээр суурилах ба "тэгш өрсөлдөх нөхцөл"-өөр хангагдсан үед улс төрийн шударга сонгуулийн ("faire") үр дүнгээр төлөөллийн байгууллага бий болж, төрийн байгууллалд "засаглалын чадавх" бүрдэнэ гэсэн утгаар хэрэглэгдсэн болно. Засаглалын тогтвортой байдал нь засаглалын институцуудын гаргасан улс төрийн шийдвэрүүд иргэдийн ашиг сонирхолд чиглэж, үйл ажиллагааны эерэг үр дүн нь төрийн "эрх мэдлийн хяналт-тэнцвэр"-тэй нөхцөлд боломжтой гэсэн утгыг илэрхийлнэ.

Энэ бүхнийг үндэслэн дескриптив шинжилгээ хийж, Үндсэн хуулийн дагуу эрх зүйн орчин тодорхойлогдсон байдал ба түүний хэрэгжилтийн талаарх иргэдийн ойлголт, төсөөллийн хооронд хэр зөрүү байгааг тодорхойлсон. Чингэхдээ Бульманны үзэл баримтлалын гол үзүүлэлтээр Морлиногийн "сайн", "муу" хэмээн зааглаcан ардчиллын эрх зүйн суурь зарчмуудын хэрэгжилт манай нийгэмд ямар төлөв байдалтай байгааг тодруулахыг эрмэлзсэн болно.

### 3.2. Асуулгын арга

Асуулгын анкетийг иргэд иргэний эрх чөлөө, улс төрийн хяналт, тэгш эрхээ эдлэх гэсэн эрх зүйн суурь зарчмуудыг хэрэгжүүлэх нөхцөл бололцоо хэр зэрэг бүрдсэн, тэр нь иргэдэд үндсэн эрхээ эдлэх боломжийг хэр зэрэг бүрдүүлж байгааг 3 үндсэн зарчмын хүрээнд 9 шалгуур үзүүлэлт бүхий Бульманны боловсруулсан арга зүйд үндэслэсэн болно. Энэхүү асуулга нь судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл, ардчиллын тухай иргэдийн ойлголт, ардчиллын эрх зүйн суурь зарчмууд болон төрийн институцийн үйл ажиллагааны хэрэгжилтийн тухай гэсэн 4 хэсгээс бүрдэнэ. Ерөнхий мэдээллээс бусад хэсгийг 1-5 оноогоор үнэлүүлэх ба тухайн нэг асуултын хувьд мэдэхгүй тохиолдолд 0 гэсэн үнэлгээг ашигласан. 1-5 онооны хувьд "1" гэдэг нь бага гэсэн утгыг илэрхийлэх ба "5" гэдэг нь их буюу бүрэн ойлголттой гэсэн утгыг илэрхийлнэ. Асуулгын ерөнхий мэдээлэл хэсэг нь 11 асуулт, ардчиллын тухай ойлголтын хэсэг нь 57 асуулт, ардчиллын хэрэгжилт нь 19 асуулт, төрийн институцийн үйл ажиллагааны хэрэгжилт хэсэг нь 11 асуулт, нэмэлт 2 асуулт бүхий нийт 100 асуулттай асуулгыг боловсруулсан болно. Асуулгын агуулгыг хавсралт 1-ээс харна уу.

**Зураг 5. Төлөөллийн ардчиллын талаарх иргэдийн төсөөллийг хэмжих үзүүлэлт**




Эх сурвалж. Buehlmann, Marc; Merkel, Wolfgang;Mueller, Lisa; Giebler, Heiko; Wessels, Bernhard (2012): Demokrtaiebarometer: ein neues Instrument zur Messung von Demokratiequalitaet. In:Zeitschrift fuer Vergleichende Politikwissenschaft 6, s.123.

Төлөөллийн ардчиллын талаарх иргэдийн ойлголтыг судлахад зураг 5-д үзүүлсэн 9 дэд үзүүлэлтийг хэрэглэв. Дэд үзүүлэлт бүр дунджаар 3 асуултыг багтаах ба иргэдээс өгсөн хариултуудад үндэслэн дэд үзүүлэлт бүрээр дунджийг нь олж, иргэдийн ардчиллын тухай ойлголтын түвшинг тодорхойлсон. Үүнтэй адилаар ардчиллын эрх зүйн суурь зарчмуудын хэрэгжилтийн тухай хэсгийг дээрх 9 дэд үзүүлэлтэд хуваахдаа үзүүлэлт бүр дунджаар 2 асуултыг багтаах ба иргэдийн хариултын дунджаар нь Монгол улс дахь төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмуудын хэрэгжилтийг үнэлсэн. Харин төрийн институцийн үйл ажиллагааны хэрэгжилтийг дэд үзүүлэлтэд хуваагаагүй, үүнийг шууд 11 асуултад хариулсан иргэдийн хариултын дунджаар тогтоосон.

Монгол улсын Улаанбаатар хотын 6 дүүргийн нийт 1,347,598 иргэнээс 18-аас дээш насны 807,055 иргэн байгаа нь судалгааны эх олонлог юм. Энэхүү мэдээлэлд үндэслэн Монгол улсын Үндэсний Статистикийн Газар (ҮСГ)-тай хамтран энгийн санамсаргүй түүврийн аргаар 18-аас дээш насны иргэдээс судалгааны түүврийг бүрдүүлэхийг оролдсон боловч тухайн хувь хүний нэр, овог, нас, хаяг, регистрийн дугаар зэрэг нь мэдээллийн нууцад хамаардаг гэсэн хуулийн үндэслэлээр эх олонлогт хамаарах иргэдийн болон түүвэрт хамрагдах иргэдийн бүртгэл мэдээллийг ҮСГ-аас гаргаж өгөөгүй. Иймд түүвэрт өөрчлөлт оруулж Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг бүрээс гэр хороолол, байшин хороолол, холимог хороолол гэсэн 3 хороог санамсаргүйгээр[1] сонгож авсан. Улаанбаатар хотын 6 дүүргээс түүвэрт сонгогдсон хороод болон өрхийн тоог хавсралт 2-т харуулав. Ийнхүү дүүрэг бүрээс сонгосон хороодын нийт 366,961 өрхөөс энгийн санамсаргүй түүврийн

[1] http://stattrek.com/statistics/random-number-generator.aspx сайтаар санамсаргүй тоо буюу түүврийн хорооны дугаарыг тодорхойлсон.

аргаар[2] 95%-ийн итгэх түвшинд **4** хувийн хэлбэлзэлтэйгээр түүврийн хэмжээг тооцоход **599** өрх, харин 95 %-ийн итгэх түвшинд **5** хувийн хэлбэлзэлтэйгээр түүврийн хэмжээг тооцоход **384** өрх сонгогдохоор тооцоологдсон. Үүнийг мөн хавсралт 2-т үзүүлэв. Харин дүүрэг бүрээс сонгогдсон гэр, байшин болон холимог хорооллын өрхүүдээс түүвэрт сонгогдсон өрх болон тэдгээрийн оршин байгаа хаягийн тухай мэдээллийг ҮСГ-аас хамтран ажиллах гэрээ болон нууц хадгалах тухай гэрээ байгуулсны үндсэн дээр гаргуулж авахдаа түүврийн хэмжээг 599 байхаар зорьсон.

Түүвэрт сонгогдсон 599 өрхийн хаягаар очиж, тухайн өрхийн 18-аас дээш насны нэг иргэнээс асуулгын судалгааг авч, холбогдох маягтыг[3] бөглүүлсэн. Ингэхдээ хэрэв тухайн хаягт өрх байхгүй эсвэл асуулгын судалгаанд оролцохоос татгалзаж байвал тухайн айлын баруун гар талын өрхөөс судалгаа авах дүрмийг баримтлах учраас анкет бөглөгдөхгүй ирэх магадлал маш бага юм. Иймээс ҮСГ-аас 599-ээс илүү хэмжээний нөөц өрхийн хаяг өгөх шаардлага байхгүй гэж үзсэн. Гэхдээ хот төлөвлөлтийн бодлоготой уялдан зарим хэсэг газар орон сууц барихаар төлөвлөгдсөн тохиолдол гарч магадгүй учраас 610 өрхийн хаяг буюу 11 өрхийн нөөц хаягийг мэдээллийн сангаасаа гаргаж өгсөн. Үүнээс гадна судалгааны үндсэн агуулгын хүрээнд нэмэлт сургалт явуулж, иргэдийн ойлголтод гарсан өөрчлөлтийг өмнөхтэй нь харьцуулж тодорхойлох зорилго дэвшүүлсэн болно.

Энэхүү судалгааны өөр нэг чухал зүйл нь асуулгын аргаар илэрсэн өнөөгийн төлөв байдлыг Олон улсын түвшинд хийгдсэн судалгааны үр дүнтэй харьцуулах боломж бүрдэнэ. Мөн түүнчлэн Жон Локк, Томас Гоббс, Жан Жак Руссо нарын онолын үзэл баримтлал болох "Төр-иргэн" хоорондын харилцааг тодорхойлж төлөөллийн ардчиллыг хангах эрх зүйн зохицуулалт хязгаарлагдмал эсэх, иргэдийн эрх чөлөөтэй байх, улс төрийн шийдвэрт хяналт тавих боломжтой байх, тэгш эрхээ эдлэхэд нь эрх зүйн зохицуулалт болон төрийн үйл ажиллагаа саад болж байгаа эсэхийг харьцуулах боломж бүрдсэн.

---

2 https://www.surveysystem.com/sscalc.htm сайтаар нийт өрхөөс сонгох түүврийн хэмжээг тодорхойлсон.

3 Энэхүү маягт гэдэг нь 18-аас дээш насны иргэн мөн гэдгийг нотлох, мөн анкет бөглөх үед мөнгөн төлбөр олгогдсныг нотлох, яг түүврийн дагуу сонгогдсон өрхөөс анкет бөглүүлснийг шалгах форм юм.

# 4. СУДАЛГААНЫ ӨГӨГДӨЛ БОЛОВСРУУЛАЛТ

## 4.1. Контент шинжилгээний өгөгдөл боловсруулалт

“Хүмүүнлэг, иргэний, ардчилсан” нийгмийн үндсэн дүр төлөвийг илэрхийлэх үзүүлэлтүүд нь иргэний “эрх чөлөө, тэгш эрх, хяналт”-ын тухай ойлголт, түүнийг тодорхойлсон эрх зүйн зохицуулалт юм. Монгол Улсын Үндсэн хууль болон бусад эрх зүйн баримт бичигт төлөөллийн ардчиллын эрх зүйн энэхүү суурь зарчмууд хэрхэн тусгалаа олсныг дескриптив арга зүйгээр задлан шинжилгээ хийлээ. Судалгааны ажлын үндсэн хэрэглэгдэхүүн нь эх сурвалж болох өмнө хийгдсэн ШУА-ийн ФСЭХ-ийн бүтээлүүд, Монгол Улсын хууль тогтоомж, суурь судалгааны тайлан, эрдэм шинжилгээний хэлэлцүүлэг зэрэг болно. Судалгааны дескриптив шинжилгээг хийхдээ задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, эрх зүйн бичиг баримтын харьцуулсан шинжилгээ хийх аргыг ашиглаж дараах асуултыг үндсэн чиглэл болгосон. Үүнд:

- Иргэний “эрх чөлөө”-ний тухай ойлголт нь хууль тогтоомжид хэрхэн тодорхойлогдсон байдалд дүгнэлт хийх,
- Иргэний “тэгш эрх”-ийн тухай ойлголт хууль тогтоомжид хэрхэн тодорхойлогдсон байдалд дүгнэлт хийх,
- Иргэний “хяналт”-ын тухай ойлголт хууль тогтоомжид хэрхэн тодорхойлогдсон байдалд дүгнэлт хийх.

***Дескриптив шинжилгээний нэгдүгээр асуулт:***

- Монгол Улс төрийн байгууллалд “иргэний эрх чөлөө, хяналт, тэгш эрх”-ийн зарчмыг хэрхэн хуульчилсан байна вэ?

Монгол Улс нь 1992 онд эрх зүйн суурь зарчмыг тулгуур болгон төлөөллийн ардчиллыг улс төрийн дэглэмийнхээ үндэс болгон сонгож, Үндсэн хуулийн гуравдугаар бүлэгт баталгаажуулсан байдаг. Монгол Улсын төрийн байгуулал 1). Хууль тогтоох засаглал (Улсын Их Хурал, Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлээс 29 дүгээр зүйл), 2). Монгол Улсын Ерөнхийлөгч (Үндсэн хуулийн 30 дугаар зүйлээс 37 дугаар зүйл), 3). Гүйцэтгэх засаглал (Үндсэн хуулийн 38 дугаар зүйлээс 46 дугаар зүйл), 4). Шүүх эрх мэдэл (Үндсэн хуулийн 47 дугаар зүйлээс 56 дугаар зүйл) гэсэн төрийн дөрвөн институцийг хуульчилж, төрийн удирдлагын хэлбэрийг Бүгд найрамдах парламентын засаглалтай байхаар боловсруулсан байна. Энэхүү төрийн байгууллын үйл ажиллагааны үндэс нь Аристотелийн онолын хүрээнд **“иргэний сайн сайхны төлөө”** чиглэгдсэн байх ёстой бөгөөд Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн хүний эрхийг тодорхойлсон байдал, НҮБ-ийн Хүний эрхийн түгээмэл тунхаглал болох 18 заалтыг хэрэгжүүлэхэд орших

ажээ. Иймд дескриптив судалгаа нь Үндсэн хуулиар “иргэний эрх чөлөө, хяналт, тэгш эрх”-ийг тодорхойлсон байдлаар хийгдсэн болно. Үндсэн хуулийн гуравдугаар бүлгийн үзэл баримтлалаар Монгол Улсын төрийн байгуулал нь дараах зураглалтай байна.

**Зураг 6. Монгол Улсын төрийн байгуулал**




Монгол Улс Үндсэн хуулиараа сонгосон парламентын тогтолцоо нь хүний эрхийг хангах эрх зүйн суурь зарчмуудыг олон улсын жишгийн дагуу хэрэгжүүлэх боломжийг олгосон юм. Хүний эрх, эрх чөлөө нь эрх зүйт төр, нийтийн эрхийн тухай ойлголтоор баталгаажих бөгөөд төрийн эрх, нийтийн эрх ашиг нь өөрөө хүний эрх чөлөөг хангах, бас тодорхой хүрээнд хязгаарлах нөхцөл болдог тул хүний эрх чөлөөг хамгаалахын тулд төрийн үйл ажиллагааг институцилэхэд зайлшгүй хүргэдэг болно. Монгол Улсад хүний эрх чөлөөг хамгаалахын тулд төрийн эрх мэдлийг төрийн байгуулалд Шарль Де Монтескьегийн эрх мэдлийн хяналт-тэнцлийг хадгалах зарчмын дагуу хуваарилсан байдаг (Энхбаатар, Ч., 2017, p. 12) Өөрөөр хэлбэл, төрийн эрх мэдэл нь харилцан тэнцвэртэй байх нөхцөлтэй байна гэсэн үг юм (зураг 6).

Харин Монгол Улсын Үндсэн хуульд төрийн эрх барих дээд байгууллага бол Улсын Их Хурал мөн хэмээн хуульчилсан байдаг. Зарим судлаачид “төрийн эрх барих дээд байгууллага” гэсэн тодорхойлолтыг онолын хувьд буруу гэж шүүмжилдэг бөгөөд энэ талаарх маргаан одоо ч үргэлжилсээр байгаа болно (Амаржаргал, 2018, pp. 10-24). Төлөөллийн ардчилалд суурилсан парламентийн засаглалын нөхцөлд сонгуулийн үр дүнгээр олонхи болсон нам, улс төрийн хүчин Засгийн газраа байгуулдаг олон улсын нийтлэг жишиг бий. Энэ жишгийн дагуу манай улсад ч Улсын Их Хуралд олонх болсон нам, эвсэл Засгийн газрыг бүрдүүлэхэд шийдвэрлэх үүрэгтэй оролцдог. Олонхийн зарчмаар бүрдсэн Засгийн газар нь УИХ-ын өмнө ажлаа хариуцан тайлагнадаг зарчим үйлчилдэг.

УИХ нь төрийн байгуулалд төр буюу нийтийн эрхийг төлөөлж, хүний эрх чөлөөний тухай ойлголтын салшгүй нэгэн хэсэг болох “эвлэлдэн нэгдэх”

эрхийн (Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 10 дугаар заалт) хэрэгжилтийг улс төрийн намаар уламжлан хэрэгжүүлэхдээ төрийн байгууллын үйл ажиллагааны хүрээнд төрийг төлөөлж хүний "аюулгүй орчинд амьдрах эрх"-ийг хангах (Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 2 дугаар заалт), хүний хөдөлмөрлөх эрхийг хангах (Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 5 дугаар заалт), хөдөлмөрийн чадваргүй нөхцөлд төрөөс тусламж авах эрхийг хангах (Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 6 дугаар заалт), хүний эрүүл мэндийг хамгаалах төрийн үйлчилгээ үзүүлэх (Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 7 дугаар заалт), эр, эм хүний хүйс үл харгалзан нийгмийн харилцаанд тэгш оролцоотой байлгах (Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 12 дугаар заалт) үүрэг хүлээнэ гэсэн зарчмын хэрэгжилтийг хангаж ажиллах ёстой (Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлээс 29 дүгээр зүйл).

Монгол Улсын төрийн байгуулалд дээрх нийтийн эрх, иргэний эрх ашгийг хамгаалах үүргийг УИХ нь хэрэгжүүлэхдээ Үндсэн хуулиар олгогдсон төрийн эрх мэдлийн хяналт-тэнцлийн зарчмын хангах үүрэгтэйн дагуу бие даасан, хараат бус шүүх засаглалын (Үндсэн хуулийн 47 дугаар зүйлээс 56 дугаар зүйл) хяналтын дор ажиллах ёстой. Энэхүү хүний эрх чөлөө, нийтийн эрх чөлөө болон эрх зүйт төрийн тухай үзэл баримтлалыг Үндсэн хуулиас гадна бусад эрх зүйн бичиг баримтаар баталгаажуулсан байдаг. Монгол Улсын парламентын тогтолцооны онцлогийг Үндсэн хуулийн гуравдугаар бүлгийн үзэл баримтлалын хүрээнд дүрслэн үзүүлбэл (зураг 7):

### Зураг 7. Монгол Улсын парламентын засаглалын онцлог




Эх сурвалж: Г. Дугаржав, Ерөнхий сайдыг томилох, засгийн газрыг бүрдүүлэх үйл явцад Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн хэрэгжүүлж байгаа эрх үүрэгт хийсэн шинжилгээ. Төрийн Удирдлагын докторын зэрэг горилсон бүтээл, 2018 он, х. 32.

Төрийн байгуулал нь иргэний эрх чөлөөг хамгаалах, нийтийн эрхийг хангах, эрх зүйт төрийн үйл ажиллагааг эрхлэх үүрэг хүлээхийн зэрэгцээ иргэний тэгш эрхийг хангахын тулд төрийн үйл ажиллагааг “ил тод” нээлттэй байдлаар зохион байгуулах, “иргэдийн оролцоо”-г тэгш хангах замаар нийгмийн бүлэг, давхаргын “төлөөллийн зарчмыг” алдагдуулахгүй байх нөхцөлийг эрх зүйн суурь зарчим болгон ажилладаг. Төрийн үйл ажиллагаа “ил тод” байх зарчмыг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн хоёрдугаар заалтыг үндэс болгож “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-аар хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэг хүлээсэн байдаг. Энэхүү Үндсэн хуулийн үзэл баримтлалыг улс төрийн намууд нь “Улс төрийн намын тухай хууль”-ийн намын үйл ажиллагааны зарчмын (5 дугаар зүйл) дагуу эрхлэхдээ Үндсэн хуулийн “иргэний эвлэлдэн нэгдэх эрх”-ийг тулгуур болгож, иргэдийн сайн дурын оролцоог үндэслэдэг. Иргэдийн сайн дурын оролцоог Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 10 дугаар заалтаар баталгаажуулж, иргэдийг үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дүгээр заалт болох хүн бүр “хуулийн өмнө тэгш байх” зарчмыг суурь болгон улс төрийн тэгш оролцоог “Сонгуулийн тухай хууль”-ийн 2 дугаар бүлэг, 11 дүгээр зүйлээр хуульчилсан, иргэний “сонгох”, “сонгогдох” гарааны тэгш боломжийг хангаж ажиллах ёстой юм.

Улс төрийн оролцооны үүрэг нь нийгмийн бүлэг, давхаргын төлөөллийн зарчмыг алдагдуулахгүй байхын тулд Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дугаар заалтыг үндэслэн “хүн бүр эрх зүйн этгээд” байх зарчмын дагуу төлөөлөл бодит байх нөхцөлийг бүрдүүлж, төлөөлөл тэгш оролцоотой байлгах зарчмыг эрхэмлэдэг. Төлөөллийн тэгш оролцоог хангах чиглэлд Монгол Улс нь “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль”-ийн үзэл баримтлал, суурь зарчмаар хүнийг “үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол” үл харгалзан нийгмийн харилцаанд тэгш оролцох боломжийг бүрдүүлэх үүргийг төрийн үйл ажиллагаанд хүлээжээ. Иргэний тэгш оролцоо, ил тод байдал, төлөөллийн зарчим нь “төр-иргэн” хоорондын харилцаанд иргэний нийгмийн тухай ойлголтыг илэрхийлдэг.

“Төр-Иргэн” хоорондын харилцааны үндэс болсон иргэний нийгмийн байгууллагын хөгжил, түүний төлөвшлийг Монгол Улсад 1992 оны Үндсэн хууль баталсан цагаас хөхүүлэн дэмжиж ирсэн байна. 1997 онд Төрийн бус байгууллагын тухай хуулийг баталж хэрэгжүүлэхдээ “иргэн” зөвхөн төлөөллийн сонгуулийн зарчмаар дөрвөн жил тутам улс төрийн оролцоотой байх биш харин улс төрийн шийдвэрт хяналттай байх нөхцөлийг төр нэг талаас хангаж, иргэн нь нөгөө талаас улс төр, эдийн засаг болон нийгмийн харилцаанд иргэний нийгмийн байгууллагаар уламжлан ардчиллыг хөгжүүлэх, нийгэмд эв санааны үнэт зүйлсийг бүтээх боломжийг илэрхийлэх үүрэг хүлээжээ. Монгол Улсад төлөөллийн зарчмын хэрэгжилтийг дараах гурван түвшинд

хуульчилсан байдаг. Нэгдүгээрт, төлөөллийн байгууллага болох УИХ болон Ерөнхийлөгчийн сонгуульд шууд оролцож, өөрийн үзэл бодлоо чөлөөтэй сонгуулиар дамжуулан илэрхийлж, төлөөллийг хангах, хоёрдугаарт, нутгийн удирдлага, засаг захиргааны нэгжийн түвшинд орон нутгийн сонгуулиар ИТХ-ын гишүүдийг сонгох, гуравдугаарт, иргэний нийгмийн байгууллага, улс төрийн намын үйл ажиллагааны түвшинд сайн дурын оролцоотой өөрсдийн улс төр, эдийн засаг, нийгмийн ашиг сонирхлыг төлөөлөх эсвэл төлөөлүүлэн хэрэгжүүлэх боломжийг хуульчилж өгсөн байна.

Ардчилалд зөвхөн хүний эрх чөлөөт байдлыг хангах, иргэдийг тэгш эрхтэй оролцуулж, ил тод, нээлттэй төлөөллийн зарчмыг хэрэгжүүлэхээс илүүтэй иргэд нийгмийн амьдралд шууд үр нөлөөтэй, үүрэг хариуцлагатай оролцох соёлыг төлөвшүүлэх нь ардчилсан нийгмийн орчин үеийн хөгжлийн чиг хандлага болж байна (ШУА-ийн Философийн хүрээлэн, 2017, p. 135). Иймээс иргэний “хяналттай” байх гэдэг ойлголт нь “иргэн төвтэй” хүмүүнлэг нийгмийн хөгжлийн гол зорилт болж байдаг. Иргэн хүн эрх чөлөөтэй байхын салшгүй шинж нь төрийн буюу нийтийн үйл хэрэгт шууд болон төлөөллөөрөө дамжуулан оролцож, сонгож байгуулсан төрийн бодлого, үйл ажиллагаанд хяналт тавих боломжтой байх явдал мөн. Хяналт иргэдийн оролцоогоор дамжиж хэрэгжих бөгөөд энэ нь гол төлөв нийгмийн хариуцлага, улс төрийн шийдвэрийн үр дагаварыг ухамсарласан иргэдийн хамтач оролцооны хэлбэр байдгаараа онцлог юм.

Ардчилсан засаглал дахь иргэний хяналтыг “тэгш өрсөлдөөний нөхцөлтэй байлгах”, “төрийн эрх мэдлийн хяналт-тэнцвэр хангагдсан байх”, “засаглах чадавхтай байх” гэсэн гурван үзүүлэлтээр тодорхойлж ойлгодог. Уг ойлголтын онолын суурь зарчмыг Монгол Улсад Үндсэн хуулийн гуравдугаар зүйлийн нэгдүгээр заалтаар “Засгийн бүх эрх ард түмний мэдэлд” байна гэж тодорхойлсон нь нэгдүгээрт, иргэний “хяналттай байх” тухай ойлголтыг хуульчилж, хоёрдугаарт улс төрийн төлөөллийн хариуцлагыг сонгуулиар дөрвөн жил тутам хянах механизмыг бүрдүүлсэн байна. Нийгмийн харилцаанд иргэн бүрийн тэгш өрсөлдөх нөхцөлийг Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дугаар заалтаар “хүн бүр хуулийн өмнө тэгш байх” зарчмаар хуульчилж, нас хүйс үл харгалзан тэгш өрсөлдөх боломжийг “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль”-ийн 5 дугаар зүйлээр зохицуулж, төрийн үйл ажиллагааг чиглүүлжээ.

Тэгш өрсөлдөх нөхцөлийн суурь үндэс нь хүн бүрт гарааны ижил нөхцөл олгогдсон байх явдал юм. Төлөөллийн ардчилсан тогтолцоо бүхий улс төрийн сонгуульд өрсөлдөх гарааны нөхцөл ижил байх зарчмыг Монгол Улсад “Сонгуулийн тухай хууль”-ийн 7 дугаар зүйлд тодруулж, иргэн хүн болон улс төрийн нам нь улс төрийн сонгуульд гарааны ижил нөхцөлтэй байх тухай үзэл баримтлалыг тус хуулийн 28 дугаар зүйлд хуульчилсан байна. Өөрөөр хэлбэл улс төрийн нам үүсгэн байгуулахад 801 хүний итгэмжлэл бүхий гарын үсэг,

иргэн хувь хүнийнхээ чөлөөт сонголтоор улс төрийн сонгуульд оролцох, нэр дэвших үед дэмжигч 801 хүний итгэмжлэл бүхий гарын үсгээр сонгуульд бие даан өрсөлдөх нөхцөл бүрдүүлж оролцох эрхтэй байхаар хуульчилсан. Төлөөллийн эрхийн уг зарчмыг Үндсэн хуулийн үзэл санаагаар зураглан үзүүлбэл (зураг 8):

**Зураг 8. УИХ ба төлөөллийн зарчим**




Тухайлбал, Монгол Улсын Их Хурлын гишүүнээр 1992-1996 оны хооронд нэг бие даагч, 1996-2000 оны хооронд бие даагч сонгогдоогүй, 2000-2004 оны хооронд нэг бие даагч, 2004-2008 оны хооронд гурван бие даагч, 2008-2012 оны хооронд нэг бие даагч, 2012-2016 оны хооронд гурван бие даагч, 2016 оны сонгуульд нэг бие даагч тус бүр сонгогдож, төлөөллийн байгууллагын төлөөлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлж байсан байна (https://mn.wikipedia.org/wiki/Улсын_Их_Хурал, хандсан 2019.01.11). Иргэн бүр улс төрийн оролцоонд тэгш эрхтэй өрсөлдөх боломжийг хуульчлахын зэрэгцээ төлөөлөгч эрх эдлэхдээ иргэдийн өмнө хариуцлага хүлээх ёстой гэсэн Гоббсын үзэл баримтлалыг Монгол Улсын төрийн байгуулал дахь төлөөллийн байгууллагын төлөөлөгч, УИХ-ын гишүүн нь Үндсэн хуулийн 23 дугаар зүйлийн 2 дугаар заалтаар "төрийн сүлдэнд тангараг өргөснөөр бүрэн эрх"-ийг хэрэгжүүлэх үүрэг хүлээж, Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн 1 дүгээр заалтаар "бүрэн эрхийн хугацаанд улсын төсвөөс цалин авах" гэж хуульчилжээ.

Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу УИХ-ын гишүүн бол монголын ард түмний элч төлөөлөгч бөгөөд төлөөлөх бүрэн эрхийн хэрэгжилтийг сонгосон иргэд нь хянаж байхаар зохицуулагдсан байна. Учир нь УИХ-ын гишүүдийн бүрэн эрх гагцхүү иргэдээс эх сурвалжтай байж, иргэдийн сонголтоор баталгааждаг бөгөөд "төрийн эрх барих" төлөөллийн байгууллагын хувьд "иргэний сайн сайхны төлөө" ажиллах үүрэг хүлээдэг билээ. Мөн "Улсын төсвөөс цалинжих" нь Руссогийн нийгмийн гэрээний онолын ойлголт, "нийтийн эрхийг хамгаалах" үүрэгтэйн нэг баталгаа бөгөөд "төрийн сүлдэнд тангараг өргөснөөр бүрэн эрх"- нь эхэлдэг. Өөрөөр хэлбэл, УИХ-ын гишүүд,

Үндсэн хууль болон бусад хуулийг чандлан сахиж өргөсөн тангарагаа зөрчихгүй байх улс төр, эрх зүйн өндөр хариуцлага хүлээдэг Монгол Улсын нийт иргэдийн элч юм. Харин манай Үндсэн хууль болон эрх зүйн бусад зохицуулалтад УИХ-ын гишүүд улс төрийн болон ёс зүйн хариуцлага хүлээх зохицуулалт ерөнхий бөгөөд сул хийгдсэнийг судлаачид тэмдэглэдэг. Хэрэв гишүүд өөрсдөө ёс зүйн хариуцлагаа ухамсарлахгүй л бол хуулиар тэдэнтэй иргэдийн хяналт, шаардлагаар хариуцлага ярих бололцоо үндсэндээ байхгүй юм.

Төлөөллийн байгууллагын бүрэн эрхийн баталгааг Үндсэн хуулийн 22 дугаар зүйлийн 2 дугаар заалтаар "бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь үзсэнээр ..... өөрөө тарах шийдвэр гаргаж болно" гэж хуульчилсан байдаг нь иргэн эрх чөлөөтэй байх, тэгш эрхээр хангагдсан байх, төрийн эрх иргэний эрхээр хязгаарлагдаж, иргэний хяналттай байх зарчмуудыг хэрэгжүүлэхэд хүндрэл учруулдаг. Энэ нь суурь агуулгаараа засгийн бүх эрх зөвхөн ард түмний "бүрэн эрх"-д хадгалагдах тухай үзэл санаатай зөрчилдсөн зохицуулалт гэж үзэх үндэслэлтэй байгаа юм. Өөрөөр хэлбэл, УИХ гэх төлөөллийн байгууллагын бүрэн эрх зөвхөн иргэдийн сонголтын баталгаа гэсэн агуулга энд бүрхэг болж Томас Гоббсын "Төр-Иргэний харилцааны" зарчим "эрх шилжүүлсэн нөхцөлд хариуцлага үүрэх" тухай ойлголтын агуулгыг ч илэрхийлж чадахгүй байна.

Үндсэн хуулийн 23 дугаар зүйлийн 2 дугаар заалтаар "Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн" баримтлана гэж хуульчилсан байдал төлөөллийн ардчиллын суурь зарчмууд хэрэгжих боломжийг нээж байна гэж үзэж болно. Чухамхүү эндээс л төрийн эрх мэдлийг Локк, Монтескье нарын онолын дагуу гурван салаанд хуваарилсан байх зарчмын "хяналт-тэнцвэрийг хангах ба Check and Balance" хэрэгжилтийг иргэний эрх чөлөө, тэгш эрх, иргэний хяналтын өнцгөөс зохицуулалт хийх төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмууд урган гардаг байна. (зураг 9).

**Зураг 9. Төрийн байгуулал дахь эрх мэдлийн хуваарилалт**

| Монгол Улсын төрийн эрх мэдлийн хуваарилалт | | |
|---|---|---|
| Хууль тогтоох | Гүйцэтгэх | Шүүх |
| Эрх чөлөө, тэгш эрх иргэний хяналт | | |
| Улсын Их Хурал | Засгийн газар Ерөнхийлөгч | Улс дээд шүүх |

Хууль тогтоох, бодлого тодорхойлох бүрэн эрх нь иргэдийн хараат бус чөлөөт сонголтоор буюу иргэдийн эрх чөлөө, тэгш эрх, иргэний хяналтын хүрээнд парламентад олгогдсон дээд эрх мэдэл, харин хууль, төрийн бодлогыг хэрэгжүүлэх дээд эрх мэдэл төлөөллийн ардчиллын дээрх эрх зүйн суурь зарчмууд парламентаас засгийн газарт хүлээлгэж буй итгэл, парламентын хяналтаар дамжиж хэрэгжих учиртай. Шүүн таслах дээд эрх мэдлийн хувьд шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлөөс сонгон шалгаруулж, нэр дэвшүүлснийг Ерөнхийлөгчийн зарлигаар томилдог (Галбаатар, Л., 2018, pp. 117-149). Ингэж томилогдсон шүүгчид нь иргэний эрх чөлөө, тэгш эрх, иргэний хяналтыг хангаж ажиллах эрх зүйн ерөнхий зохицуулалт бий.

Монгол Улсад "төрийн эрх барих дээд байгууллага" буюу хууль тогтоох засаглалыг УИХ, нэг танхимтай 76 гишүүнтэйгээр 1992 оноос хэрэгжүүлж байна. Төрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх үүднээс хууль тогтоох байгууллага гүйцэтгэх засаглалыг байгуулж байна уу? Эсвэл гүйцэтгэх засаглалын тэргүүн ард түмний сонголтоор бүрэн эрхээ хэрэгжүүлэх үүрэг хүлээж байна уу гэдгээс хамаарч засаглалын мөн чанарын тухай асуудал хэлэлцдэг ба энд Ерөнхийлөгчийн засаглалтай байх тухай эсвэл Парламентын засаглалтай байх асуудал юм (зураг 7).

Монгол Улсад гүйцэтгэх засаглалыг УИХ-аас байгуулдаг байх, мөн УИХ-ын өмнө хариуцлага хүлээдэг байх удирдлагын хэлбэрийг сонгосон (Энхбаатар, Ч., 2017, p. 41). Энэ ч утгаар УИХ-д олонх болсон нам эвсэл гүйцэтгэх засаглалын тэргүүн болох Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох, чөлөөлөх асуудлыг Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 6 дугаар заалтын дагуу хариуцан ажилладаг. Эрх мэдлийн хуваарилалтын зарчмын хүрээнд 38 дугаар зүйлийн 1 дүгээр заалт "Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн" гэж тодорхойлсны зэрэгцээ үйл ажиллагааны чиг үүргийг хуульчилсан. Үндсэн хуулийн үзэл баримтлалын хүрээнд УИХ болон ЗГ-ын харилцааны асуудал нь 1992 оноос өнөөг хүртэл нийгмийн амьдралд улс төрийн олон талт маргаан дагуулж байна. Учир нь УИХ буюу хууль тогтоох байгууллагад төсвийн болон томилгооны эрх мэдлээс гадна ЗГ-ын бүтэц бүрэлдэхүүн, нэгж гишүүн бүрийг хэлэлцэх давуу эрхийг УИХ-ын гишүүнд (Үндсэн хуулийн 39 дүгээр зүййин 3 дугаар заалт) олгосон байдаг нь төрийн байгуулал дахь улс төрийн маргааныг өдөөх нөхцөл болдог (Энхбаатар, Ч., 2017, pp. 52-57).

Гүйцэтгэх засаглалын тогтвортой байдал бол засаглах чадавхыг илэрхийлэх үндсэн агуулга боловч онолын түвшинд хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын хоорондын эрх мэдлийн хяналт-тэнцвэрийг хангасан байна гэсэн утга илэрхийлдэггүй. Тийм ч учраас парламентын засаглалтай улс орнуудын улс төрийн практикт гүйцэтгэх засаглалын тэргүүн, Ерөнхий сайдын байр суурийг бэхжүүлэх зорилгоор тухайн парламентад олонх болсон улс төрийн нам дангаар байгуулж буй нөхцөлд намын дарга, хэрэв эвслийн засгийн газрыг байгуулах бол эвсэл дотроо хамгийн олон суудал

авсан намын даргыг Ерөнхий сайдаар томилдог. Монгол Улсад 1992-2018 оны хооронд 17 Ерөнхий сайдыг томилж, чөлөөлж байсан түүхээс дүгнэлт хийвэл Засгийн газрын үйл ажиллагааны чадавх сул байна гэсэн дүгнэлт хийх боломжтой юм. Гэхдээ энэ нь үйл ажиллагааны чадавх сул болохыг дангаар тодорхойлж чадахгүй. Эрх зүйн зохицуулалтаас гадна өөр нөлөөлж буй олон зүйл байгааг судлаачид онцолсон байдаг (Энхбаатар, Ч., 2017, p. 33) Эрх мэдлийн хуваарилалт, хяналт-тэнцвэрийн онолын асуудлын хүрээнд босоо болон хэвтээ тэнхлэгт эрх мэдэл шилжүүлж (horizontal versus vertical) хэрэгжүүлэх гэсэн ойлголт байдаг. Энэ нь иргэд зөвхөн УИХ, Ерөнхийлөгчийн сонгуульд оролцох эрхтэй байх, дөрвөн жилийн сонгуулийн давтамжтай иргэний хяналттай байхаас илүүтэйгээр тухайн төрийн байгуулал дахь засаг захиргааны нэгжийн зохион байгуулалтын түвшинд иргэний эрх чөлөө, тэгш эрх, иргэний хяналтын механизмыг хэрэглэх боломж бүрдсэн эсэх тухай асуудал юм.

Уг зохицуулалтыг "нутгийн өөрөө удирдах ёс" гэж тодорхойлох бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн 4 дүгээр бүлэгт эрх зүйн зохицуулалтыг хуульчилсан (Үндсэн хуулийн 57 дугаар зүйлээс 63 дугаар зүйл). Үндсэн хуулийн 59 дугаар зүйлийн 1 дүгээр заалт "Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр хэрэгжүүлнэ" хэмээн тодорхойлсон байдал, "Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын хууль"-ийн 6 дугаар зүйлийн 2 дугаар заалт "аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд, сум, дүүргийн Засаг даргыг харьяалах аймаг, нийслэлийн Засаг дарга..... томилно" гэж хуульчилсан байдлаас нутгийн өөрөө удирдах ёсны бие даасан эрх болох "subsidiarity" зарчим байхгүй байна (зураг 10). Нутгийн өөрөө удирдах ёсны бие даасан байх зарчим нь олон улсын түвшинд харилцан адилгүй хэрэгждэг.

**Зураг 10. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тогтолцоо**



Монгол Улс 1992 онд ардчилсан засаглалд шилжихдээ төвлөрсөн удирдлагын тогтолцоо бүхий засаг захиргааны нэгжийг нутгийн өөрөө удирдах ёстой (vertical separation of powers) хослуулах оролдлого хийжээ. Онолын түвшинд засаг захиргааны нэгжийн бие даасан байдлыг ХБНГУ-д (тулгуур хуулийн 28 зүйлийн 2 дугаар заалт ба Субсидиар зарчим) дараах үзүүлэлтээр хэмждэг. Үүнд:

- Хүний нөөцийг бие даан шийдвэрлэх эрх (Personalhoheit),
- Нутаг дэвсгэрийн бие даасан эрх (Gebietshoheit)
- Зохион байгуулалтын бие даасан эрх (Organisationhoheit)
- Эрх зүйн шийдвэр гаргах бие даасан эрх (Satzungshoheit)
- Санхүүгийн эрх (Finanzhoheit)
- Албан татварын эрх (Abgabenhoheit)
- Төлөвлөлтийн эрх (Planungshoheit)
- Оршихуйн асуудлыг бие даан шийдвэрлэх эрх (Daseinvorsorge)

Судлаач, Ханс Келсен өөрийн бүтээлдээ засаг захиргааны нэгжийн түвшинд эрх үүрэг хуваарилах зарчим (vertical separation of powers) гэх ойлголтын суурь нь хүний халдашгүй байдал байх бөгөөд төрийн байгуулал дахь тогтолцоонд анхан шатны байгууллагын үйл ажиллагаанаас эхлэлтэй байна гэсэн санааг дэвшүүлсэн байдаг (Kelsen, 1960). Гэхдээ нутаг дэвсгэрийн бие даасан эрх зүйн зохицуулалт нь тухайн улсын уламжлал, түүхэн хөгжил, засаг захиргааны нэгжийн зохион байгуулалтаас хамаардаг болохыг онцлох нь зүйтэй юм. "Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын хууль"-иар орон нутаг нь төрийн удирдлагыг хэрэгжүүлэхдээ засаг захиргааны нэгжийн удирдлагыг томилох, чөлөөлөх давуу эрхтэй Засгийн газрын гүйцэтгэлийн дагуу нутгийн өөрөө удирдах ёсны зарчмыг хослуулан хэрэгжүүлэх гэсэн эрх зүйн орчинтой байгааг Монгол улсад төрийн байгуулалтын түүхэн улбаатай байгааг германы судлаач тэмдэглэжээ (Koenig, Klaus, 1977, p. 406).

***Дескриптив шинжилгээний хоёрдугаар асуулт:***

- Төрийн байгуулал дахь институцийн үйл ажиллагаанд "иргэний эрх чөлөө, хяналт, тэгш эрх"-ийн зарчмыг хэрхэн уялдуулсан байна вэ?

Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу төрийн байгуулал дахь институцийн үйл ажиллагааны зарчмыг 1 дүгээр зүйлийн 2 дугаар заалтаар "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх" хэмээн тодорхойлсон байна. Монгол Улсын төрийн байгууллын институцууд засаглалын үйл явцад энэ үзэл баримтлалыг хэрэгжүүлэхдээ "иргэний эрх чөлөө, тэгш эрх, иргэний хяналт"-тай байх эрх зүйн суурь зарчмыг хэрхэн хангасныг болон УИХ, Засгийн газар, Ерөнхийлөгчийн институц, Шүүх засаглал, Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагууд дээр дурдсан зарчмуудыг "Төр-Иргэн" хоорондын харилцаанд ашиглах боломж хэр бүрдүүлснийг уг шинжилгээгээр тодруулсан болно.

Үндсэн хуулийн үзэл баримтал нь хүний эрх чөлөөг дээдэлсэн, иргэний тэгш оролцоотой, хяналттай байх нөхцлийг хуульчилсан, "Төр-Иргэн" хоорондын харилцаа шууд хамааралтай байхаар зохицуулагдсан байдлыг Үндсэн хуулийн гуравдугаар бүлэгт тодорхой хэмжээнд хийжээ. Харин иргэдийн оролцооны тэгш эрх, иргэний шууд хяналттай байх нөхцөлийг 2015 оны хууль тогтоомжийн тухай хуулийн нийтлэг үндэслэлээр "ил тод, нээлтэй байх, нийтийн оролцоог хангасан байх, ашиг сонирхлын зөрчилгүй байх"-аар, хувь иргэний шууд оролцоог "бичгээр санал авах, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах, санал асуулга зохион байгуулах, олон нийтийн цахим сүлжээгээр хэлэлцүүлэг өрнүүлэх" аргаар хангаж ажиллах үүрэг хүлээхээр эрх зүйн хувьд нэгтгэн зохицуулжээ. Нэг талаас ийм нэмэлт зохицуулалт хийгдээд удаагүй байгаа, нөгөө талаас төрийн үйл ажиллагаа иргэдэд чиглэгдэж байдаг ч иргэдийн зүгээс энэ шинэ арга замыг хэр оновчтой ашиглаж байна вэ? гэсэн асуудлыг судлах шаардлага гарч байна.

Иргэний тэгш оролцооны боломжийг эрх зүйн зохицуулалтаар нээлттэй байлгахын зэрэгцээ 2015 оны Нийтийн сонголын тухай хуулийн нийтлэг зарчмаар 1). Иргэний эрх чөлөө хангаж ажиллах зорилт нь "иргэний мэдэх эрх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хангах", 2). Иргэний тэгш оролцоог хангаж ажиллахдаа "хууль дээдлэх, талуудын оролцоог тэгш хангах, үр нөлөөтэй байх" зарчмыг баримтлана хэмээн хуульчилсан байна. Энэ хуулийн үзэл баримтлалын гол агуулга нь иргэн бүрийн эрх чөлөө зөвхөн өөрсдийн сайн дурын оролцоо, идэвхид тулгуурласан байдлаар хангагдах ёстой гэсэн санаанд үндэслэжээ. Өөрөөр хэлбэл иргэний эрх чөлөөний тухай Үндсэн хуулийн үзэл санаа "иргэний халдашгүй байх" зарчим нь нэг талаас эрх чөлөөг сонгох боломж хувь хүнд олгож, нөгөө талаас иргэн хүний боловсрол, хувь хүний төлөвшлийн асуудлыг давхар хөндөж байна гэсэн үг юм.

Улс төрийн оролцоо тэгш байх боломжийг бүрдүүлэхээс илүүтэй "Төр-иргэн" хоорондын харилцаанд "иргэний хяналт" байх ёстой гэсэн үзэл ойлголт байдаг. Монгол Улсын Үндсэн хуулийн өөрчлөлт шинэчлэлийн асуудлын хүрээнд "иргэний оролцоог хангасан байх", "иргэний хяналттай байх" гэсэн зарчмыг 2017 онд батлагдсан" Зөвлөлдөх санал асуулгын тухай" хуулинд тусгасан байдаг. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 1 дүгээр заалт "иргэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, төлөөллийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдлэнэ" гэх Гоббсын суурь зарчмын дагуу засаглалын үйл ажиллагаанд иргэний оролцоог хангах, төрийн үйл ажиллагааг хяналттай байлгах зорилгоор засаг захиргааны түвшинд улс төрийн шийдвэрийг "Зөвлөлдөх санал асуулгын тухай" хуулийг ашиглах боломж олгосон байна. Төр өөрөө "нийгэм эдийн засгийн асуудлыг иргэний тусламжтай" илрүүлэх, төрийн зүгээс дэвшүүлж буй санал, шийдэлд иргэний саналыг "зөвлөлдөх" замаар тусгах, төр "иргэнд мэдээлэл өгөх" үүрэг хүлээж байгааг тодруулсан байдлаас ардчиллыг иргэд рүү ойртуулсан байдал ажиглагдаж байна.

Төрийн үйл ажиллагаа нь хараат бус, үр нөлөөтэй байх аргаар иргэний нийгмийн хөгжлийг дэмжихэд чиглэдэг. Судлаачдын үзэж байгаагаар Монгол Улсад иргэний нийгмийн байгууллага бүрэн утгаар хөгжөөгүй байна. Иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааг дэмжсэн эрх зүйн орчин ч хангалттай бүрдээгүй бөгөөд 1997 онд батлагдсан хуульд өнөөдрийг хүртэл дорвитой өөрчлөлт ороогүй нь иргэний нийгмийн байгууллагуудын өнөөгийн шаардлагыг хангаж чадахгүйд хүрчээ.

Дескриптив судалгааны мэдээллийг нэгтгэн дүгнэж үзвэл дурдсан хоёр асуудлаар дараах дүгнэлт хийж болохоор байна. Үүнд: **Нэгдүгээрт**, Иргэний эрх чөлөө, тэгш эрх, иргэний хяналттай байх тухай эрх зүйн суурь зарчим Монгол Улсын Үндсэн хууль, түүнийг дагалдаж гарсан холбогдох гол хуулиудад ерөнхий үзэл баримтлалын хувьд тусгагдсан боловч тэгш эрх, иргэний хяналтын зарчмыг илүү нарийвчилах шаардлага байна. **Хоёрдугаарт,** ардчилал, ардчилсан засаглалын судалгааны хүрээнд төлөөллийн ардчилал дахь иргэний эрх чөлөө, тэгш эрх, иргэний хяналттай байх эрх зүйн суурь зарчмуудын талаар хийгдсэн дүгнэлтүүдээс үзэхэд үндсэн зохицуулалт нэгэнт бий болсон хэдий ч олон нийтийн хүртээл болж хэрэгжих байдал хангалтгүй байна. **Гуравдугаарт**, Монгол Улсын төрийн байгууллын эрх мэдлийн хуваарилалтын зарчимд чиг үүрэг, харилцан хамаарал, үйл ажиллагааны хяналт тэнцэл нь онолын хувьд ч, олон улсын жишгийн хувьд ч хангалтгүй хуульчлагдсан нь төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмуудын хэрэгжилтэд сөрөг нөлөө үзүүлж байна (Үндсэн хуулийн 3 дугаар бүлэгт).

## 4.2. Асуулгын судалгааны өгөгдөл боловсруулалт

Асуулгын судалгаанд нийт 601 өрх бүрээс 18-аас дээш насны нэг иргэн төлөөлөл болон хамрагдлаа. Үүнээс судалгааны боловсруулалтад хүчинтэй **524** өрхийн судалгааг ашигласан болно. Энэ нь судалгааны 95%-ийн итгэх түвшинтэй 4 хувийн хэлбэлзэлтэй 599 өрхийн түүврийн хэмжээнд хүрэхгүй байгаа учраас судалгааны найдвартай байдлын хэлбэлзэлийг 1% бууруулж 95%-ийн итгэх түвшинтэй 5 хувийн хэлбэлзэлтэй түүврийн хэмжээнд найдвартай байдлын түвшинг хангасан /**384** өрх/ болно. Ийнхүү Улаанбаатар хотын 5 дүүргийн 524 иргэний хариултад боловсруулалт хийлээ.

Өгөгдөл боловсруулалтын хамгийн эхэнд судалгааны асуулгын дотоод найдвартай байдлыг Cronbach's Alpha коеффициентоор тодорхойлсон. Иргэдийн ардчиллын тухай ойлголтыг тодорхойлсон 57 асуултын тогтвортой байдал буюу Cronbach's Alpha коеффициент нь **0.984**, ардчиллын хэрэгжилтийг тодорхойлсон 19 асуултын Cronbach's Alphaкоеффициент нь **0.928**, төрийн институцийн үйл ажиллагааны хэрэгжилтийг тодорхойлсон 11 асуултын Cronbach's Alpha коеффициент нь **0.910** тус тус гарсан нь бүгд 0.7-оос дээш буюу асуултууд хоорондоо тогтвортой байгааг илтгэж байна (Тооцооллын үр дүнг хавсралт 3-д үзүүлэв).

**Хүснэгт 2. Асуулгын найдвартай байдлын түвшин**

| № | Ардчиллын тухай иргэдийн ойлголт | Ардчиллын хэрэгжилт | Төрийн институцийн үйл ажиллагааны хэрэгжилт |
|---|---|---|---|
| **Cronbach's Alpha коэффициент** | **0.984** | **0.928** | **0.910** |

Эх сурвалж: SPSS "23.0" программын тооцооллын үр дүн

Харин судалгаанд оролцогчдын насны бүлгээр хэвийн тархалтыг шалгахад The Skewness & Kurtosis z-утга нь **3.79** [-1.96;1.96], The Shapiro-Wilk p-утга нь **-2.69** [0.05;∞] хязгаарт хоёулаа харъяалагдахгүй учир хэвийн тархалтын нөхцөл хангагдаагүй болно. Үүнд судалгааны санхүүжилттэй уялдуулан сонгосон түүврийн онцлог (дүүрэг бүрээс гэр, байшин, холимог хороолол сонгосон, тухайн өрхийн 18-аас дээш насны нэг иргэнээс анкет бөглүүлсэн) нь нөлөөлсөн байж болно (Тооцооллын үр дүнг хавсралт 4-гаас үзнэ үү).

Асуулга судалгаанд оролцогчдын хүн ам зүйн шинж, төлөөллийн төлөөлөх чадварыг тодорхойлохдоо нас, хүйс, боловсрол, оршин суугаа газар, ажил эрхлэлтийн байдал, ам бүлийн тоо, өрхийн сарын дундаж орлого, шашин шүтлэгийн байдлыг судлан үзэж үр дүнг дараах байдлаар нэгтгэлээ.

Судалгаанд оролцогчдыг насны бүлгээр авч үзвэл 13 хувь нь 18-24, 13 хувь нь 25-29, 13 хувь нь 30-34, 11 хувь 35-39, ..... , 6 хувь нь 65-аас дээш насныхан эзэлж байна (зураг 11).

**Зураг 11. Судалгаанд оролцогчдын нас (хувиар)**




Эх сурвалж: SPSS "23.0" программын тооцооллын үр дүн

Зургаас үзэхэд судалгаанд насны бүлгийн төлөөлөл жигд хамрагдсан байна.

Судалгаанд оролцогчдыг хүйсийн бүтцээр нь судлан үзвэл 66 хувь нь эмэгтэй, 34 хувь нь эрэгтэй байна (зураг 12). Асуулга судалгааны түүврийг бүрдүүлэхдээ энгийн санамсаргүй түүврийн аргаар сонгогдсон хаяг, байршилд хамаарах өрхийн нэг гишүүнээс судалгааг авахаар төлөвлөсөн байсан.

**Зураг 12. Судалгаанд оролцогчдын хүйс (хувиар)**




Эх сурвалж: SPSS "23.0" программын тооцооллын үр дүн

Асуулгын судалгааг авах тухайн цаг хугацаанд өрхийн эмэгтэй гишүүн ихэвчлэн гэртээ байснаас шалтгаалан хүйсийн төлөөлөх чадвар алдагдахад хүрсэн. Энэ нь хүйсийн төлөөлөл бүрэн хангагдаагүй сул талтай боловч дээрх аргаар түүврийн төлөөллийг бүрдүүлэхдээ 18-аас дээш насны 2-оос дээш гишүүнтэй нэг өрхийн иргэдээс санамсаргүй түүврийн зарчмаар сонголт хийх шаардлагатайг харуулж байна.

Судалгаанд оролцогчдыг боловсролын түвшингээр харьцуулан авч үзвэл 39 хувь нь дээд, 11 хувь нь мэргэжлийн боловсрол, 44 хувь нь бүрэн дунд боловсрол, 5 хувь нь суурь боловсрол, 1 хувь нь бага болон боловсролгүй иргэд байна (зураг 13).

**Зураг 13. Судалгаанд оролцогчдын боловсролын түвшин (хувиар)**




Эх сурвалж: SPSS "23.0" программын тооцооллын үр дүн

Судалгааны түүврийг бүрдүүлэхдээ Улаанбаатар хотын 6 дүүргээс сонгосон хороодын нийт 366961 өрхөөс энгийн санамсаргүй түүврийн аргаар, 95%-ийн итгэх түвшинд 599 өрх сонгогдохоор тооцоологдсон. Өрхийн байршлыг судлан үзвэл 9 хувь нь Сүхбаатар дүүрэг, 19 хувь нь Баянгол дүүрэг, 13 хувь нь Чингэлтэй дүүрэг, 32 хувь нь Баянзүрх дүүрэг, 27 хувь Сонгино-хайрхан дүүрэгт харьяалагдаж байна (зураг 14).

**Зураг 14. Судалгаанд оролцогчдын оршин суугаа газар (хувиар)**




Эх сурвалж: SPSS "23.0" программын тооцооллын үр дүн

Судалгаанд оролцогчдын 13 хувь нь төрийн байгууллагад, 26 хувь нь хувийн хэвшилд, 16 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлдэг, 1 хувь нь төрийн бус байгууллагад ажилладаг, 20 хувь нь тэтгэвэрт, 6 хувь нь оюутан суралцагч, 18 хувь нь ажил эрхэлдэггүй иргэд байна (зураг 15).

**Зураг 15. Судалгаанд оролцогчдын хөдөлмөр эрхлэлтийн байдал (хувиар)**




Эх сурвалж: SPSS "23.0" программын тооцооллын үр дүн

Зургаас харахад судалгаанд хөдөлмөр эрхлэлтийн ерөнхий бүлгийн төлөөлөл жигд хамрагдсан байгааг харж болно. Судалгаанд оролцогчдын өрхийн гишүүдийн тооны эзлэх хувийг (зураг 16) гаргаж зургаар үзүүлэв.

**Зураг 16. Судалгаанд оролцогчдын ам бүлийн тоо (хувиар)**




Эх сурвалж: SPSS "23.0" программын тооцооллын үр дүн

Өрхийн сарын дундаж орлогыг судлан үзвэл 74 хувь нь 1 сая хүртэл төгрөг, 18 хувь нь 1-1,5 сая төгрөг, 8 хувь нь 1,5 саяас дээш төгрөгийн сарын орлоготой байна. (зураг 17)

Энэхүү судалгааг авахдаа эх олонлогыг төлөөлөх чадварыг хангах үүднээс гэр хороолол, байшин хороолол, холимог хороолол гэсэн ангиллаар хороодыг сонгож түүврийг бүрдүүлэхэд 1 сая хүртэл төгрөгийн сарын дундаж орлоготой өрх дийлэнх хувийг эзэлж байна.

**Зураг 17. Судалгаанд оролцогчдын өрхийн сарын дундаж орлого (хувиар)**




Эх сурвалж: SPSS "23.0" программын тооцооллын үр дүн

Иргэдийн шашин шүтлэгийн байдлыг сонирхож үзэхэд 47 хувь нь буддын шашин, 2 хувь нь христийн шашин, 8 хувь нь бөө мөргөл, 43 хувь шашин шүтдэггүй иргэд байна (зураг18).

**Зураг 18. Судалгаанд оролцогчдын шашин шүтлэгийн байдал (хувиар)**




Эх сурвалж: SPSS "23.0" программын тооцооллын үр дүн

Асуулга судалгааны ерөнхий мэдээллийн асуултуудын боловсруулалтын үр дүнгээс нэгтгэн дүгнэж авч үзвэл түүвэр бүрдүүлэх арга зүйн дагуу түүврээ бүрдүүлсэн бөгөөд судалгааны төсөв, хугацаа, хувь хүний мэдээллийн нууц зэргээс хамааран түүврийн нэгжид иргэн биш өрхийг сонгоход хүрсэн гэдгийг анхаарах хэрэгтэй.

Иргэний эрх чөлөө, иргэний тэгш эрх, иргэний хяналтын суурь зарчмуудыг тодорхойлсон тулгуур эрх зүйн баримт бичгүүд болох Үндсэн хууль, Сонгуулийн тухай хууль, Иргэний хуулийн талаарх иргэдийн мэдлэгийн түвшинг нь үнэлүүлэхэд 60 хувь нь Үндсэн хуулийн талаарх, 55.5 хувь нь Сонгуулийн тухай хуулийн талаарх, 57.9 хувь нь Иргэний хуулийн талаарх мэдлэгийн түвшингээ дунд зэрэг болон түүнээс дээш гэж хариулжээ (хүснэгт 3).

**Хүснэгт 3. Судалгаанд оролцогчдын холбогдох хуулиудын талаарх мэдлэгийн түвшин (хувиар)**

| Мэдлэгийн түвшин | Үндсэн хууль | Сонгуулийн тухай хууль | Иргэний хууль |
|---|---|---|---|
| Маш сайн | 2,8 | 2,0 | 2,4 |
| Сайн | 10,4 | 11,5 | 10,9 |
| Дунд зэрэг | 46,8 | 42,0 | 44,6 |
| Муу | 16,3 | 16,2 | 15,3 |
| Маш муу | 8,0 | 9,5 | 9,3 |
| Мэдэхгүй | 15,7 | 18,8 | 17,5 |
| **Бүгд** | **100,0** | **100,0** | **100,0** |
| Минимум утга | 5 | 5 | 5 |
| Максимум утга | 1 | 1 | 1 |
| **Дундаж утга** | **3,19** | **3,24** | **3,22** |
| **Эрэмбэ** | **I** | **III** | **II** |

Эх сурвалж: SPSS "23.0" программын тооцооллын үр дүн

Дээрх хуулиудын талаарх иргэдийн мэдлэгийн түвшний үнэлгээний дундаж утгыг тооцож эрэмбэлэхэд нэгдүгээрт, Үндсэн хуулийн талаарх мэдлэгийн түвшин (дундаж утга 3.19), хоёрдугаарт, Иргэний хуулийн талаарх мэдлэгийн түвшин (дундаж утга 3.22), гуравдугаарт, Сонгуулийн тухай хуулийн талаарх мэдлэгийн түвшин (дундаж утга 3.24) эрэмбэлэгдэж байна. Өөрөөр хэлбэл, 1992 оноос хойш нийт 7 удаагийн УИХ болон Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүнгээс улбаалан иргэдийн сонгуулийн боловсрол, танин мэдэхүй нэг талаас сайжирсан байдал ажиглагдаж байгаа хэдий ч эсрэгээрээ сонгуулийн ирц жил ирэх тусам буурч буй байдал нь боловсрол дээшлэх тусам иргэдийн сонгуульд оролцох сонирхол буурч байгааг илтгэж байна.

Дундаж утгыг бодож гаргахдаа мэдэхгүй гэж хариулсан оролцогчдын хариултыг боловсруулалтаас хасч бодсон. Тухайн асуултын өгөгдлийг боловсруулахдаа 1-5 оноогоор /1 буюу маш сайн, 5 буюу маш муу/ дүгнэж

гаргасан ба ерөнхий дундаж утга нь 3 оноо болно. Иргэдийн өгсөн хариултын дундаж утгаас харахад дээрх хуулиудын талаарх иргэдийн мэдлэг нь ерөнхий дунджаас доогуур түвшинд байна.

Асуулгын судалгааны хүрээнд 1990 оноос эхлэлтэй Ардчилал нь судалгаанд хамрагдсан иргэний амьдралд хэрхэн нөлөөлсөн болон Монгол Улсын ардчиллын хөгжилд өгөх ерөнхий төсөөллийн үнэлгээг тодруулах зорилгоор 2 асуултыг асуусан.

Ардчилал нь судалгаанд хамрагдсан иргэний амьдралд хэрхэн нөлөөлсөн талаарх төсөөллийн үнэлгээг нэгтгэн авч үзвэл 14.8 хувь нь эерэг, 13.8 хувь нь сайн тал нь давамгайлсан, 55.7 хувь нь сайн муу аль аль талаараа, 10.4 хувь нь муу тал нь давамгайлсан, 5.4 хувь нь сөрөг нөлөө үзүүлсэн гэж хариулжээ (зураг19). Хариултын дундаж утгыг гаргаж үзэхэд 2.78 хувьтай /1 буюу эерэг, 5 буюу сөрөг/ байна. Эндээс дүгнэж авч үзвэл судалгаанд оролцогчид Ардчилал тэдний амьдралд ерөнхий дундаж гуравтай харьцуулахад эерэгээр нөлөөлсөн гэж үзсэн байна.

**Зураг 19. Судалгаанд оролцогчдын ардчиллын нөлөөллийн талаарх төсөөлөл (хувиар)**




Эх сурвалж: SPSS "23.0" программын тооцооллын үр дүн

Монгол Улсын ардчиллын хөгжилд өгөх ерөнхий төсөөллийн үнэлгээг нэгтгэн авч үзвэл 1 хувь нь маш сайн, 13.2 хувь нь сайн, 57.1 хувь нь дунд зэрэг, 22 хувь нь муу, 6.8 хувь нь маш муу гэсэн үнэлгээг өгчээ (зураг19).Хариултын дундаж утгыг гаргаж үзэхэд 3.20 хувьтай /1 буюу маш сайн, 5 буюу маш муу/ байна. Дундаж утгаас харахад иргэдийн Монгол Улсын ардчиллын хөгжилд өгөх ерөнхий төсөөллийн үнэлгээ муу тал руу хэлбийсэн байна. Өөрөөр хэлбэл улс төрийн дэглэмийн өөрчлөлт нийгмийн гишүүдийн 13.8 хувьд давуу боломж

олгосон байхад муу тал нь давамгайлсан нь 10.4 хувьтай байгаа нь нийгэмд "тэгш эрхийн" хэрэгжилт сул байгааг харуулж байна.

**Зураг 20. Судалгаанд оролцогчдын ардчиллын хөгжлийн талаарх төсөөлөл (хувиар)**




Эх сурвалж: SPSS "23.0" программын тооцооллын үр дүн

Ардчилал нь иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлсөн болон Монгол Улсын ардчиллын хөгжилд өгөх ерөнхий төсөөллийн үнэлгээг хооронд нь харьцуулан үзвэл ардчилал амьдралд нь эерэг нөлөө үзүүлж байгаа боловч ардчиллын хөгжлийн түвшинг муу гэж дүгнэжээ.

Асуулгын судалгааны дараагийн багц асуултууд нь судалгаанд оролцогчдын ардчиллын талаарх ойлголтын түвшинг үнэлүүлэх 57 асуулт, ардчиллын хэрэгжилтийн түвшинг үнэлүүлэх 19 асуулт, төрийн институцийн үйл ажиллагааны хэрэгжилтийн түвшинг үнэлүүлэх 11 асуултаас бүрдэж байна. Судалгаанд оролцогчдоор ардчиллын талаарх ойлголтын түвшинг үнэлүүлэхдээ "Ардчилал"-ын тухай ойлголтыг хэмжих Бульманны арга зүйн дагуу 3 шалгуур үзүүлэлтийг гаргаж, түүнийг 9 дэд үзүүлэлт, үүнийгээ дахин 19 дэд үзүүлэлтэд задалж, 19-н үзүүлэлтээ 57 асуултад хөрвүүлсэн. (хүснэгт 4)

**Хүснэгт 4. Ардчиллын талаарх ойлголтын түвшинг үнэлэх шалгуур үзүүлэлт**

<table>
<tr><th>№</th><th>Ойлголт</th><th>3 дэд үзүүлэлт</th><th>9 дэд үзүүлэлт</th><th>19 дэд үзүүлэлт</th><th>Асуулт</th></tr>
<tr><td>1</td><td rowspan="19">Ардчилал</td><td rowspan="7">Иргэний эрх чөлөө</td><td rowspan="3">Хувийн эрх чөлөө</td><td>Амьд явах эрх</td><td>3 асуулт</td></tr>
<tr><td>2</td><td>Халдашгүй байх эрх</td><td>3 асуулт</td></tr>
<tr><td>3</td><td>Чөлөөт сонголт хийх эрх</td><td>3 асуулт</td></tr>
<tr><td>4</td><td rowspan="2">Нийтийн эрх</td><td>Эвлэлдэн нэгдэх эрх</td><td>3 асуулт</td></tr>
<tr><td>5</td><td>Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх</td><td>3 асуулт</td></tr>
<tr><td>6</td><td rowspan="2">Эрх зүйт төр</td><td>Хуулийн өмнө тэгш байх</td><td>3 асуулт</td></tr>
<tr><td>7</td><td>Шүүхийн байгууллага бие даасан байх</td><td>3 асуулт</td></tr>
<tr><td>8</td><td rowspan="6">Иргэний тэгш эрх</td><td rowspan="2">Ил тод байдал</td><td>Төрийн үйл ажиллагаа илт тод байх</td><td>3 асуулт</td></tr>
<tr><td>9</td><td>Улс төрийн намын үйл ажиллагаа ил тод байх</td><td>3 асуулт</td></tr>
<tr><td>10</td><td rowspan="2">Иргэний оролцоо</td><td>Улс төрийн тэгш оролцоо</td><td>3 асуулт</td></tr>
<tr><td>11</td><td>Иргэний сайн дурын оролцоо</td><td>3 асуулт</td></tr>
<tr><td>12</td><td rowspan="2">Төлөөллийн зарчим</td><td>Төлөөлөл тэгш оролцоотой байх</td><td>3 асуулт</td></tr>
<tr><td>13</td><td>Төлөөлөл бодит байх</td><td>3 асуулт</td></tr>
<tr><td>14</td><td rowspan="6">Иргэний хяналт</td><td rowspan="2">Тэгш өрсөлдөөн</td><td>Өрсөлдөх тэгш боломж</td><td>3 асуулт</td></tr>
<tr><td>15</td><td>Өрсөлдөх горааны нөхцөл</td><td>3 асуулт</td></tr>
<tr><td>16</td><td rowspan="2">Эрх мэдлийн хяналт-тэнцвэр</td><td>УИХ, ЗГ-ын харилцаа</td><td>3 асуулт</td></tr>
<tr><td>17</td><td>Нутгийн өөрөө удирдах ёс</td><td>3 асуулт</td></tr>
<tr><td>18</td><td rowspan="2">Засаглах чадавх</td><td>ЗГ-ын үйл ажиллагааны чадавх</td><td>3 асуулт</td></tr>
<tr><td>19</td><td>Нутгийн өөрөө удирдах байгууллагын бие даасан байдал</td><td>3 асуулт</td></tr>
</table>

Тайлбар: Дэлгэрэнгүйг "хавсралт 1. Анкетийн загвар"-аас үзнэ үү.

Энэхүү үнэлгээ нь 1-5 оноогоор дүгнэх /1 буюу ойлголтгүй, 2 буюу ойлголт бага, 3 буюу бүрэн бус ойлголттой, 4 буюу ойлголттой, 5 буюу бүрэн ойлголттой/ байдлаар боловсруулагдсан. Судалгаанд оролцогчдын ардчиллын талаарх ойлголтыг төсөөллийн үнэлгээг дээр дурдсан 1-5 хүртлэх оноогоор дүгнүүлж дундаж утгыг гаргасан. Ойлголтыг хэмжих 3, 9, 19 дэд үзүүлэлт бүрийн дундаж утгыг онооны дараалаар эрэмбэлсэн. Ингэхдээ "мэдэхгүй" гэсэн хариултыг боловсруулалт-аас хасч гаргалаа. (Тооцооллын дэлгэрэнгүй үр дүнг хавсралт 5-д үзүүлэв).

Судалгаанд оролцогчдын ардчиллын талаарх ойлголтын төсөөллийн үнэлгээний дундаж утгыг гаргаж, "иргэний эрх чөлөө", "иргэний тэгш эрх", "иргэний хяналт" гэсэн 3 үзүүлэлтийн хувьд бүлэглэн авч үзвэл "иргэний эрх чөлөө"-ний дундаж утга 2.67 буюу 1 дүгээрт, "иргэний тэгш эрх"-ийн дундаж утга 2.54 буюу 2 дугаарт, "иргэний хяналт"-ын тухай ойлголтын дундаж утга 2.43 буюу 3 дугаарт эрэмбэлэгдэж байна. Дээрх гурван үзүүлэлтийн хувьд судалгаанд хамрагдсан оролцогч "иргэний эрх чөлөө"-ний талаарх ойлголтын

түвшингээ "иргэний тэгш эрх", "иргэний хяналт"-тай байх тухай харьцуулахад илүү гэж үзсэн байна. Гэхдээ дээрх 3-н үзүүлэлтийн хувьд дундаж утга нь ерөнхий дунджаас дээгүүр байна (хүснэгт 5).

**Хүснэгт 5. Судалгаанд оролцогчдын төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмуудын талаарх өөрийн ойлголтын төсөөлөл, түүний эрэмбэ (дундаж утгаар)**

| 3 дэд үзүүлэлт | 9 дэд үзүүлэлт | Минимум утга | Максимум утга | Дундаж утга | 3 дэд үзүүлэлтийн эрэмбэ | 9 дэд үзүүлэлтийн эрэмбэ |
|---|---|---|---|---|---|---|
| **Иргэний эрх чөлөө** | Хувийн эрх чөлөө | 1 | 5 | 2,82 | **I** | **I** |
| | Нийтийн эрх | 1 | 5 | 2,67 | | **III** |
| | Эрх зүйт төр | 1 | 5 | 2,53 | | **IV** |
| | **Бүгд** | **1** | **5** | **2,67** | | |
| **Иргэний тэгш эрх** | Ил тод байдал | 1 | 5 | 2,46 | **II** | **VI** |
| | Иргэний оролцоо | 1 | 5 | 2,69 | | **II** |
| | Төлөөллийн зарчим | 1 | 5 | 2,46 | | **VII** |
| | **Бүгд** | **1** | **5** | **2,54** | | |
| **Иргэний хяналт** | Тэгш өрсөлдөөн | 1 | 5 | 2,41 | **III** | **VIII** |
| | Эрх мэдлийн хяналт-тэнцвэр | 1 | 5 | 2,40 | | **IX** |
| | Засаглах чадавх | 1 | 5 | 2,49 | | **V** |
| | **Бүгд** | **1** | **5** | **2,43** | | |
| **НИЙТ** | | **1** | **5** | **2,55** | | |

Эх сурвалж: SPSS "23.0" программын тооцооллын үр дүн

Харин 9 дэд үзүүлэлтийн хувьд "Хувийн эрх чөлөө" нэгдүгээрт, "Иргэний оролцоо" хоёрдугаарт, "Нийтийн эрх" гуравдугаарт, "Эрх зүйт төр" дөрөвдүгээрт, "Засаглах чадавх" тавдугаарт, "Ил тод байдал" зургаадугаарт, "Төлөөллийн зарчим" долоодугаарт, "Тэгш өрсөлдөөн" наймдугаарт, "Эрх мэдлийн хяналт-тэнцвэр" есдүгээрт эрэмбэлэгдэж байна. Өөрөөр хэлбэл, төлөөлийн ардчиллын эрх зүйн суурь зарчмуудын хэрэгжилтийн тухай иргэдийн ойлголт, төсөөлөл иргэний эрх чөлөөтэй байдал гэх ойлголтоор давуу илэрхийлэгдэхийн зэрэгцээ өөрсдийн эрх чөлөө нь эрх мэдлийн хяналт-тэнцвэр буюу эрх мэдлийн хуваарилалтын зарчмаар баталгаажих тухай ойлголт сул байгааг илтгэж байна.

Судалгаанд оролцогчдоор төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмуудын хэрэгжилтийн түвшинг үнэлүүлэхдээ дээр дурдсан 19 дэд үзүүлэлтийг 19 асуултад хөрвүүлж 1-5 оноогоор дүгнэх /1 буюу муу, 2

буюу дунджаас доогуур, 3 буюу дундаж, 4 буюу дунджаас дээгүүр, 5 буюу сайн/ хэлбэрээр боловсруулагдсан. Судалгаанд оролцогчдын ардчиллын хэрэгжилтийн түвшний талаарх төсөөллийн үнэлгээг дээр дурдсан 1-5 хүртэлх оноогоор дүгнүүлж дундаж утгыг гарган, 3, 9, 19 дэд үзүүлэлт бүрт дундаж утгыг онооны дараалаар эрэмбэлсэн. Ингэхдээ "мэдэхгүй" гэж хариулсан хариултыг боловсруулалтаас хасч тооцлоо (Тооцооллын дэлгэрэнгүй үр дүнг хавсралт 6-д хавсаргав).

Судалгаанд оролцогчдын төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмуудын хэрэгжилтийн түвшний талаарх төсөөллийн үнэлгээний дундаж утгыг тооцож, "иргэний эрх чөлөө", "иргэний тэгш эрх", "иргэний хяналт" гэсэн 3 дэд үзүүлэлтийн хувьд бүлэглэн авч үзвэл "иргэний хяналт"-ын дундаж утга 2.46 буюу 1 дүгээрт, "иргэний тэгш эрх"-ийн дундаж утга 2.42 буюу 2 дугаарт, "иргэний эрх чөлөө"-ний дундаж утга 2.41 буюу 3 дугаарт эрэмбэлэгдэж байна. Дээрх гурван үзүүлэлтийн хувьд судалгаанд оролцогчдын "иргэний хяналт"-ын талаарх ойлголтын түвшингээ "иргэний тэгш эрх", "иргэний эрх чөлөө"-ний тухай ойлголттой харьцуулахад илүү гэж үзсэн байна. Гэхдээ дээрх 3-н үзүүлэлтийн хувьд дундаж утга нь ерөнхий дунджаас доогуур байна (хүснэгт 6).

Харин есөн дэд үзүүлэлтийн хувьд "Иргэний оролцоо" нэгдүгээрт, "Нийтийн эрх" хоёрдугаарт, "Тэгш өрсөлдөөн" гуравдугаарт, "Төлөөллийн зарчим" дөрөвдүгээрт, "Засаглах чадавх" тавдугаарт, "Хувийн эрх чөлөө" зургаадугаарт, "Эрх мэдлийн хяналт-тэнцвэр"долоодугаарт, "Эрх зүйт төр" наймдугаарт, "Ил тод байдал" есдүгээрт эрэмбэлэгдэж байна.

**Хүснэгт 6. Судалгаанд оролцогчдын төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмуудын хэрэгжилтийн өнөөгийн байдлын талаарх ойлголтын төсөөлөл, түүний эрэмбэ (дундаж утгаар)**

| 3 дэд үзүүлэлт | 9 дэд үзүүлэлт | Минимум утга | Максимум утга | Дундаж утга | 3 дэд үзүүлэлтийн эрэмбэ | 9 дэд үзүүлэлтийн эрэмбэ |
|---|---|---|---|---|---|---|
| **Иргэний эрх чөлөө** | Хувийн эрх чөлөө | 1 | 5 | 2,40 | **III** | **IV** |
| | Нийтийн эрх | 1 | 5 | 2,71 | | **II** |
| | Эрх зүйт төр | 1 | 5 | 2,12 | | **VIII** |
| | **Бүгд** | **1** | **5** | **2,41** | | |
| **Иргэний тэгш эрх** | Ил тод байдал | 1 | 5 | 2,11 | **II** | **IX** |
| | Иргэний оролцоо | 1 | 5 | 2,79 | | **I** |
| | Төлөөллийн зарчим | 1 | 5 | 2,36 | | **VI** |
| | **Бүгд** | **1** | **5** | **2,42** | | |
| **Иргэний хяналт** | Тэгш өрсөлдөөн | 1 | 5 | 2,68 | **I** | **III** |
| | Эрх мэдлийн хяналт-тэнцвэр | 1 | 5 | 2,30 | | **VII** |
| | Засаглах чадавх | 1 | 5 | 2,38 | | **V** |
| | **Бүгд** | **1** | **5** | **2,46** | | |
| **НИЙТ** | | **1** | **5** | **2,43** | | |

Эх сурвалж: SPSS "23.0" программын тооцооллын үр дүн

Гурван дэд үзүүлэлтийн хувьд төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмуудын хэрэгжилтийн түвшний талаарх төсөөллийн үнэлгээний дундаж нь ардчиллын талаарх ойлголтын түвшний төсөөллийн үнэлгээний дундаж утгаас бага байна. Мөн дээрх гурван дэд үзүүлэлтийн эрэмбэ нь ойлголт болон хэрэгжилтийн хувьд урвуу хамааралтай байгаа нь сонирхол татаж байна. Энэ нь судалгаанд оролцогчид өөрийн ойлголтын түвшин бусадтай харьцуулахад муу гэж үзэж байхад харин хэрэгжилтийн түвшинг бусадтай харьцуулахад харьцангуй сайн гэж үзэж байгааг илэрхийлж байна. Есөн дэд үзүүлэлтийн дундаж утгын эрэмбэ нь мөн адил ойлголт болон хэрэгжилтийн талаарх төсөөллийн үнэлгээний хувьд ялгаатай байна (хүснэгт 7).

**Хүснэгт 7. Судалгаанд оролцогчдын ардчиллын эрх зүйн суурь зарчмуудын талаарх өөрийн ойлголт, суурь зарчмуудын хэрэгжилтийн өнөөгийн байдлын талаарх төсөөллийн үнэлгээний эрэмбэ, харьцуулалт /дундаж утгаар, 3 ба 9 дэд шалгуур үзүүлэлтээр/**

| | | Ойлголтын түшвин | | | Хэрэгжилтийн түвшин | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 дэд үзүүлэлт | 9 дэд үзүүлэлт | Дун-даж утга | 3 дэд үзүүлэлт-ийн эрэмбэ | 9 дэд үзүүлэлт-ийн эрэмбэ | Дун-даж утга | 3 дэд үзүүлэлт-ийн эрэмбэ | 9 дэд үзүүлэлт-ийн эрэмбэ |
| **Иргэний эрх чөлөө** | Хувийн эрх чөлөө | 2,82 | I | **I** | 2,40 | III | **IV** |
| | Нийтийн эрх | 2,67 | | **III** | 2,71 | | **II** |
| | Эрх зүйт төр | 2,53 | | **IV** | 2,12 | | **VIII** |
| | **Бүгд** | **2,67** | | | **2,41** | | |
| **Иргэний тэгш эрх** | Ил тод байдал | 2,46 | II | **VI** | 2,11 | II | **IX** |
| | Иргэний оролцоо | 2,69 | | **II** | 2,79 | | **I** |
| | Төлөөллийн зарчим | 2,46 | | **VII** | 2,36 | | **VI** |
| | **Бүгд** | **2,54** | | | **2,42** | | |
| **Иргэний хяналт** | Тэгш өрсөлдөөн | 2,41 | III | **VIII** | 2,68 | I | **III** |
| | Эрх мэдлийн хяналт-тэнцвэр | 2,40 | | **IX** | 2,30 | | **VII** |
| | Засаглах чадавх | 2,49 | | **V** | 2,38 | | **V** |
| | **Бүгд** | **2,43** | | | **2,46** | | |
| **НИЙТ** | | **2,55** | | | **2,43** | | |

Эх сурвалж: SPSS "23.0" программын тооцооллын үр дүн

Дээрх 9 дэд үзүүлэлтийн иргэдийн ойлголт болон хэрэгжилтийн төсөөллийн үнэлгээний хувьд 19 дэд үзүүлэлтээр нарийвчлан задалж дундаж утга, эрэмбийн дарааллыг харьцуулан авч үзвэл дараах байдалтай байна (хүснэгт 8).

**Хүснэгт 8. Судалгаанд оролцогчдын төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмуудын талаарх өөрийн ойлголт, суурь зарчмуудын хэрэгжилтийн өнөөгийн байдлын талаарх төсөөллийн үнэлгээний эрэмбэ, харьцуулалт /дундаж утгаар, 19 дэд үзүүлэлтээр/**

| № | Үзүүлэлт | Ойлголт | | Хэрэгжилт | | Эрэмбийн өөрчлөлт |
|---|---|---|---|---|---|---|
| | | дундаж | эрэмбэ | дундаж | эрэмбэ | |
| 1 | Амьд явах эрх | 2,78 | III | 2,18 | XIV | -11 |
| 2 | Халдашгүй байх эрх | 2,75 | IV | 2,39 | IX | -5 |
| 3 | Чөлөөт сонголт хийх эрх | 2,93 | I | 2,61 | V | -4 |
| 4 | Эвлэлдэн нэгдэх эрх | 2,64 | VI | 2,67 | IV | +2 |
| 5 | Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх | 2,71 | V | 2,75 | III | +2 |
| 6 | Хуулийн өмнө тэгш байх | 2,47 | XII | 2,13 | XVI | -4 |
| 7 | Шүүхийн байгууллага бие даасан байх | 2,59 | XIII | 2,11 | XVII | -9 |
| 8 | Төрийн үйл ажиллагаа илт тод байх | 2,55 | IX | 2,16 | XV | -6 |
| 9 | Улс төрийн намын үйл ажиллагаа ил тод байх | 2,37 | XIX | 2,06 | XIX | 0 |
| 10 | Улс төрийн тэгш оролцоо | 2,79 | II | 3,00 | I | 1 |
| 11 | Иргэний сайн дурын оролцоо | 2,60 | VII | 2,57 | VI | 1 |
| 12 | Төлөөлөл тэгш оролцоотой байх | 2,45 | XIV | 2,37 | XI | 3 |
| 13 | Төлөөлөл бодит байх | 2,47 | XI | 2,34 | XII | -1 |
| 14 | Өрсөлдөх тэгш боломж | 2,44 | XV | 2,99 | II | 13 |
| 15 | Өрсөлдөх гарааны нөхцөл | 2,38 | XVIII | 2,38 | X | 8 |
| 16 | УИХ, ЗГ-ын харилцаа | 2,41 | XVI | 2,08 | XVIII | -2 |
| 17 | Нутгийн өөрөө удирдах ёс | 2,39 | XVII | 2,53 | VII | 10 |
| 18 | ЗГ-ын үйл ажиллагааны чадавх | 2,51 | X | 2,24 | XIII | -3 |
| 19 | НӨУБ-ын бие даасан байдал | 2,47 | XIII | 2,52 | VIII | -5 |

Дээрх 19 үзүүлэлтийн иргэдийн ойлголт болон хэрэгжилтийн төсөөллийн үнэлгээний эрэмбийн зөрүүг тооцож үзэхэд хэрэгжилтийн хувьд 2 үзүүлэлт хүчтэй савласан буюу 4-өөр эрэмбэ хойшилсон, 8 үзүүлэлт 1 эрэмбээр урагшилсан, 9 үзүүлэлт нь өөрчлөгдөөгүй байна. Тухайлбал, хүний "халдашгүй байдал"-ыг ойлголтын түвшинд сайн гэж үнэлсэн хэдий ч төрийн байгуулал дахь институцийн үйл ажиллагааны хэрэгжилтийн үнэлгээнд муу буюу 4 баллаар ухрааж үнэлсэн байдал нь хүний "халдашгүй байх" тухай хуулийн хэрэгжилт сул байгааг иргэд өөрсдийн төсөөллийн дагуу үнэлсэн байдал харагдаж байна. Мөн улс төрийн намын үйл ажиллагааны ил тод байдлын тухай ойлголтыг үнэлсэн байдал нь хэрэгжилтийн үнэлгээнд доошилсон байдал нь "төлөөллийн зарчим" болох Бульманны тодорхойлсон агуулгыг илэрхийлж чадахгүй байгааг илтгэхийн зэрэгцээ улс төрийн намын төлөвшлийн асуудлыг хөндөж байгааг тодруулжээ.

Дээрх 19 үзүүлэлтийн хувьд "амьд явах эрх", "шүүхийн байгууллага бие даасан байх", "төрийн үйл ажиллагаа ил тод байх", "өрсөлдөх тэгш боломж", "нутгийн өөрөө удирдах ёс", "өрсөлдөх гарааны нөхцөл" зэрэг үзүүлэлтүүдийн ойлголтын талаарх үнэлгээний эрэмбэ болон хэрэгжилтийн талаарх үнэлгээний эрэмбэ хооронд нилээд зөрүү гарсан байна.

Бульманны аргачлалаар олон жилийн хугацаанд давтамжтайгаар судалгаа хийсэн улс орнуудын хувьд "ардчиллын талаарх иргэдийн ойлголтын түвшин дээшлэх тусам иргэдийн сонголт, оролцоо, хяналт, хариуцлагад эерэг өөрчлөлт гарч улмаар ардчиллын хэрэгжилтэд эерэг нөлөө үзүүлдэг" гэсэн Габриэль Алмондын "улс төрийн соёлын" тухай ойлголтын нийтлэг дүр зураг ажиглагдаж байгаа юм. Өөрөөр хэлбэл ардчилалд ардчилагч хэрэгтэй гэсэн санаа юм. Энэхүү судалгааны хувьд иргэдийн ойлголтын түвшин болон хэрэгжилтийн талаарх төсөөллийн үнэлгээ хоорондоо уялдаатай байгаа дүр зураг харагдаж байна.

Төрийн байгуулал дахь институцийн үйл ажиллагааны хэрэгжилтийн түвшинг үнэлүүлэхдээ нийт 11 байгууллагыг сонгон авч, тэдгээрийн үйл ажиллагааг иргэдээр 1-5 оноогоор дүгнүүлсэн /1 буюу муу, 2 буюу дунджаас доогуур, 3 буюу дундаж, 4 буюу дунджаас дээгүүр, 5 буюу сайн/. Төрийн байгуулал дахь институцийн үйл ажиллагааны хэрэгжилтийн талаарх төсөөллийн үнэлгээг дээр дурдсан 1-5 хүртэлх оноогоор дүгнүүлж дундаж утгыг тооцон, дундаж утгыг онооны дараалаар эрэмбэлсэн. Ингэхдээ "мэдэхгүй" гэж хариулсан оролцогчдын хариултыг боловсруулалтаас хасч гаргалаа (Тооцооллын дэлгэрэнгүй үр дүнг хавсралт 7-д хавсаргав).

Судалгаанд оролцогчдын төрийн байгуулал дахь институцийн үйл ажиллагааны хэрэгжилтийн талаарх төсөөллийн үнэлгээний дундаж утгыг гаргаж эрэмбэлэн хүснэгтээр үзүүлэв.

Хүснэгтээс харвал судалгаанд оролцогчид дүүргийн захиргааны байгууллагыг бусадтай харьцуулахад үйл ажиллагааны хэрэгжилт хамгийн сайн, улс төрийн намууд бусадтай харьцуулахад хамгийн муу гэж дүгнэгдсэнийг харж болно.

**Хүснэгт 9. Судалгаанд оролцогчдын төрийн байгууллагуудын үйл ажиллагааны хэрэгжилтийн өнөөгийн байдлын талаарх төсөөлөл, эрэмбэ**

| Байгууллага | Минимум утга | Максимум утга | Дундаж утга | Эрэмбэ |
|---|---|---|---|---|
| Улс төрийн намууд | 1 | 5 | 2,135 | XI |
| Улсын Их Хурал | 1 | 5 | 2,140 | X |
| Шүүх | 1 | 5 | 2,142 | IX |
| Прокурор | 1 | 5 | 2,19 | VIII |
| Үндсэн хуулийн цэц | 1 | 5 | 2,24 | VII |
| Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал | 1 | 5 | 2,39 | VI |
| Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал | 1 | 5 | 2,449 | V |
| Засгийн газар /Ерөнхий сайд, Засгийн газар, яам, агентлаг/ | 1 | 5 | 2,451 | IV |
| Нийслэлийн захиргааны байгууллага /Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, харьяа агентлагууд/ | 1 | 5 | 2,52 | III |
| Ерөнхийлөгчийн институц | 1 | 5 | 2,59 | II |
| Дүүргийн захиргааны байгууллага /Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, харьяа агентлагууд/ | 1 | 5 | 2,65 | I |
| **Дундаж** | **1** | **5** | **2,35** | |

Эх сурвалж: SPSS “23.0“ программын тооцооллын үр дүн

Энэхүү судалгааны хүрээнд төрийн байгуулал дахь институцуудын хоорондын хамаарлыг судалж үзээгүй боловч дээрх дундаж утга, түүний эрэмбээс нэгтгэн дүгнэж, төрийн байгуулал дахь институцуудын үйл ажиллагаа хоорондоо хамааралтай гэж үзвэл улс төрийн намуудын үйл ажиллагаа УИХ-ын үйл ажиллагаанд нөлөөлсөн; УИХ-ын үйл ажиллагаанаас бусад институцуудын үйл ажиллагаа хамаарсан; “Ардчилал”-ын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах үүрэгтэй шүүх, прокурор, ҮХЦ-ийн үйл ажиллагаа хангалтгүй байгаа нь эргээд төрийн байгуулал дахь институцийн үйл ажиллагааны хэрэгжилт бүхэлдээ хангалтгүй байхад нөлөөлсөн; орон нутгийн захиргааны байгууллага нь гүйцэтгэх чиг үүргийг бодитоор хэрэгжүүлдэг, иргэдтэй тулж ажилладаг гэдэг утгаараа бусадтай харьцуулахад харьцангуй өндөр үнэлгээ авсан зэрэг нь Монголын нийгэмд үүсээд байгаа өнөөгийн бодит байдлын ерөнхий дүр зургийг илэрхийлжээ гэж үзэх боломжтой юм. Энэхүү үр дүн нь сонирхолтой бөгөөд цаашид дэлгэрүүлэн судлах шаардлагатай, анхаарал татсан асуудал гэдгийг илэрхийлж байна. Дээр дурдсан дүр зураг нь 19 үзүүлэлтээр иргэдийн ойлголт болон хэрэгжилтийн төсөөллийн үнэлгээний дундаж утга, эрэмбийн зөрүүг тооцож үзэхэд хэрэгжилтийн хувьд гарсан “Улс төрийн намын үйл ажиллагаа ил тод байх” үзүүлэлттэй давхцаж байгаа нь иргэд асуулгын судалгаанд хариулахдаа бодитоор хандсаныг нотлож байна.

Эцэст нь асуулгын судалгааны үр дүнг нэгтгэн авч үзвэл нэгдүгээрт, ардчиллын тухай иргэдийн ойлголтын түвшин дунджаар **2.55**, ардчиллын хэрэгжилтийн түвшин дунджаар **2.43**, төрийн байгуулал дахь институцийн үйл ажиллагааны түвшин **2.355** үнэлгээтэй байна.

Хоёрдугаарт, төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмуудын талаарх иргэдийн ойлголтыг **Т-тест**ийн аргаар 2-оос бага уу? гэж шалгахад Т-тестийн тооцоолсон утга **11.301**, 95%-ийн итгэх түвшинд ач холбогдлын түвшин **α=0.000** буюу 0.05-аас бага гарч 2-оос ялгаагүй гэдэг нь нотлогдохгүй байна. Т-тестийн тооцооллын үр дүнг хавсралт 9-д хавсаргав. Харин ойлголтын дунджийг **3-аас** бага уу? гэж шалгахад Т-тестийн тооцоолсон утга -**9.330**, 95%-ийн итгэх түвшинд ач холбогдлын түвшин **α=0.000** буюу 0.05-аас бага гарч иргэдийн ойлголтын түвшин үнэлгээний дунджаас доогуур гэдэг нь нотлогдлоо.

Төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмуудын талаарх иргэдийн ойлголт, хэрэгжилтийн талаарх төсөөллийн үнэлгээг 9-н дэд үзүүлэлтийн хувьд зургаар илэрхийлэн харуулвал дараах байдалтай байна (зураг 21).

**Зураг 21. Төлөөллийн ардчиллын суурь зарчмуудын талаарх ойлголт, хэрэгжилтийн төсөөллийн үнэлгээ (9-н дэд үзүүлэлтээр)**




Эх сурвалж: Судлаачийн тооцоолсон

Тайлбар:

IF - Хувийн эрх чөлөө, RS -Эрх зүйт төр, OF -Нийтийн эрх, WE - Тэгш өрсөлдөөн, GK - Эрх мэдлийн хяналт-тэнцвэр, RF - Засаглах чадамж, TR - Ил тод байдал, PA - Иргэний оролцоо, RE - Төлөөллийн зарчим

Зураг 21-ээс харахад иргэдийн ойлголтыг тодорхойлсон 9 үзүүлэлтүүд хоорондоо жигд тэнцвэртэй [2.4;2.82][4] байна. Суурь зарчмуудын хэрэгжилтийг үнэлсэн үнэлгээний хувьд уг 9 үзүүлэлт [2.11;2.79] хооронд хоорондоо жигд тэнцвэртэй байгаа болович үүний далайц[5] нь ойлголтын түвшний далайцтай харьцуулахад бага байна. Нөгөө талаас үнэлгээний хамгийн их утга 5-тай

[4] Математикийн тэмдэглэгээгээр хооронд гэдгийг [] хаалт хэрэглэдэг болно.

[5] Далайц гэдэг статистикийн утгаараа интервалын хамгийн их, хамгийн бага утга хоёрын зөрүү юм.

харьцуулахад иргэдийн ойлголтын түвшний дундаж нь 50 хувьтай ойролцоо түвшинд байна.

Бульманны аргачлалаар судалгаа хийсэн улс орнуудын хувьд ойлголтын түвшний өөрчлөлтийн зураглалыг гаргаж аль үзүүлэлт дээр анхаарал хандуулах шаардлагатайг тодруулсан байдаг. Бидний авсан энэхүү судалгааны ардчиллын талаарх иргэдийн ойлголтын түвшний зураглалыг харьцангуй төсөөтэй 2 улсын зураглалтай жишээ болгон харьцуулан үзвэл дараах байдалтай байна (зураг 22).

**Зураг 22. Финлянд, АНУ /1995, 2005 он/ болон Монгол улсын иргэдийн ардчиллын талаарх ойлголтын түвшний харьцуулалт /2018 он/**



Бульманны аргачлалаар судалгаа хийгдсэн улс орнуудын хувьд 9-н дэд үзүүлэлтүүдийн дундаж утга харьцангуй ялгаатай ба зарим үзүүлэлт 100 хувьд нилээд дөхсөн байгаа бол Монгол улсын хувьд харьцангуй жигд, дундаж утга нь 50 хувьтай ойролцоо түвшинд байгаа нь иргэдийн ойлголтын түвшинг нэмэгдүүлэх шаардлагатай байгааг илэрхийлж байна.

Судалгааны багийн гишүүд судалгааны арга зүйг боловсруулахдаа асуулгын судалгааны хүрээнд судалгаанд оролцогчдод ардчиллын талаар тэнцвэртэй мэдээллийг “Зөвлөлдөх санал асуулгын тухай хуулийн” дагуу хүргэж асуулгын судалгааг дахин давтаж авахад үр дүн нь хэрхэн өөрчлөгдөх вэ? гэсэн асуултад хариулт авах үүднээс нэмэлт ажлыг төлөвлөсөн.

Энэхүү нэмэлт ажил нь судалгаанд оролцогчдын тодорхой төлөөллийг санамсаргүй түүврийн аргаар сонгон, тэдэнд урьдчилан бэлтгэсэн сургалтын агуулга, хөтөлбөрийн хүрээнд мэдээлэл олгож, 2 дахь шатны санал асуулгыг өмнөх асуулгыг өөрчлөхгүйгээр дахин асууж, үр дүнг нэгтгэхэд чиглэгдсэн. Нэмэлт ажлын зорилго нь оролцогчдод ардчиллын талаар олон талт, тэнцвэртэй мэдээлэл өгөх замаар сургалтын өмнөх болон дараах ойлголтын зөрүүг хэмжихэд оршиж байсан.

Асуулгын судалгааг 2018 оны 6 сарын 28-ны өдрөөс 7 сарын 05-ны өдрүүдэд, сургалтыг 2018 оны 10 сарын 26-ны өдөр зохион байгуулж, сургалтын дараа 2 дахь санал асуулгыг авсан. Асуулгын анхдагч санал асуулгад 524 иргэн хамрагдсан ба тэдгээр оролцогчдоос сургалтад хамрагдах сонирхлыг тандан судлахад 304 оролцогч сургалтад хамрагдах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн бөгөөд хоёр дахь шатны санал асуулгын судалгаанд дээрх оролцогчдоос тодорхой тооны төлөөлөл оролцсон. Сургалтанд хамрагдсан оролцогчдод Ардчилал ба “Иргэний тэгш эрх”, Ардчилал ба “Иргэний хяналт”, Ардчилал ба “Иргэний эрх чөлөө” сэдвийн хүрээнд тус бүр сургалт зохион байгуулж, сургалтын төгсгөлд хоёр дахь шатны санал асуулгыг зохион байгуулсан.

Ингээд сургалтанд хамрагдагсдын ардчиллын талаарх ойлголтын түвшний төсөөллийн үнэлгээний дундаж утгыг сургалтын өмнөх болон дараах байдлаар харьцуулан судалж үзэхэд дараах байдалтай байна (хүснэгт 10). Үүнд:

**Хүснэгт 10. Сургалтад хамрагдагсдын төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмуудын талаарх өөрийн ойлголтын төсөөллийн харьцуулалт / сургалтын өмнөх болон дараах байдлаар, дундаж утгаар/**

| 3 үзүүлэлт | 9 үзүүлэлт | Нийт дундаж /1 асуулга/ | Сургалтад оролцогчид | | Зөрүү | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 1 асуулга дундаж | 2 асуулга дундаж | Оролцогч-нийт | 2 асуулга – 1 асуулга |
| **Иргэний эрх чөлөө** | Хувийн эрх чөлөө | 2,82 | 2,72 | 4,11 | -0,10 | 1,39 |
| | Нийтийн эрх | 2,67 | **3,34** | 3,81 | 0,67 | 0,47 |
| | Эрх зүйт төр | 2,53 | 3,36 | 3,17 | 0,83 | -0,19 |
| | **Бүгд** | **2,67** | **3,14** | **3,69** | **0,47** | **0,55** |
| **Иргэний тэгш эрх** | Ил тод байдал | 2,46 | 2,72 | 3,50 | 0,26 | 0,78 |
| | Иргэний оролцоо | 2,69 | 2,94 | 4,11 | 0,25 | 1,17 |
| | Төлөөллийн зарчим | 2,46 | 2,86 | 3,70 | 0,40 | 0,84 |
| | **Бүгд** | **2,54** | **2,84** | **3,77** | **0,31** | **0,93** |
| **Иргэний хяналт** | Тэгш өрсөлдөөн | 2,41 | 3,11 | 3,94 | 0,70 | 0,83 |
| | Эрх мэдлийн хяналт-тэнцвэр | 2,40 | 3,14 | 4,00 | 0,74 | 0,86 |
| | Засаглах чадавх | 2,49 | 3,19 | 3,89 | 0,71 | 0,69 |
| | **Бүгд** | **2,43** | **3,15** | **3,94** | **0,72** | **0,80** |
| **НИЙТ** | | **2,55** | **3,04** | **3,80** | **0,50** | **0,76** |

Эх сурвалж: SPSS "23.0" программын тооцооллын үр дүн

Дээрх тооцооллоос дүгнэж авч үзвэл сургалтанд хамрагдагсдын анхны санал асуулгад өгсөн ойлголтын талаарх хариултын дундаж утга нь анхны санал асуулгад оролцсон нийт оролцогчдын дундаж утгаас их байна. /Өөрчлөлтийн хэлбэлзэл: -0,1-ээс +0,83/ Өөрөөр хэлбэл нийт оролцогчдын дундаж утгатай харьцуулахад ардчиллын талаарх ойлголт сайтай гэж үзсэн оролцогчид сургалтанд хамрагдахаар иржээ. Эндээс дүгнэж үзвэл танин мэдэхүй болон боловсролын түвшнээс хамаарч иргэдийн бодит оролцоо сайжирдаг байна гэсэн дүгнэлт нь Роберт Далийн 1971 оны бүтээл "Полирхи" ардчиллын үзэл санааг илэрхийлж байна.

Сургалтын дараа оролцогчид өөрийн ойлголтын түвшингээ дээшилсэн гэж үзсэн байна. /Өөрчлөлтийн хэлбэлзэл: -0,19-ээс +1,39/ Учир нь сургалтад хамрагдсан оролцогчдын ерөнхий дундаж утга нь сургалтын өмнө 3.04 байсан бол сургалтын дараа 3.80 болж дээшилсэн байна (Тооцооллын дэлгэрэнгүй үр дүнг хавсралт 5-д хавсаргав).

Сургалтад хамрагдагсдын ардчиллын хэрэгжилтийн түвшний талаарх төсөөллийн үнэлгээний дундаж утгыг сургалтын өмнөх болон дараах байдлаар харьцуулан гаргаж үзүүлэв (хүснэгт 11). Үүнд:

**Хүснэгт 11. Сургалтад хамрагдагсдын төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмуудын хэрэгжилтийн өнөөгийн байдлын талаарх ойлголтын төсөөллийн харьцуулалт /сургалтын өмнөх болон дараах байдлаар, дундаж утгаар/**

| 3 үзүүлэлт | 9 үзүүлэлт | Нийт дундаж /1 асуулга/ | Сургалтад оролцогчид | | Зөрүү | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | 1 асуулга дундаж | 2 асуулга дундаж | Оролцогч-нийт | 2 асуулга – 1 асуулга |
| **Иргэний эрх чөлөө** | Хувийн эрх чөлөө | 2,40 | 2,72 | 4,20 | 0,32 | 1,48 |
| | Нийтийн эрх | 2,71 | 2,33 | 4,20 | -0,37 | 1,87 |
| | Эрх зүйт төр | 2,12 | 1,75 | 3,40 | -0,37 | 1,65 |
| | **Бүгд** | **2,41** | **2,27** | **3,93** | **-0,14** | **1,66** |
| **Иргэний тэгш эрх** | Ил тод байдал | 2,11 | 1,50 | 3,80 | -0,61 | 2,30 |
| | Иргэний оролцоо | 2,79 | 2,80 | 3,70 | 0,01 | 0,90 |
| | Төлөөллийн зарчим | 2,36 | 2,00 | 3,10 | -0,36 | 1,10 |
| | **Бүгд** | **2,42** | **2,10** | **3,53** | **-0,32** | **1,43** |
| **Иргэний хяналт** | Тэгш өрсөлдөөн | 2,68 | 3,17 | 3,40 | 0,48 | 0,23 |
| | Эрх мэдлийн хяналт-тэнцвэр | 2,30 | 2,75 | 3,60 | 0,45 | 0,85 |
| | Засаглах чадавх | 2,38 | 2,67 | 3,20 | 0,29 | 0,53 |
| | **Бүгд** | **2,46** | **2,86** | **3,40** | **0,41** | **0,54** |
| **НИЙТ** | | **2,43** | **2,41** | **3,62** | **-0,02** | **1,21** |

Эх сурвалж: SPSS "23.0" программын тооцооллын үр дүн

Дээрх тооцооллоос дүгнэж үзэхэд сургалтанд оролцогчдын 1 дэх удаагийн асуулгын хувьд ардчиллын зарчмуудын хэрэгжилтийн талаарх төсөөллийн үнэлгээний дундаж утга нь нийт оролцогчдын дундаж утгаас бага байна. /Нийт дунджаас 0,02-оор бага/ Өөрөөр хэлбэл нийт оролцогчдын дундаж утгатай харьцуулахад хэрэгжилтийн үр дүнг муугаар үнэлж байсан оролцогчид сургалтанд хамрагдахаар иржээ.

Сургалтын дараа оролцогчдын төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмуудын хэрэгжилтийн талаарх төсөөллийн үнэлгээ нь сургалтын өмнөх үнэлгээнээс дээшилсэн байна. /Өөрчлөлтийн хэлбэлзэл: +0,23-аас +2,3/ Учир нь сургалтад хамрагдсан оролцогчдын ерөнхий дундаж утга нь сургалтын өмнө 2.41 байсан бол сургалтын дараа 3.62 болж дээшилсэн байна (Тооцооллын дэлгэрэнгүй үр дүнг хавсралт 6-д хавсаргав).

Сургалтанд хамрагдагсдын төрийн байгуулал дахь институцийн үйл ажиллагааны хэрэгжилтийн талаарх төсөөллийн үнэлгээний дундаж утгыг сургалтын өмнөх болон дараах байдлаар харьцуулан гаргаж үзэхэд дараах байдалтай байна (хүснэгт 12). Үүнд:

Сургалтанд хамрагдсан оролцогчдын 1 дэх удаагийн асуулгын хувьд институцийн үйл ажиллагааны хэрэгжилтийн талаарх төсөөллийн үнэлгээний

дундаж утга нь нийт оролцогчдын дундаж утгаас их байна. /Нийт дунджаас 0,35-аар их/ Өөрөөр хэлбэл нийт оролцогчдын дундаж утгатай харьцуулахад институцийн үйл ажиллагааны үр дүнг сайнаар үнэлж байсан оролцогчид сургалтанд хамрагдахаар иржээ.

**Хүснэгт 12. Сургалтад хамрагдагсдын төрийн байгууллагуудын үйл ажиллагааны хэрэгжилтийн өнөөгийн байдлын талаарх ойлголтын төсөөллийн харьцуулалт /сургалтын өмнөх болон дараах байдлаар, дундаж утгаар/**

| Байгууллага | Нийт дундаж /1 асуулга/ | Сургалтад оролцогчид | | Зөрүү | |
|---|---|---|---|---|---|
| | | 1 асуулга дундаж | 2 асуулга дундаж | Оролцогч-нийт | 2 асуулга – 1 асуулга |
| Улсын Их Хурал | 2,140 | 2,00 | 3,00 | -0,14 | 1,00 |
| Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал | 2,394 | 2,00 | 2,80 | -0,39 | 0,80 |
| Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал | 2,449 | 2,33 | 4,20 | -0,12 | 1,87 |
| Ерөнхийлөгчийн институц | 2,595 | 3,83 | 3,20 | 1,24 | -0,63 |
| Улс төрийн намууд | 2,135 | 2,17 | 3,20 | 0,03 | 1,03 |
| Үндсэн хуулийн цэц | 2,241 | 3,17 | 2,80 | 0,93 | -0,37 |
| Шүүх | 2,142 | 2,00 | 3,00 | -0,14 | 1,00 |
| Прокурор | 2,192 | 2,00 | 3,00 | -0,19 | 1,00 |
| Засгийн газар /Ерөнхий сайд, Засгийн газар, яам, агентлаг/ | 2,451 | 3,00 | 3,20 | 0,55 | 0,20 |
| Нийслэлийн захиргааны байгууллага | 2,516 | 3,00 | 3,20 | 0,48 | 0,20 |
| Дүүргийн захиргааны байгууллага | 2,646 | 4,17 | 3,20 | 1,52 | -0,97 |
| **Дундаж** | **2,35** | **2,70** | **3,16** | **0,34** | **0,47** |

Эх сурвалж: SPSS "23.0" программын тооцооллын үр дүн

Сургалтын дараа төрийн байгуулал дахь институцийн үйл ажиллагааны хэрэгжилтийн талаарх төсөөллийн үнэлгээ нь сургалтын өмнөх үнэлгээнээс дээшилсэн байна. /Өөрчлөлтийн хэлбэлзэл: -0,97-оос +1,87/ Учир нь сургалтад хамрагдсан оролцогчдын ерөнхий дундаж утга нь сургалтын өмнө 2.70 байсан бол сургалтын дараа 3.16 болж дээшилсэн байна (Тооцооллын дэлгэрэнгүй үр дүнг хавсралт 7-д хавсаргав).

Сургалтад хамрагдсан оролцогчдын сургалтын өмнөх болон дараах ойлголтын түвшин ба хэрэгжилтийн талаарх төсөөллийн үнэлгээний зөрүүг 9 дэд үзүүлэлтээр ангилан зургаар үзүүлбэл дараах байдалтай байна (зураг 23). Сургалтад хамрагдагсдын ардчиллын ойлголтын талаарх, хэрэгжилтийн талаарх төсөөллийн үнэлгээ, төрийн байгуулал дахь институцийн үйл ажиллагааны хэрэгжилтийн талаарх төсөөллийн үнэлгээний аль аль нь сургалтын дараа эерэг талруу хүчтэй хэлбэлзсэн байна.

Иргэдийн ойлголтын түвшний сургалтын дараах эерэг өөрчлөлтийг сургалтын агуулга, заах арга зүй, зохион байгуулалтаас хамаарч бий болсон гэж дүгнэж болох хэдий ч иргэдийн ойлголт өөрчлөгдсөнийг үгүйсгэж болохгүй юм. Түүнээс гадна хэрэгжилтийн талаарх төсөөллийн үнэлгээ болон төрийн институцийн үйл ажиллагааны хэрэгжилтийн талаарх төсөөллийн үнэлгээний сургалтын дараах эерэг өөрчлөлтүүд нь анхаарал татаж байна.

**Зураг 23. Сургалтанд хамрагдагсдын ардчиллын талаарх ойлголтын түвшин, хэрэгжилтийн талаарх төсөөллийн үнэлгээний харьцуулалт (сургалтын өмнөх болон дараах байдлаар, дундаж утгаар)**




Эх сурвалж: SPSS "23.0" программын тооцооллын үр дүн

Тайлбар:

IF - Хувийн эрх чөлөө, RS -Эрх зүйт төр, OF -Нийтийн эрх, WE - Тэгш өрсөлдөөн, GK - Эрх мэдлийн хяналт-тэнцвэр, RF - Засаглах чадамж, TR - Ил тод байдал, PA - Иргэний оролцоо, RE - Төлөөллийн зарчим

Эерэг өөрчлөлтийг шууд утгаар нь ойлгож тайлбарлана гэвэл сургалтад хамрагдсан оролцогчид төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмуудын талаар ойлголттой болсны дараагаар хэрэгжилтийн түвшин болон төрийн байгуулал дахь институцийн үйл ажиллагааг өмнө нь буруу дүгнэж байснаа олж харж алдаагаа зассан гэсэн гаргалгаа руу хөтөлж байна. Эндээс олон улсын судлаачдын нэгдсэн (Роберт Даль, Леонардо Морлино, Марк Бульманн нарын) дүгнэлт болох ардчилсан тогтолцоо дангаар ардчиллыг чанаржуулахгүй зөвхөн иргэдийн ойлголтын чанар нь ардчиллын цөм гэсэн үзэл санаа илэрч байна.

# 5. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Монголын ард түмэн 1992 онд "хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм" цогцлуулан хөгжүүлэх эрхэм зорилго дэвшүүлэн "Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ" (Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 1 дүгээр заалт), "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" (Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дугаар заалт) хэмээн суурь зарчмаа тодорхойлж төлөөллийн ардчиллыг хөгжүүлэх зорилтыг дэвшүүлсэн.

Гэвч төлөөллийн ардчилал манай улсын хэмжээнд төдийгүй дэлхий дахинд томоохон сорилтуудтай тулгарч, бий болсон хүндрэлтэй нөхцөл байдлаас гарах арга замыг онол, практикийн түвшинд судлан тодорхойлохоор улс орнууд идэвхтэй ажиллаж байна. Онол, практикийн энэхүү эрэл хайгуулын хүрээнд Freedom House, НҮБХХ, Amnesty International, Дэлхийн банк, IDEA болон Роберт Даль, Леонардо Морлино, Марк Бульманн зэрэг олон байгууллага, судлаачид тодорхой үзэл баримтлал, арга, аргачлалыг боловсруулсан байдаг.

Олон улсын түвшинд судлаачид ардчиллын хэрэгжилт тухайн төрийн байгууллын тогтолцооны асуудал хэмээн үзэж, төлөөллийн болон шууд ардчиллын институцийг судалгааны асуудал болгон авч үзэж байхад зарим судлаачид төрийн байгууллын тогтолцооноос үл хамаарч, ардчиллын хэрэгжилтийг гагцхүү иргэдийн тэгш оролцоотой байх болон улс төрийн шийдвэр иргэдийн хяналттай байхаас хамааралтай гэсэн үзэл санааг 1970 оноос дэвшүүлж эхэлсэн байдаг. Ийм чиглэлийн үзэл баримтлалын томоохон судлаачид /Р.Даль, Л.Морлино, Марк Бульманн/ төлөөллийн байгууллага болох парламентын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын үндсэн зарчим нь "иргэний эрх чөлөө, тэгш эрх, иргэний хяналттай" байх нөхцөлийг бүрдүүлж чадаж байна уу гэсэн асуултыг судалгааны цөм асуудал болгон авч үздэг. Энэ арга зүйг үндэс болгосон судалгаанууд нь ардчилсан дэглэмтэй байна уу гэхээс илүүтэй ардчиллын үндсэн агуулга болох "иргэний эрх чөлөө" баталгаажсан эсэх, "иргэний тэгш эрх" нийгмийн харилцаанд хуулиар тодорхойлогдсон эсэх, мөн улс төрийн шийдвэр "иргэдийн бодит оролцоотой" байгаа эсэх, улс төрийн гарсан шийдвэр "иргэдийн хяналттай" байгаа эсэх гэсэн асуудлыг голчлон анхаардаг.

Нөгөө талаас дээрх үзэл баримтлалын хүрээнд хийгдсэн судалгаануудаас гаргасан нэг гол дүгнэлт нь ардчиллын хэрэгжилтийн үр дүн, иргэдийн ойлголтын түвшинтэй хамааралтай байгааг тогтоосонд оршиж байна. Өөрөөр хэлбэл иргэдийн ардчиллын мөн чанарыг ойлгож, ухамсарласан байдал нь ардчиллын хөгжилд тэргүүлэх ач холбогдолтой гэсэн санаа юм.

Иймд Удирдлагын академийн захиалгат судалгааны баг дээрх үзэл баримтлалд тулгуурлан Л.Морлиногийн ардчиллын чанарын үнэлгээ, Freedom House-ийн ардчиллын индексийн зарчим, жишиг стандартыг харгалзан Марк Бульманны ардчиллын барометрийн арга зүй, аргачиллыг үндэслэн Монгол улс дахь төлөөллийн ардчиллын үзэл баримтлалын суурь зарчим, тэдгээрийг эрх зүйгээр тодорхойлсон байдал болон ардчиллын эрх зүйн суурь зарчмуудын хэрэгжилтийн талаарх үнэлгээг иргэдийн ойлголт, төсөөллөөр тодорхойлох зорилготойгоор энэхүү судалгааг хийж гүйцэтгэсэн болно.

Энэхүү зорилгын хүрээнд дараах судалгааны асуултыг боловсруулан ажилласан. Үүнд:

1. Монгол Улс төрийн байгуулалд "иргэний эрх чөлөө, хяналт, тэгш эрх"-ийн зарчмыг хэрхэн хуульчилсан байна вэ?
2. Төрийн байгуулал дахь институцийн үйл ажиллагаанд "иргэний эрх чөлөө, хяналт, тэгш эрх"-ийн зарчмыг хэрхэн уялдуулсан байна вэ?
3. 1992 оноос хойш Монгол Улсын иргэд "иргэний эрх чөлөө, хяналт, тэгш эрх"-ийн зарчмыг төлөөллийн ардчилалд хэрхэн ойлгож ирсэн бэ?

Монгол Улс дахь төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмууд, тэдгээрийн хэрэгжилтийг тодорхойлохдоо "Ардчилал"-ын эрх зүйн суурь зарчмууд болох "иргэний эрх чөлөө", "иргэний хяналт", "иргэний тэгш эрх" гэсэн дэд үзүүлэлтийг тодорхойлж, 3-н үзүүлэлт бүрийг хэмжих 9 нэгж, үүнийг цааш нь 19 дэд үзүүлэлтэд задалж, эдгээр үзүүлэлт бүрээр нэгдүгээрт, эрх зүйн баримт бичигт контент шинжилгээ хийж, хоёрдугаарт, Монгол Улс дахь төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмуудын талаарх иргэдийн ойлголт, хэрэгжилтийн байдлын талаарх төсөөллийн үнэлгээг социологийн асуулгын аргаар судлан үзсэн болно.

Судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэж дараах байдлаар тодорхойлов. Үүнд:

- Монгол Улсын төрийн байгуулалд "Төлөөллийн ардчилал"-ын тухай суурь үзэл баримтлал хэрхэн хуульчлагдсан байдлыг гурван зарчмын дагуу шалгуур үзүүлэлт бүрээр нь дескриптив шинжилгээ хийхэд Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд ойлголт бүр нь шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон ба агуулга нь либерал ардчиллын үзэл баримтлал, онолын дагуу хуульчилагдсан байна.
- Төрийн байгууллын институцийн үйл ажиллагаанд "иргэний эрх чөлөө", "иргэний хяналт", "иргэний тэгш эрх" гэсэн 3 үзүүлэлт болон түүнийг цааш 9 болон 19 дэд үзүүлэлтэд задалж, тус бүрийг уялдуулсан

байдалд дескриптив шинжилгээ хийхэд "Төр-иргэний харилцаа" шууд хамааралтай, хоёр замын урсгал байхаар Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 1 дүгээр заалтад тусгалаа олсон ба төрийн үйл ажиллагааны зарчим нь "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх" гэж тодорхойлсон байна. Төрийн үйл ажиллагаа нь иргэний шууд оролцоотой, хяналттай байх тухай асуудлыг 2015 оны "Хууль тогтоомжийн тухай хууль"-ийн үзэл баримтлалаар сайжруулж, 2015 оны "Нийтийн сонсголын тухай хууль"-ийн нийтлэг зарчмаар "Төр-иргэний харилцаанд" иргэн тэгш оролцоотой, хяналттай байх нөхцөлийг хуульчилсан байна.

- Иргэд "иргэний эрх чөлөө, хяналт, тэгш эрх"-ийн зарчмыг 1992 оноос эхлэн төлөөллийн ардчиллын хүрээнд хэрхэн тодорхойлсон болохыг Үндсэн хууль, Сонгуулийн тухай хууль, Иргэний хуулийн танин мэдэхүйн түвшнээр судлан үзэхэд 60 хувь (дундаж утга 3.19) нь Үндсэн хуулийн талаарх, 55.5 хувь (дундаж утга 3.24) нь Сонгуулийн тухай хуулийн талаарх, 57.9 хувь (дундаж утга 3.22) нь Иргэний хуулийн талаарх мэдлэгийн түвшнээ дунд зэрэг болон түүнээс дээш гэж үнэлж байна.
- Иргэдийн ойлголтоор Монгол Улс дахь төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмууд тэдний амьдралд эерэг нөлөө үзүүлж байгаа боловч тэдгээрийн хэрэгжилт бодит амьдрал дээр муу гэж үзэж байна.
- Судалгаанд оролцогчдын төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмуудын талаарх ойлголтыг 3, 9 үзүүлэлтээр ангилан авч үзэхэд үзүүлэлтүүд хоорондоо харьцангуй жигд боловч ерөнхий дунджаас доогуур түвшинд байна. Үзүүлэлтүүдийг дундаж утгаар эрэмбэлэхэд дараах байдалтай байна. Үүнд:
    - o Гурван дэд үзүүлэлтийн хувьд "иргэний эрх чөлөө" нэгдүгээрт [2.67], "иргэний тэгш эрх"хоёрдугаарт [2.54], "иргэний хяналт" гуравдугаарт [2.43] эрэмбэлэгдэж байна.
    - o Есөн дэд үзүүлэлтийн хувьд "Хувийн эрх чөлөө" 1 дүгээрт, "Иргэний оролцоо" 2 дугаарт, "Нийтийн эрх" 3 дугаарт, "Эрх зүйт төр" 4 дүгээрт, "Засаглах чадамж" 5 дугаарт, "Ил тод байдал" 6 дугаарт, "Төлөөллийн зарчим" 7 дугаарт, "Тэгш өрсөлдөөн" 8 дугаарт, "Эрх мэдлийн хяналт-тэнцвэр" 9 дүгээрт эрэмбэлэгдэж байна.
- Судалгаанд оролцогчдын төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмуудын хэрэгжилтийн түвшний талаарх төсөөллийн үнэлгээг 3, 9 үзүүлэлтээр ангилан авч үзэхэд үзүүлэлтүүд хоорондоо харьцангуй жигд тэнцвэртэй, ерөнхий дунджаас доогуур түвшинд байна. Үзүүлэлтүүдийг дундаж утгаар эрэмбэлэхэд дараах байдалтай байна. Үүнд:
    - o Гурван дэд үзүүлэлтийн хувьд "иргэний хяналт"нэгдүгээрт [2.46], "иргэний тэгш эрх" хоёрдугаарт [2.42], "иргэний эрх чөлөө" гуравдугаарт [2.41] эрэмбэлэгдэж байна.

- o Есөн дэд үзүүлэлтийн хувьд "Иргэний оролцоо" 1 дүгээрт, "Нийтийн эрх" 2 дугаарт, "Тэгш өрсөлдөөн" 3 дугаарт, "Төлөөллийн зарчим" 4 дүгээрт, "Засаглах чадамж" 5 дугаарт, "Төлөөллийн зарчим" 6 дугаарт, "Эрх мэдлийн хяналт-тэнцвэр" 7 дугаарт, "Эрх зүйт төр" 8 дугаарт, "Ил тод байдал" 9 дүгээрт эрэмбэлэгдэж байна.

- Төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмуудын талаарх ойлголтын түвшний үнэлгээ болон тэдгээрийн хэрэгжилтийн талаарх төсөөллийн үнэлгээний дундаж утгыг 3, 9 дэд үзүүлэлтээр харьцуулан үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:
  - o Гурван дэд үзүүлэлтийн хувьд ойлголтын түвшний үнэлгээ болон хэрэгжилтийн түвшний үнэлгээний эрэмбэ урвуу хамааралтай, "иргэний хяналт"-ын хэрэгжилтийн түвшний дундаж утга ойлголтын түвшний дундаж утгаас өссөн.
  - o Есөн дэд үзүүлэлтийн хувьд "нийтийн эрх", "иргэдийн оролцоо", "тэгш өрсөлдөөн" гэсэн үзүүлэлтүүдийн хувьд хэрэгжилтийн түвшний дундаж утга ойлголтын түвшний дундаж утгаас өссөн.

- Судалгаанд оролцогчдын төрийн байгуулал дахь институцийн үйл ажиллагааны хэрэгжилтийн талаарх төсөөллийг 11 байгууллагын хүрээнд дундаж утгыг эрэмбэлж үзэхэд дүүргийн захиргааны байгууллага 1 дүгээрт, Ерөнхийлөгчийн институц 2 дугаарт, нийслэлийн захиргааны байгууллага 3 дугаарт, Засгийн газар 4 дүгээрт, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 5 дугаарт, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 6 дугаарт, Үндсэн хуулийн цэц 7 дугаарт, прокурор 8 дугаар, шүүх 9 дүгээрт, Улсын Их Хурал 10 дугаарт, улс төрийн намууд 11 дүгээрт эрэмбэлэгдэж байна. Энэхүү судалгааны хүрээнд төрийн байгуулал дахь институцуудын хоорондын хамаарлыг судалж үзээгүй боловч дээрх дундаж утга, түүний эрэмбээс нэгтгэн дүгнэж, төрийн байгуулал дахь институцуудын үйл ажиллагаа хоорондоо хамааралтай гэж үзвэл улс төрийн намуудын үйл ажиллагаа УИХ-ын үйл ажиллагаанд нөлөөлсөн; УИХ-ын үйл ажиллагаанаас бусад институцуудын үйл ажиллагаа хамаарсан; "Ардчилал"-ын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах үүрэгтэй шүүх, прокурор, ҮХЦ-ийн үйл ажиллагаа хангалтгүй байгаа нь төрийн байгуулал дахь институцийн үйл ажиллагааны хэрэгжилт бүхэлдээ хангалтгүй байхад нөлөөлсөн; нутгийн захиргааны байгууллага нь гүйцэтгэх чиг үүргийг хэрэгжүүлдэг, иргэдтэй тулж ажилладаг гэдэг утгаараа бусад институцтэй харьцуулахад харьцангүй өндөр үнэлгээ авсан зэрэг Монголын нийгэмд үүсээд байгаа бодит байдлын ерөнхий дүр зургийг иргэд ойлгож харж байгааг тодруулж байна. Энэ үр дүн нь нэг талаас сонирхолтой боловч, нөгөө талаас

цаашид дэлгэрүүлэн судлах шаардлагатай анхаарал татсан нийгмийн асуудал гэдгийг тодруулж байна.

- Бульманны аргачлалаар судалгаа хийгдсэн улс орнуудын хувьд есөн дэд үзүүлэлтийн дундаж утга харьцангуй ялгаатай ба зарим үзүүлэлт 100 хувь рүү нилээд дөхсөн байгаа бол Монгол улсын хувьд харьцангуй жигд, дунджаас доогуур утгатай боловч 2.5-тай ойролцоо түвшинд байна. Өөрөөр хэлбэл ардчилал нь ард түмний засаглал байхын тулд иргэдийн эрх чөлөөг хамгаалж, оролцоог бүрдүүлж, хяналттай байх нөхцөлийг төр хангах үүрэгтэй гэсэн үзэл санааг энд тодруулж байна.
- Судалгааны багийн гишүүд судалгааны арга зүйг боловсруулахдаа асуулга судалгааны хүрээнд судалгаанд оролцогчдод төлөөллийн ардчиллын эрх зүйн суурь зарчмуудын талаар тэнцвэртэй мэдээллийг хүргэж асуулга судалгааг дахин авахад үр дүн нь хэрхэн өөрчлөгдөх вэ? гэдэгт хариулт авах үүднээс нэмэлт ажлыг төлөвлөсөн. Энэхүү нэмэлт ажил нь судалгаанд хамрагдсан оролцогчдын тодорхой төлөөллийг санамсаргүй түүврийн аргаар сонгон, тэдэнд урьдчилан бэлтгэсэн сургалтын агуулга, хөтөлбөрийн хүрээнд мэдээлэл олгож, 2 дахь шатны санал асуулгыг өмнөх асуулгыг өөрчлөхгүйгээр дахин асууж, үр дүнг нэгтгэхэд чиглэгдсэн. Нэмэлт ажлын зорилго нь оролцогчдод ардчиллын талаар олон талт, тэнцвэртэй мэдээлэл өгөх замаар сургалтын өмнөх болон дараах ойлголтын зөрүүг хэмжихэд оршиж байсан. Ингээд 2 шатлалт судалгааг авахад дараах дүр зураг гарч байна. Үүнд:
